7	31200	1.1.1.02 Банкинд байгаа бэлэн мөнгө	1,268,001,022.4	4,896,785,665.3	1,651,439,922.2	4,723,985,050.1	5,250,967,352.5	7,291,529,459.4
8	31210	1.1.1.02.01 Төгрөг	1,197,469,450.3	4,177,995,755.8	1,287,688,230.5	2,801,618,148.2	5,250,967,352.5	4,216,089,384.2
9	31211	1.1.1.02.01.01 Төрийн сангийн харилцах	957,887,885.4	3,011,242,987.6	1,279,749,548.4	206,135,435.8	5,250,967,352.5	204,048,504.8
10	31212	1.1.1.02.01.02 Монгол банкин дахь харилцах	0	12,377,889.5	2,699,687.4	769,279,853.8	0.0	784,357,430.7
11	31213	1.1.1.02.01.03 Арилжааны банк дахь харилцах	239,581,564.9	1,154,374,878.7	5,238,994.6	1,826,202,858.6	0.0	3,227,683,448.7
12	31220	1.1.1.02.02 Гадаад валют	70,531,572.1	718,789,909.5	363,751,691.7	1,922,366,901.9	0.0	3,075,440,075.3
13	31221	1.1.1.02.02.01 Төрийн сангийн харилцах	26,202,050.5	130,421,492.3	0	0	0.0	156,623,542.8
14	31222	1.1.1.02.02.02 Монгол банк дахь харилцах	0	572,298,858	357,925,599.9	67,062,216.6	0.0	997,286,674.5
15	31223	1.1.1.02.02.03 Арилжааны банк дахь харилцах	44,329,521.7	16,069,559.2	5,826,091.8	1,855,304,685.3	0.0	1,921,529,858
16	31400	1.1.1.03 Замд яваа мөнгөн хөрөнгө	31,879.6	0	57,669,478.8	836,345.5	0.0	58,537,703.8
17	31500	1.1.1.04 Хадгаламж	1,360,000	5,667,004,896.7	1,567,408,000	1,286,972,192.4	0.0	8,522,745,089.1

## Тодруулга №36 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг байгууллагаар нь харуулбал:

/мянган төгрөгөөр/

№	Байгууллага /Шатлал 2, ТЭЗ, Шатлал 1/-ын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Архангай	13,004,026.5	3,334,683
2	Баян-Өлгий	8,327,583.4	4,104,772.6
3	Баянхонгор	15,323,510	5,269,054
4	Булган	10,397,131.5	5,871,287
5	Говь-Алтай	9,772,709.6	6,686,815.6
6	Дорноговь	11,190,162.2	10,857,753
7	Дорнод	8,812,474.3	4,444,156.7
8	Дундговь	10,811,543.7	3,985,175.4
9	Завхан	10,015,687.3	5,164,747.3
10	Өвөрхангай	17,848,253.6	11,876,078.4
11	Өмнөговь	396,849,903.1	296,395,970.6
12	Сүхбаатар	13,813,240.9	2,426,918
13	Сэлэнгэ	15,329,297	8,013,308.7
14	Төв	17,115,325.9	7,098,364.3
15	Увс	7,884,766.9	4,650,600
16	Ховд	9,762,691.4	3,523,775.6
17	Хөвсгөл	13,332,817.8	4,887,998.6
18	Хэнтий	15,080,077.8	4,723,209.6
19	Дархан-Уул	7,532,544.1	2,774,653.4
20	Улаанбаатар	2,167,092,110	1,821,014,652
21	Орхон	5,950,424.2	6,648,355.7
22	Говь сүмбэр	3,083,529.6	849,992.2
23	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	0.0	464,284.5
24	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	214,355.8	319,801.6
25	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	34,190,729.3	40,918,931.9
26	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	1,824,765,578.3	1,088,131,286.2
27	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	9,064,780.2	8,140,656.2
28	САНГИЙН САЙД	1,888,741,868.6	2,472,962,706.5
29	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	14,156,535	13,808,669.1
30	ТӨВ ТӨРИЙН САН	909,710,883.1	435,370,251.2
31	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	24,369,473.6	27,560,389.4
32	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	529.7	20.8
33	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	13,017,533.2	522,456.6
34	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	311,684.9	391,960.8
35	ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	7,362.1	10

36	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	190,990	7,486.6
37	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	21,570.6	100.6
38	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	603,297.5	12,169.7
39	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	97,207.9	3,950
40	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	873,236.8	60,926.2
41	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	72,450.6	0.0
42	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	778,539.5	200,544.9
43	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	2,530,623.7	1,642,371.1
44	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	180,607,129.3	203,347,708.8
45	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	55,001,121.7	50,102,116.1
46	БОЛОВСРОЛЫН САЙД	472,186,340.9	216,591,500.1
47	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	205,326,491.4	153,381,607.3
48	АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД	20,499,116.2	5,923,419.5
49	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	291,216,299.3	289,023,714.1
50	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	75,957,044.4	97,243,530.7
51	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	922,673.4	182,353.7
52	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	1,151,488.2	288,052.6
53	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД, ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	365,049,093.8	1,184,311,073.7
54	ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	15,297,770.4	12,288,822.8
55	МОНГОЛ УЛСЫН САЙД, 20 МИНУТЫН ХОТ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	50,000,000	0.0
56	Эрүүл мэндийн даатгалын сан	55,104,783.6	38,134,532.1
57	Үндэсний баялгийн сан	3,979,427,400.8	5,322,996,561.1

Тэмдэглэл.(Мөнгө, түүнтэй адилтгар хөрөнгөтэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 15,916.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1,370.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,370.6 тэрбум төгрөгөөр өсөхөд төсөл сангийн үлдэгдэл 2,034.3 тэрбум төгрөгөөр, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үлдэгдэл 622.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, төрийн сангийн үлдэгдэл 939.7 тэрбум төгрөгөөр, төсөвт байгууллагын үлдэгдэл 346.0 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Касст байгаа мөнгөн хөрөнгийн 43.1 тэрбум төгрөг буюу 98.7 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн, 0.5 тэрбум төгрөг буюу 1.3 хувь нь төсөвт байгууллагын, 0.02 тэрбум төгрөг нь төсөл сангийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

Банканд байгаа 7,291.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 4,520.2 тэрбум төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн, 417.5 тэрбум төгрөг нь төрийн сангийн, 1,893.2 тэрбум төгрөг нь төсөл сангийн, 460.6 тэрбум төгрөг нь төсөвт байгууллагын үлдэгдэл байна.

Замд яваа 58.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн 98.5 хувь буюу 57.6 тэрбум төгрөг нь төрийн санд, 1.4 хувь буюу 0.8 тэрбум төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн, 0.1 хувь буюу 0.1 тэрбум төгрөг нь төсөвт байгууллагын үлдэгдэл байна.

Хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 8,522.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 6,515.2 тэрбум төгрөгөөр буюу 4.2 дахин өссөн байна.

## 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ

### ӨССӨН БАЙГУУЛЛАГУУД (34)

#### Мэдээлэл харилцаа холбооны зохицуулах хороо (+6,897.4 сая)

Мөнгөн хөрөнгө 6,897,394.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 5G систем ашиглах радио давтамж, радио давтамжийн тусгай зөвшөөрлийн төлбөр тооцооны орлого, арилжааны банкинд байршуулсан хадгаламжийн хүүгийн орлого, бусад орлогоос хамаарсан

#### Дарханы төмөрлөгийн үйлдвэр (+56,406.6 сая)

2024 оны хэрэгжсэн гэрээний дэнчингийн төлбөр 2.0 тэрбум төгрөг Хөрөнгийн биржээр орж ирсэн. Зөвхөн 12 сард хөрөнгийн биржээр төмрийн хүдрийн баяжмалын арилжааны 18 гэрээ хийгдэж гэрээний төлбөр 38 сая доллар орж ирсэн.

#### Шивээ овоо (+6,157.2 сая)

Мөнгөн хөрөнгийн данс нь 9,289.3 сая төгрөгт хүрч өмнөх оноос 6,157.2 сая төгрөгөөр өссөн нь Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцаас 2,461.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр орж ирсэн болон нүүрсний борлуулалтын авлагууд төлөгдөж, төлөвлөсөн зарим зарим зардлууд бүрэн зарцуулагдаагүйгээс шалтгаалсан.

#### Эрдэнэс алт ресурс (+8,094.4 сая)

Борлуулалтын орлого төлөвлөгөө давж биелсэнтэй холбоотой мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэн.

#### Эрдэнэс Монгол (+54,720.7 сая)

Үйл ажиллагааны орлого 13.6 тэрбум төгрөгөөр, хүүгийн орлого 16.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж урсгал зардлыг 32.3 тэрбум төгрөгөөр хэмнэснээр мөнгөн мөрөнгийн үлдэгдлийг нэмэгдүүлэх боломжтой болсон.

#### Эрдэнэт үйлдвэр (+55,087.1 сая)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 91,886.2 сая төгрөг болж, 55,087.1 сая төгрөгөөр өссөн нь арилжааны банк дахь ам.долларын 3 харилцах дансны үлдэгдэл 21,170.2 сая төгрөг, төгрөгийн 5 харилцах дансны үлдэгдэл 32,666.8 сая төгрөг, банкин дах хугацаатай хадгаламж 7,276.0 сая төгрөг, касс дахь бэлэн мөнгө 19.7 сая төгрөг, замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна. Нөгөө талаас үйлдвэрийн газрын экспортын борлуулалтын үндсэн гол бүтээгдэхүүн болох зэсийн үнэ Лондонгийн металлын бирж дээр харьцангуй өндөр байснаар борлуулалтын орлого нэмэгдсэнтэй шууд холбоотой.

#### 10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл /БНСУ зээл/ (+19,564.1 сая)

Төслийн барилга угсралтын 3 багц ажлын ерөнхий гүйцэтгэгч БНСУ-ын “Бьюксан Инженеринг” компани нь БНСУ-ын Сөүл хотын шүүхэд дахин хөрөнгөжүүлэх шүүхийн эрх зүйн зохицуулалт хийлгэх тухай хүсэлт гаргасан. БНСУ-ын “Бьюксан Инженеринг” компанийн шүүхээс томилогдсон бүрэн эрхт төлөөлөгч БУА-ын гэрээг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон талаар мэдэгдсэн. Иймд Төслийн барилга угсралтын ажлын 3 багц Гэрээг цуцлах мэдэгдлийг гүйцэтгэгч компанид хүргүүлж гэрээ цуцлагдсанаар Гүйцэтгэлийн баталгааг нэхэмжлэж 5.5 сая ам.доллар орж ирсэн

#### Монголын хөрөнгийн бирж (+387,376.2 сая)

Мөнгөн хөрөнгө - Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь 3 сарын дотор мөнгөнд хөрвөх чадвартай хөрөнгө байх тул харилцах болон 3 сарын хугацаатай хадгаламжуудыг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд тайлагнав. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлийн 1,192,815,215,717.84 төгрөг нь уул уурхайн бүтээгдэхүүний цахим арилжаанд оролцогчдын арилжааны дэнчинд байршуулсан мөнгө болно.

#### Төрийн банк (+93,364.0 сая)

Касс дах бэлэн мөнгө -3.66 тэрбум төгрөгөөр буурч, Банк дах бэлэн мөнгө - 97.02 тэрбумаар өссөн байна.

#### Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл-ЕХОБ /FI-83097/ (+11,232.2 сая)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 44,305,297.9 мянган төгрөгт хүрч, 11,232,163.1 мянган төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банк болон Европын хөрөнгө оруулалтын банкны зээлийн эх үүсвэрээс 8.01 сая евро буюу 32,629,470.8 мянган төгрөг, тендерийн баримт бичиг худалдсаны орлогоор 6,740.0 мянган төгрөг, валютын ханшийн зөрүүний олз 3,337,697.1 мянган төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлж, урсгал зардалд 1,071,025.6 мянган төгрөгийг, хөрөнгө оруулалтын зардалд 23,670,719.2 мянган төгрөгийг зарцуулсан нь нөлөөлсөн.

#### Үнэт цаасны хадгаламжийн төв (+56,568.5 сая)

2025 оны Аудитын байгууллагын зөвлөмжийн дагуу Бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байсан 34.7 тэр.бум төгрөгийн арилжааны банк дахь хугацаатай хадгаламжийг Мөнгөн хөрөнгө дансанд бүртгэсэн. Мөн "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2024 оны 2,3-р ээлжийн ногдол ашгийн тараагдаагүй үлдэгдлээр мөнгө хөрөнгө өссөн байна.

#### **Хадгаламжийн даатгалын корпораци (+103,177.6 сая)**

ХДК нь өмнөх онд худалдаж авсан гадаад үнэт цааснуудыг борлуулж, хөрөнгө оруулалтын арилжааны гүйлгээтэй холбоотой Монголбанкны дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс өссөн үзүүлэлттэй.

#### **Глобал сан сүрьеэ төсөл (+7,068.1 сая)**

Глобал сангийн удирдах зөвлөлийн хурлаар батлагдсаны дагуу Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн банк (KfW) болон Глобал сан хоорондын 29.0 сая еврогийн "Өр хөрвүүлэх хэлэлцээр"-т Сангийн сайд Б.Жавхлан, ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн банкны Зүүн ба Зүүн Өмнөд Ази бүс хариуцсан Захирал Франк Боне, тус банкны Ерөнхий Портфолио Менежер Андреа Годон, Глобал сангийн Гүйцэтгэх захирал Питер Сандс нар Засгийн газар хоорондын "Өр хөрвүүлэх хэлэлцээр"-т гарын үсэг 2024 оны 12 дугаар сарын 9-ний өдөр зурсан. Улмаар 2025.01.01-нээс эхлэн Глобал сангийн одоо хэрэгжиж байгаа Үндсэн төсөл GS7 -д нэмэлт санхүүжилт хэлбэрээр 2025-2026 онд D2H төсөл хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор мөнгөн санхүүжилтийн дүн өссөн.

#### **Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан (+7,575.0 сая)**

Онцгой албан татварын тухай хуулийн 6.1-д заасны дагуу ногдуулан хураасан татварын орлогын гүйцэтгэлээс татвар ногдсон согтууруулах ундааны литр тутам хамаарах 300 төгрөгийн орлогыг Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих санд тухай бүр төвлөрүүлнэ гэж заасны дагуу жил бүр санхүүжилт төвлөрдөг.

#### **Хил хамгаалах ерөнхий газар (+10,347.1 сая)**

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 12,975,176,47.3 төгрөг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл байна. Үүнээс 2,050,384.7 мянган төгрөг Эрэнцавын шалган нэвтрүүлэх заставын өргөтгөл, хилийн отряд шинээр барих, хилийн цэргийн 0243 дугаар ангийн гадна шугам сүлжээний их засвар, 0306 дугаар ангийн Аглуу, Хавцал булаг, 0130 дугаар ангийн гурван хүүхэд салбарын их засвар, мөн ангийн санхтехнизийн их засвар, 0132 дугаар ангийн Чулуунхудаг салбарын их засвар, 0151 дүгээр ангийн дэд станцын их засвар, 0198 дугаар ангийн Эрс-Уул, 0214 дүгээр ангийн Тэхийн шар нуруу, Өргөстэй, 0245 дугаар ангийн спорт заал, 0285 дугаар ангийн Холбоо нуур, 0243 дугаар ангийн Хүдэр, Цөх, 0285 дугаар ангийн Бор бургас салбаруудын их засварын барьцаа болон хил хамгаалах салбарын тоног төхөөрөмж (улсын хэмжээнд) тоон радио релейн систем, опертив мэдээллийн систем, хяналтын камер, дохиоллын системийн тоног төхөөрөмжийн барьцаа, 10,924,791.7 мянган төгрөг нь санхүүгийн түрээсээр авсан нисдэг тэрэгний үлдэгдэл төлбөрийг 2026 онд төлөх дүнг барьцаа дансанд тус тус байршуулсан.

#### **ШШГЕГ - Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан (+10,818.5 сая)**

Шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийн төвлөрүүлэлттэй холбоотой өссөн.

#### **ШШГЕГ. Шийдвэр гүйцэтгэх газар/төлбөр/ (+25,515.8 сая)**

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн хүрээнд төлбөр авагч төлбөр төлөгчийн хоорондын тооцооноос үүссэн, өссөн.

#### **Иргэний нисэхийн үндэсний төв (+23,107.2 сая)**

Байгууллагын өдөр тутмын тасарлтгүй үйл ажиллагааг ханган, орлогыг нэмэгдүүлэн, хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж зарим зардлыг хэмнэн ажилласан нь дансанд дахь мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн.

#### **Зээлийн батлан даалтын сан (+11,880.4 сая)**

АХБ-эх үүсвэртэй батлан даалтуудын хугацаа дуусч эргэн төлөлт нэмэгдсэн

#### **Таван толгой түлш (+21,256.8 сая)**

Эрдэнэс Тавантолгой ХК-аас санхүүжилтийн гэрээний дагуу 12 сарын 30-ны өдөр 27 тэрбум төгрөгийн санхүүжилт орж ирсэн

#### **Монгол улсын хөгжлийн банк (+819,276.1 сая)**

500 сая долларын бонд гаргаж, эх үүсвэр татсан. Уг эх үүсвэрээс 300 сая долларыг хадгаламжаар байршуулсантай холбоотой.

#### **НДСан - НД Ерөнхий газар (+900,037.2 сая)**

2025 оны жилийн эцэст нэгжүүдээс төвлөрсөн харилцахын үлдэгдлийг татан төвлөрүүлсэн. Хуримтлалын тогтолцоонд шилжих, тэтгэврийн сангийн тогтвортой байдлыг хангах зорилгоор даатгуулагчийн шимтгэлийн тодорхой хэсгийг мөнгөжүүлэн хуримтлуулж, 4 Арилжааны банкуудад хадгаламж байршуулсантай холбоотой байна.

#### **Өм. Гурвантэс. Орлого (+11,688.0 сая)**

2024 татварын хяналт шалгалтаар тавьсан торгуулийн орлого алдангийн хамт 2025 онд төвлөрүүлсэнтэй холбоотой татварын орлого давуулан биелүүлж мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэн байна.

#### **Өм. Орлого (+6,906.8 сая)**

Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу сум, байгууллагуудын хуваарьт санхүүжилтийг дутуу олгосон.

#### **Өм. Ханбогд. Орлого (+20,219.0 сая)**

Оюу толгой ХХК-ны далд уурхайн олборлолтын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор татварын орлогууд нэмэгдсэн

#### **Сэ. Орлого (+10,410.2 сая)**

Орон нутгийн төсвийн орлогод ААНБ-ын орлого давж биелсэн, зарцуулах эрх хязгаарлагдсантай холбогдуулан хөрөнгө оруулалтын зардал болон бусад урсгал зардлууд гараагүй төсвийн гүйцэтгэл 78.2 хувьтай байгаа зэргээс төрийн сангийн үлдэгдэл өндөр дүнтэй харагдаж байна.

#### **Дархан-Уул барьцаа (+8,845.5 сая)**

УТЭШХО -ын гүйцэтгэлийн чанарын баталгааны дансны үлдэгдэл

#### **Геоземи, усны барилга байгууламжийн газар (+9,094.6 сая)**

Сэлбэ голын 5-н шатлалт усан сан барих ажил 2025 онд хийгдэхээр төлөвлөгдсөн хэдий ч зурагт өөрчлөлт орж, зарим газар чөлөөлөлтөнд маргаан гарч газар чөлөөлөлт хийгдэхгүй байгаагаас орж ирсэн санхүүжилтын мөнгө 2025.09.12-нд 9,762,160,472.40 төгрөг зарцуулагдаагүй дансанд байгаа. 2026 онд ажил нь хийгдэхээр зөвшилцөл, чөлөөлөлтийн ажлууд яригдаж байна.

#### **Нийслэлийн орон сууцны корпораци (+18,290.2 сая)**

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/1732 дугаар тоот захирамжаарх Нийслэл дэх төрийн албан хаагчдын төсөл хөтөлбөр хэрэгжсэнтэй холбоотой. Мөн НОСК 1-5 ТЗК ХХК-н авлага төвлөрүүлэх ажлын хэсэг байгуулан 3 сараас дээш авлагын үлдэгдэлтэй харилцагчдын авлагыг барагдуулан ажилласан байна.

#### **Уб. Бз. Орлого (+23,275.9 сая)**

Дүүргийн ерөнхий орлогын дансны мөнгөн хөрөнгийн өсөлт нь дүүргийн хөрөнгийн оруулалтын он дамжин хэрэгжүүлэх ажлын санхүүжилт болох 21,671,036.1 мянган төгрөг, 2025 оны татварын орлогын замд яваа мөнгөн хөрөнгийн өсөлтөөр нэмэгдсэн байна.

#### **Уб. Нийтийн тээврийг хөгжүүлэх сан (+18,558.3 сая)**

600 автобусны элэгдэлийн зардлын суутгалын орлого, Лариско сити медиа ххк-аас Нийтийн тээврийн зогсоолын самбарын түрээсийн төлбөр зэрэг орлого төвлөрснөөр мөнгөн хөрөнгө өссөн

#### **Уб. Чи. Орлого (+14,499.2 сая)**

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын явц гүйцэтгэл болон Ерөнхий сайдын 05 тоот албан даалгаварын хүрээнд хэмнэлт гарч үлдэгдэл өссөн.

#### **Ор. Баян-Өндөр сумын орлого (+20,247.0 сая)**

Оны эцэст төсвийн эрх хязгаарласантай холбоотой хөрөнгө оруулалтын санхүүжилтүүд дутуу олгогдож он дамжсан тул ерөнхий орлогын дансны үлдэгдэл нэмэгдсэн.

#### **Ор. Орлого (+51,115.9 сая)**

Оны эцэст төсвийн эрх хязгаарласантай холбоотой хөрөнгө оруулалтын санхүүжилтүүд дутуу олгогдож он дамжсан тул ерөнхий орлогын дансны үлдэгдэл нэмэгдсэн.

### **БУУРСАН БАЙГУУЛЛАГУУД (127)**

#### **Таван толгой төмөр зам (-30,630.9 сая)**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 21 дүгээр тогтоолын 2 дах заалт, Зам тээврийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 01/1646 дугаартай албан бичгээр Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр замын барилга угсралтын ажлын эхлэлтийн санхүүжилтэд дэмжлэг үзүүлэхээр "Монголын төмөр

зам" ТӨХК-тай 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн СГ-2025/01 тоот гэрээ, 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн СГ/2025/02 тоот гэрээний дагуу санхүүжилт олгосноос шалтгаалж мөнгөн хөрөнгө буурсан

#### **Эрдэнэс оюу толгой (-4,756.1 сая)**

Үндсэн үйл ажиллагааг төсвийн дагуу санхүүжүүлж, барилгын үлдэгдэл төлбөр төлсөн тул мөнгөн хөрөнгө буурсан.

#### **Эрдэнэс таван толгой (-889,350.7 сая)**

1. Мөнгөн хөрөнгийн орох урсгалд нүүрсний үнийн бууралт голлох нөлөө үзүүлсэн. 2. Харин мөнгөн хөрөнгийн гарах урсгалд дараах зарлагууд голлох нөлөөг үзүүлсэн. Үүнд: -Үндэсний баялгийн санд ногдол ашгаас 300.0 тэрбум төгрөгийг урьдчилан шилжүүлсэн. - 2024 оны ногдол ашгаас иргэд, аж ахуйн нэгжид 574.9 тэрбум төгрөг олгосон. - Татварын байгууллагад 1,630.6 тэрбум төгрөгийн татвар төлсөн. - Хөрс хуулалт, олборлолт, тэсэлгээний ажлын хөлсөнд 2,276.5 тэрбум төгрөг шилжүүлсэн. - Тавантолгой төмөр зам ХХК, Тавантолгой түлш ХХК-д 534.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. - НБҮ-ийн тэжээлийн нүүрсний тээврийн конвейер, бутлуур, ачилтын байгууламжийн төлбөрт 244.0 тэрбум төгрөг шилжүүлсэн. - Уулын техник худалдан авахтай холбоотойгоор Хуа еэ компанид 146.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

#### **Дипломат төлөөлөгчийн газар (-1,248.8 сая)**

1. 2024 оны жилийн эцэст Женев дэх ЭСЯ-ны дансанд 2024 оны жилийн эцэст Женев хотод 2025 оны 1 сард болох Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтад оролцох МУ-ын ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ болон төлөөлөгчдийн зардал 2,575.8 сая төгрөг үлдсэн байсныг 2025 оны 1-2 сард төлбөрийг төлж барагдуулсан, 2. 2025 оны 12 сарын 31-ний байдлаар 50 ДТГ-ын дансанд 2,264.2 сая төгрөг үлдэгдэлтэй байсан үүнээс 299.6 сая төгрөг нь Батлан хамгаалах яамны ЗХЖШ-ын 2 албан хаагчийн цалин болон зардлын санхүүжилт, Боловсролын яамны ДТГ-аар дамжуулсан мөнгө болох 114.1 сая төгрөг, бусад нь ДТГ-уудын төсвийн хэмнэлт, орлогын төвлөрүүлээгүй үлдэгдэл байсан байна. Жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 2026 оны 1 болон 2 сарын санхүүжилтээс суутган тооцож, улсын төсөвт төвлөрүүлсэн.

#### **Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл - 3 /4342/ (-6,407.9 сая)**

Ховд сум 18.755 км, Эрдэнэбүрэн сум 19.776 км авто замын санхүүжилт 2024 онд татаад, 2025 онд гарсантай холбогдуулан буурсан

#### **Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл -2 /3679/-ТХН (-2,781.8 сая)**

Өглөгтэй гарын төлбөрийг тайлант онд төлсөн

#### **Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл (-1,212.1 сая)**

АХБ-тай хийсэн гэрээний дагуу төслийн үйл ажиллагаа дуусч төсөл хаагдсан. Иймд ашиглагдаагүй үлдсэн санхүүжилтийг АХБ руу буцаан төвлөрүүлсэн. Хугацаатай хадгаламж болох 4 сая төгрөг үлдсэнийг 2026 оны 5 сард гэрээний хугацаа дуусахаар дансыг хааж үлдэгдлийг төвлөрүүлнэ.

#### **Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ, бэлэн байдлыг хангах төсөл-ТХН (-5,088.2 сая)**

Өмнөх онд орж ирсэн зээлийн ашиглалт мөнгөн хөрөнгөд бүртгэлтэй байснаас 2025 онд зөвлөхийн үйлчилгээ, тоног төхөөрөмжийн гэрээнүүдийн үлдэгдэл төлбөр шилжүүлж, Үлдэгдэл 726 саят төгрөгийг Дэлхийн банкинд буцаан төвлөрүүлсэн.

#### **Монгол Улсын Зүрх Судлал, Зүрхний мэс засал ба Телемедицин (-1,223.1 сая)**

МОН/007 нь 2025 онд батлагдсан жилийн ажлын болон санхүүгийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаануудыг зохион байгуулж, мөнгөн хөрөнгө зарцуулсан.

#### **Монголын үнэт цаасны клирингийн төв (-5,809.6 сая)**

МУ-ын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.2, 62.1.15 дахь заалт, "Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулах, шинэчлэх талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2025 оны 61 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Сангийн сайдын №228-р тушаалын дагуу "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК руу нэгтгэгдэх шийдвэр гарсан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 26-нд бүх харилцагч компаниуд руу барьцаа хөрөнгийг шилжүүлэн үлдсэн мөнгөн хөрөнгийг балансаас баланс руу шилжүүлсэн.

#### **Сангийн яам (-139,227.6 сая)**

2024 оны гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн Монгол талын хөрөнгө оруулалтын ажил дуусаагүйтэй холбогдуулан уг санхүүжилтийг барьцаанд байршуулсан болно. Мөн баталгаат чанарын 5 хувийн барьцаа чөлөөлсөн.

#### **Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл -ТХН (-5,206.3 сая)**

Австрали улсын зээлийн эх үүсвэрээр хэрэгжиж буй төсөл. Өмнөх оны зээлийн ашиглалтийн санхүүжилт мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл тусгасан байсан. Үүний гэрээний дагуу зарцуулсан.

**УБ хотын төлбөрийн чадварт нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл-/3694/ (-4,847.8 сая)**

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 14,217,868,830.32 төгрөг болж, өмнөх оны үлдэгдлээс 4,847,846,445.45 төгрөгөөр буурсан нь тайлант онд гадаадын зээлийн эх үүсвэрээс 29,530,090,093.5 төгрөг, хандив тусламжаар 2,637,250,187 төгрөг, бусад орлогын 14,046,822.92 төгрөгийн эх үүсвэрийг тус тус бүрдүүлж, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз) 654,082,807.5 төгрөг болж, урсгал зардалд 2,827,112,091.8 төгрөг, хөрөнгийн зардалд 34,856,204,264.57 төгрөгийг зарцуулсантай холбоотой.

**УГЕГ - Гаалийн ерөнхий газар (-12,056.2 сая)**

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын дагуу “Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэхээр гэрээ нь хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, санхүүжилт бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдэлийг захиалагчийн барьцаа дансанд байршуулах” гэж заасны дагуу 10,734.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг он дамжуулан 2025 онд санхүүжүүлсэн.

**Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл-ТХН (-5,739.1 сая)**

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,9 тэрбум төгрөгийн бууралт нь 2024 оноос он дамжсан 5А дулааны магистрал шугамын үлдэгдэл 756 сая төгрөг, 2А дулааны магистрал шугамын гуравдугаар үе шатны гүйцэтгэл 1,9 тэрбум төгрөг, 1А шугамын эхний үе шатны гүйцэтгэлийн санхүүжилт 2,2 тэрбум төгрөгийг 2025 оны эхэнд санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

**Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл - нэмэлт-ТХН (-1,841.4 сая)**

АХБ-аас 725,284,760.42 төгрөгийн санхүүжилт авсан ба ТХН-723,710,330.08 болон хөрөнгө оруулалтын зардал-1,933,918,614.43 төгрөгийн зөрүүг урьдчилгаа данснаас төлсөнтэй холбоотой. Гадаад валютын ханшийн олз 90,905,000.27

**Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл-1 (-2,539.6 сая)**

АХБ-аас 2.527,991,860.94 төгрөгийн санхүүжилт авсан ба хөрөнгө оруулалтын зардал-5,230,632,172.01 төгрөг зарцуулсан ба зөрүүг урьдчилгаа данснаас төлсөнтэй холбоотой. Гадаад валютын ханшийн олз 163,010,777.84

**Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах төсөл (-4,423.3 сая)**

Төсөл дуусч хаалт хийсэн. АХБ-ний зээлийн эх үүсвэрээр орж ирсэн санхүүжилтийн үлдэгдэл мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл байсан. Үүнийг хөрөнгө болгон Эрүүл мэндийн яаманд шилжүүлж 3,501 сая төгрөгийн хоорондын тооцоо үүсгэж, үлдэгдэл төлбөр болох 922 сая төгрөгийг АХБ-д буцаан төвлөрүүлсэн

**Гэмтэл, согог судлалын үндэсний төв (-1,520.8 сая)**

ЭМД-аас авах өмнө оны авлагаа бүрэн авсан. Өглөг барагдуулсан

**Улсын гуравдугаар төв эмнэлэг (-2,163.3 сая)**

Тайлант онд цалин нэмэгдсэн, даатгалаас авлагатайгаас мөнгөн хөрөнгө буурсан. Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага буурсан.

**Улсын нэгдүгээр төв эмнэлэг (-2,826.8 сая)**

ЭМС-ын 2025 оны А/05, А/356, А/360 тоот тушаалаар 9.6 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн

**Улсын хоёрдугаар төв эмнэлэг (-2,190.1 сая)**

Оны эцэст ЭМД-аас авах санхүүжилт орж ирсэн, мөн 1-р сарын ажилчдын цалин хөлс олгоход хэрэглэгдэхээр нөөцөлсөн

**Хавдар судлалын үндэсний төв (-4,345.2 сая)**

Бараа үйлчилгээний зардал, үйл ажиллагаанд зарцуулагдсан.

**Халдварт өвчин судлалын үндэсний төв (-1,815.4 сая)**

Бараа үйлчилгээний зардал, үйл ажиллагаанд зарцуулагдсан.

**Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, их засвар (-37,597.1 сая)**

Барьцаа данснаас 13.9 тэрбум төгрөгийн гараагүй гүйцэтгэлийг Сангийн яаманд буцаан төвлөрүүлж, 2024 онд барьцаанд авсан 20.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг шилжүүлж, чанарын баталгааны хугацаа дууссан 4.4 тэрбум төгрөгийг гүйцэтгэгчид олгосон.

**Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (-1,842.9 сая)**

Бараа үйлчилгээний зардал, үйл ажиллагаанд зарцуулагдсан.

**Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэний төв - 2 (-1,005.8 сая)**

Бараа үйлчилгээний зардал, үйл ажиллагаанд зарцуулагдсан.

**Улаанбаатар. МУПЕГазар - Улаанбаатар, Нийслэлийн Прокурорын газар (-1,255.5 сая)**

Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 2025/ЦХШЗ/1269 дугаартай шүүгчийн захирамжаар 3.0 тэрбум төгрөг, 6 дугаар сарын 19-ны өдрийн 2025/ШЗ/1833 дугаартай шүүгчийн захирамжаар 100.0 сая төгрөг, 5 дугаар сарын 28ны өдрийн 1575 дугаар гүйцэтгэх хуудсаар 70.0 сая төгрөг нийт 3,170.0 сая төгрөгийн барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний мөнгийг буцаан шилжүүлсэн. Мөн шүүгчийн захирамж болон прокурорын тогтоолоор 1.9 сая төгрөгийн барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний мөнгийг нэмж байршуулах шийдвэр гарснаар зэргээс үүдэн тус дансны үлдэгдэл буурсан байна.

**Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн - УТҮГ (-58,335.6 сая)**

2024.12.31-нд ЗГ-н тогтоолоор 60 тэрбум төгрөгийн төсөл хөтөлбөрийн санхүүжилт тус байгууллагын Барьцаа хөрөнгийн дансанд орж ирсэн. 2025 онд энэ санхүүжилтээс 20 төсөл арга хэмжээний санхүүжилт болох 6,883,787,200 төгрөгийн санхүүжилтийг олгож, гэрээ байгуулаагүй болон хугацаандаа санхүүжилт олгогдох боломжгүй 12 төсөл арга хэмжээний санхүүжилт 51,451,830,109.41 төгрөгийг улсын төсвийн орлогын дансанд буцаан төвлөрүүлж, чанарын баталгаа, Захиалагчийн хяналтын зардал болон Гүйцэтгэгчид өгөх санхүүжилт болох 1,664,382,690.69 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг (-1,787.1 сая)**

Арилжааны банкны эхний үлдэгдэл 10,000 төгрөг байсныг төрийн сангийн дансанд татсан. Төрийн сангийн урсгал үйл ажиллагааны 100900012007 дугаар дансны эхний үлдэгдэл 1,733,024,251.44 төгрөг байснаас тайлант онд нийт 23,698,123,828.27 төгрөгийн орлого орж, 25,405,013,418.58 төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж оны эцсийн үлдэгдэл 26,134,661.13 төгрөг болсон. Мөн ахмадын сангийн 100900012521 дугаар дансны оны эхний үлдэгдэл 20,914,989.59 төгрөг байснаас тайлант хугацаанд орлого ороогүй, 19,822,000.00 төгрөгийг зарцуулж, жилийн эцэст 1,092,989.59 төгрөгийг татан төвлөрүүлж, авлагаар тусгасан. Мөн хөрөнгө оруулалтын барьцааны 100900012315 дугаар дансны оны эхний үлдэгдэл 152,740,968.15 төгрөг байснаас тайлант хугацаанд 21,588,617.05 төгрөгийн барьцаа хөрөнгө төвлөрүүлж, 80,913,699.30 төгрөгийн барьцааг чөлөөлж жилийн эцэст 93,415,885.90 төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байсан. Нийт тайлант онд 23,719,712,445.32 төгрөгийн орлого орж, 25,506,852,107.47 төгрөгийн зарлага гарсан тул мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл 1,787,139,662.15 төгрөгөөр буурсан байна.

**Хууль зүй, дотоод хэргийн яам /шинэ 2016-08/ (-1,160.6 сая)**

Хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой барьцаа дансны үлдэгдэл буурсан.

**Хууль зүйн үндэсний хүрээлэн (-3,058.3 сая)**

ХЗҮХ-ийн өргөтгөлийн барилга 2024-2025 оны Улсын төсвөөс санхүүжиж баригдаж ашиглалтанд орсон. 2024 оны барилгын санхүүжилтийг олгосон.

**Төрийн орон сууцны корпораци /ТОСК/ (-9,274.2 сая)**

ТОСК нь тайлант онд Хөгжлийн банкнаас авсан ТОСК бондын хүүгийн төлбөрт 9,692.3 сая төгрөг төлсөн нь мөнгөн хөрөнгө буурах гол шалтгаануудын нэг болсон байна.

**Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын хөрөнгө оруулалт, их засвар (-28,923.5 сая)**

ХББОСЯамны хөрөнгө оруулалтын барьцаа данснаас 2025 онд чанарын баталгааны хугацаа дууссан 87 компаний чанарын баталгаа болон хөрөнгө оруулалтын барьцааг чөлөөлсөн.

**БЕГ-Хөрөнгө оруулалт барьцаа (-41,611.6 сая)**

Тайлант онд 8,108,599,000 төгрөгийн барьцаа төвлөрч, 61 төсөл арга хэмжээний 9,898,156,100 төгрөгийн барьцаа хөрөнгийг чөлөөлөн, аудитын актын дагуу 3,209,275,6 төгрөгийг шилжүүлсэн, Засгийн газрын тогтоолын дагуу гүйцэтгэлээр 23,372,540,400 төгрөгийн ажил гүйлгээг хийсэн, 13,240,272,300 төгрөгийг Сангийн яамны улсын төсвийн дансанд төвлөрүүлж үлдэгдэл буурсан байна.

**БСШУСЯ. Барьцаа (-3,335.1 сая)**

Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын чанарын баталгааны төлбөрийг журмын дагуу тоног төхөөрөмж нийлүүлсэн байгууллагад шилжүүлснээр барьцаа дансанд байршсан мөнгөн хөрөнгө буурсан байна. /хэдэн байгууллагад өгсөн талаар/

**Да. Дархан. Сургууль /Оюуны ирээдүй, цогцолбор/ (-1,518.2 сая)**

Гүйцэтгэл үр дүнгээр санхүүждэг байгууллагууд нь хичээлийн жил, санхүүгийн жил зөрдөг тул 2024 оны зарцуулагдаагүй үлдэгдлээс 2025 онд цалин хөлсний зардалд зарцуулснаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан байна.

**Монгол Улсын Их сургууль (-10,651.5 сая)**

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 10.6 тэрбум төгрөгөөр буурсан нь томоохон хөрөнгө оруулалтын төсөл болох хичээлийн ЗБ байрны санхүүжилтэд 6.3 тэрбум төгрөг, ШУТУПаркийн барилгын их засварт 120 сая төгрөг тус тус зарцуулсан. Мөн хүүгийн орлого нэмэгдүүлэх зорилгоор мөнгөн хөрөнгийн чөлөөлт үлдэгдлийн тодорхой хэсэг буюу богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 1.3 тэрбум төгрөгийг үнэт цаас (бонд)-д хөрөнгө оруулсантай тус тус холбоотой.

**Уб. Бг. Сургууль /Эрдмийн ундраа/ (-1,090.7 сая)**

Гүйцэтгэл үр дүнгээр санхүүждэг байгууллагууд нь хичээлийн жил, санхүүгийн жил зөрдөг тул 2024 оны зарцуулагдаагүй үлдэгдлээс 2025 онд цалин хөлсний зардал, тэтгэмж урамшуулал, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулснаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан байна.

**Уб. Бз. Сургууль /14-р/ (-1,057.3 сая)**

Тус сургуулийн 2024 оны 12 сарын 31-ны харилцах данс нь 1,515,208,950,95 төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлан тэнцлийг гаргасан байдаг. Энэ нь төрийн сангийн ажил гүйлгээ хаагдснаас хойш харилцах дансанд хөтөлбөр зориулалтаар санхүүжилт нэмэгдэж орж ирсэн нь үлдэгдлийг өндөр дүнтэйгээр тайлагнасан. 2025 оны 12 сарын 31-ны харилцах данс нь 457,942,066,89 төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнаж байна. Тухайн үлдэгдэл нь хөтөлбөр зориулалт бүрээс болон тус сургуулийн туслах үйл ажиллагааны орлогоос үлдсэн төгрөг болно. /энэ агуулга нь бүрэн биш тайлбар байна/

**Уб. Бз. Сургууль /97-р/ (-1,158.6 сая)**

2024 оны санхүүгийн жилийн эцсийн байдлаарх үлдэгдэл 1,253,350,607.70 төгрөг байсан. Тайлант хугацаанд цалингийн сангийн төсөв хэмнэлттэй хэрэгжиж, урьд оны үлдэгдэл нэмэгдэн шилжин орж ирсэн нь 2025 оны төсвийн санхүүжилтийг бууруулж, санхүүжилт дутуу орсон. Ингэснээр 2025 оны жилийн эцсийн үлдэгдэл 94,706,465.21 төгрөг болж буурсан. /энэ агуулга нь бүрэн биш тайлбар байна/

**Авто тээврийн үндэсний төв (-21,920.3 сая)**

2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр батлагдсан. "Тээвэрчдийн ордны барилга"-ын ажлын төлбөрт 9.6 тэрбум төгрөг, 2024 оны ногдол ашгийн төлбөрт 5.6 тэр бум төгрөг төлсөн. Мөн орлогын төлөвлөгөө тасарсан нь мөнгөн хөрөнгө буурхад нөлөөлсөн.

**Зам, тээврийн хөрөнгө оруулалт, их засвар (-81,354.0 сая)**

Тус яамны Барьцаа баталгаа дансны үлдэгдэл. оны эхэнд 147 байснаа оны эцэст 65 сая болж буурсан.

**МИАТ (-5,621.7 сая)**

Мөнгөн хөрөнгө 29,414.1 сая төгрөгөөс 23,792.4 сая төгрөг болж 5,621.7 сая төгрөгөөр буурсан нь оны эцэст компани эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх 10,000.0 сая төгрөгийн шугамын зээлийг хаасанаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан.

**Монголын төмөр зам (-54,847.8 сая)**

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого 288.5 тэрбум төгрөг, зээл өрийн үнэт цааснаас төвлөрсөн орлого 197.9 тэрбум нийт 486.4 тэрбум төгрөг төвлөрүүлэн бүртгэсэн. Үүнээс үйл ажиллагааны зардалд 231.2 тэрбум төгрөг, Багахангай Хөшгийн хөндийн төслийн гүйцэтгэлд нийт 250.4 тэрбум төгрөг зарцуулсанаас үйл ажиллагааны орлогоос 52.5 тэрбум төгрөг, Сангийн яамны дамжуулан зээлийн хүүгийн өглөгт 17.9 тэрбум төгрөг зарцуулсан нь мөнгөн урсгал огцом буурхад нөлөөлсөн.

**Геологийн судалгаа-шинжилгээний төв ААТҮГ (-3,842.3 сая)**

Байгууллагын үйл ажиллагаанд 3 банкинд төгрөгийн-5, картын данс-1, долларын-1, еврогийн-1, хугацаатай хадгаламжийн-2 нийт 10 харилцах данс ашигладаг.

**Замын-Үүдийн шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж (-4,583.5 сая)**

Монгол улсын засгийн газрын 2025 оны 03 дугаар 19-ний №146 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2025 оны 10 сарын 23-ны №513 тоот тогтоолоор Замын-Үүд дэх "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үл хөдлөх үндсэн хөрөнгө болон бусад эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авах, Монгол улсын засгийн газрын 2025 оны 03 сарын 19-ний №136 дугаар тогтоол, Монгол улсын засгийн газрын 2025 оны 03 сарын 06-ны №116 тоот

тогтоолоор тус тус Замын-Үүдийн шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ нь Эрчис ойл ХХК-д балансаас балансад шилжүүлэн татан буугдсан.

#### **Эрчис ойл (-5,834.8 сая)**

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эхэнд 7,750.2 сая төгрөгөөр оны эцэст 1,915.4 сая төгрөгөөр тус тус тайлагнагдсан нь 5,834.8 сая төгрөгийн бууралттай байна.

#### **Байгаль орчныг хамгаалах, ЖДҮ-ийг хөгжүүлэх 2 үе шаттай зээлийн төсөл (-2,532.5 сая)**

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 13,370,493.5 мянган төгрөг болж 2,532,490.7 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдэл 15,902,984.2 мянган төгрөг дээр 15,830,306.1 мянган төгрөгийн зээлийн үндсэн, 2,643,212.6 мянган төгрөгийн хүүгийн төлбөр болон ханшийн олз 38,069.7 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 395,723.0 төгрөгийн орлого орж ирсэнээс, 13,856,930.0 мянган төгрөгийг 6 банкны 37 аж ахуй нэгжид төслийн зээл олгож, 7,187,099.9 мянган төгрөгийг Жайкад төлөх дамжуулан зээлийн төлбөрийг 2025 оны хуваарийн дагуу Сангийн яаманд шилжүүлж, ургалд зардал 395,678.8 мянган төгрөг зарцуулж, 93.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн шилжүүлсэнээс шалтгаалжээ.

#### **Биокомбинат (-1,598.1 сая)**

2024оны 12 сард МЭЕГын Урьдчилсан захиалга мөнгө орж ирсэн тул мөнгөний үлдэгдэл их гарсан

#### **Мал эмнэлгийн ерөнхий газар (-11,515.9 сая)**

2024 онд ОХУ-аас тендерээр малын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин худалдан авсан төлбөрт төлөгдөх төлбөрийн үлдэгдэл.

#### **Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл (-13,758.3 сая)**

Сангийн яам, ХХААХҮЯ-ны хооронд 2020 онд байгуулсан 200515/01/161/56 тоот Дамжуулан зээлийн гэрээний төлбөрийг 2025 оны жилийн эцсээр Сангийн яаманд урьдчилж төлсөн.

#### **Хүнс хөдөө аж, ахуй, хөнгөн үйлдвэрийн ХО-ИЗ (-6,850.0 сая)**

Засгийн газрын 2023 оны 456, 2024 оны 249 дүгээр тогтоолын хүрээнд байршуулсан 94 төсөл, арга хэмжээний 9,581,610,643.98 төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан. Үүнээс Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 456, 2024 оны 249 дүгээр тогтоолын хүрээнд барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 17 төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлээр 6,496,166,666.0 төгрөгийг олгосон.

#### **Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ (-1,281.2 сая)**

2025 оны жилийн эцсийн байдлаар 1,895.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан ба өмнөх оноос 1,281.2 сая төгрөгөөр буурсан дүнтэй гарсан. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос буурсан нь ЭХЗХ-с 2025 оны 4-р улиралд ДҮТ-с худалдан авах 1 кВт\*ц цахилгааны үнийг 39.08 төгрөгөөр нэмэгдүүлж 308.03 төгрөгөөр тогтоосон, компанинд буцах мөнгөний урсгалийн хувь хэмжээг 9.53 хувиар бууруулж 7.2 хувиар баталсан зэрэг нь шууд нөлөөлсөн.

#### **Дулааны хоёрдугаар цахилгаан станц (-1,110.2 сая)**

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 759.9 сая төгрөг болж, өмнөх оноос 1,110.2 сая төгрөгөөр буурахад Диспетчерийн үндэсийн төв ТӨХК-аас авах авлага өссөн нь нөлөөлсөн байна.

#### **ХНХЯ. Барьцаа (-2,576.8 сая)**

Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолоор байршуулсан 2,236.7 сая төгрөгийг 2025 онд барилга угсралтын ажлын гүйцэтгэлээр санхүүжилт олгосон. Мөн 822.0 сая төгрөгийн чанарын баталгааг чөлөөлсөн байна.

#### **Эдийн засаг, хөгжлийн сайд ХО-ИЗ (-84,641.2 сая)**

Тус мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл Барьцаа хөрөнгө оруулалтын дансны 90,015,053,074.55 төгрөг болон захиалагчийн хяналтын дансны 6,542,115,968.96 төгрөгийн нийлбэр бөгөөд 2025 оны Төсвийн жилд барьцаа хөрөнгийн дансанд орлого аваагүй, харин 82,377,239,704.35 төгрөгийн зарлага гаргасан. Тус зардлын 14 орчим хувийг улсын төсөвт төвлөрүүлж, 85 орчим хувийн санхүүжилтийг Засгийн газрын тогтоолын дагуу гүйцэтгэгч байгууллагад олгосон. Мөн 1 орчим хувийн захиалгчийн хяналтын болон чанарын баталгааг суутгасан. Түүнчлэн захиалагчийн хяналтын дансанд 2025 оны төсвийн жилд 771,320,610.97 төгрөгийг дотоод шилжүүлгээр хяналтын зардлаар орлогодсон бол 3,035,297,595.98 төгрөгийн зардал гаргаж хяналт хэрэгжүүлэгчдэд олгосон. Иймд эцсийн үлдэгдэл эхний үлдэгдлээс харьцангуй багассан.

#### **Мэдээлэл, холбооны сүлжээ ХХК (-1,331.4 сая)**

Авлагын өсөлтөөс шалтгаалан мөнгөн хөрөнгийн нөөц багассан. Нийт мөнгөн хөрөнгөөс аймаг орон нутгийн салбаруудын харилцах данс болон касс-т 405.3 сая төгрөг, УБ хотын салбар нэгжийн харилцах данс болон касс-т 2,653.0 сая төгрөгийн үлдэгдэл байна.

**Архангай. НДСан - Аймаг (-2,013.0 сая)**

2025 оны жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн 8399.8 сая төгрөгийн 8341.4 сая төгрөг нь 99.7 хувь тэтгэврийн даатгалын сан эзэлж байна. Энэ нь дараа сарын 01 -ны өдөр олгох тэтгэврийн санхүүжилт боловч төв сангаас санхүүжилтийг 2026.01.06 -ны өдөр НДЕГ-с санхүүжилт орж ирсэнтэй холбоотой байна.

**Дархан-Уул. НДСан - Аймаг (-4,866.3 сая)**

Төвлөрсөн харилцах 2025.12.31-нд төвлөрүүлэлт бүрэн хийгдсэн болон тэтгэврийн даатгалын сангийн 2026 оны 1-р сарын тэтгэврийн санхүүжилт дутуу орж ирсэн шалтгааны улмаас арилжааны банкны харилцах дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан.

**Дорнод. НДСан - Аймаг (-4,114.3 сая)**

Тэтгэврийн санд дараа сарын 1-ны өдөр олгох тэтгэврийн санхүүжилт дутуу орж банкнаас 6783.2 сая төгрөгийн түр санхүүжилт үүсгэн тэтгэврийг олгосон.

**Завхан. НДСан - Аймаг (-3,350.4 сая)**

Төвлөрсөн харилцах 2025.12.31-нд төвлөрүүлэлт бүрэн хийгдсэн болон тэтгэврийн даатгалын сангийн 2026 оны 1-р сарын тэтгэврийн санхүүжилт дутуу орж ирсэн шалтгааны улмаас арилжааны банкны харилцах дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан.

**Орхон. НДСан - Аймаг (-3,143.4 сая)**

\*Төвлөрсөн харилцах - 2025.12.31-нд төвлөрүүлэлт бүрэн хийгдсэн. \*Тэтгэврийн даатгалын санд 2026.01 дүгээр сарын тэтгэврийн санхүүжилт 2,518,628,544 төгрөгөөр дутуу орж ирсэн.

**Өвөрхангай. НДСан - Аймаг (-3,313.2 сая)**

Тэтгэврийн даатгалын сангийн болон ҮОМШӨД сангийн 2026.01.01 тэтгэврийн санхүүжилт дутуу орж ирсэн.

**Өмнөговь. НДСан - Аймаг (-3,008.1 сая)**

2025 оны жилийн эцэст арилжааны банк гэрээний үүргээ биелүүлж төвлөрсөн харилцахын төвлөрүүлэлтийн гүйлгээ бүрэн хийгдсэнээр жилийн харилцахын үлдэгдэл буурсан.

**Сүхбаатар. НДСан - Аймаг (-1,800.5 сая)**

НДЕГазраас олгодог тэтгэвэр тэтгэмжийн санхүүжилт буурсантай холбоотойгоор харилцах дансны үлдэгдэл буурсан үзүүлэлттэй гарч байна

**Сэлэнгэ. НДСан - Аймаг (-3,870.4 сая)**

2025 онд шимтгэлийн орсон орлогыг тухайн өдрийн 00.00 цагт банк өөрөө автоматаар төв санд төвлөрүүлдэг болсонтой холбоотой байна.

**Төв. НДСан - Аймаг (-1,304.1 сая)**

2025 онд шимтгэлийн орсон орлогыг тухайн өдрийн 00.00 цагт банк өөрөө автоматаар НДЕГ-н төв санд төвлөрүүлдэг болсонтой холбоотой байна.

**Улаанбаатар. НДСан - УБ-Багануур (-1,945.8 сая)**

Арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд: Тэтгэврийн даатгалын санд 2026.01 дүгээр сарын санхүүжилт дутуу орсон тул өмнөх оноос үлдэгдэл 1,547,996,548.45 төгрөгөөр буурсан нь гол нөлөөг үзүүлж байна. Төвлөрсөн харилцахад 2025.12.31-ний өдрийн орлогыг төвлөрүүлсэнээр, үлдсэн дүн нь өмнөх оноос 246,100,802.62-оор буурсан байна..

**Улаанбаатар. НДСан - УБ-Баянгол (-10,780.9 сая)**

Төвлөрсөн харилцахын үлдэгдэл бүрэн төвлөрсөн, тэтгэврийн санхүүжилт дутуу орж ирсэн.

**Улаанбаатар. НДСан - УБ-Сонгинохайрхан (-11,023.3 сая)**

Арилжааны банкны харилцах дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан. Сангийн дансанд дараа сард олгох тэтгэврийн санхүүжилт өмнөх онтой харьцуулахад бага орж ирснээс шалтгаалж тайлант оны дансны үлдэгдэл буурсан.

**Улаанбаатар. НДСан - УБ-Сүхбаатар (-6,559.4 сая)**

Арилжааны банкны харилцах дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан. Сангийн дансанд дараа сард олгох тэтгэврийн санхүүжилт өмнөх онтой харьцуулахад бага орж ирснээс шалтгаалж тайлант оны дансны үлдэгдэл буурсан.

**Улаанбаатар. НДСан - УБ-Хан-Уул (-5,291.1 сая)**

Тэтгэврийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 4,886.1 сая төгрөгөөр буурсан.

**Улаанбаатар. НДСан - УБ-Чингэлтэй (-3,970.3 сая)**

НДЕГазраас олгодог тэтгэвэр тэтгэмжийн санхүүжилт буурсантай холбоотойгоор харилцах дансны үлдэгдэл буурсан үзүүлэлттэй гарч байна

**Ховд. НДСан - Аймаг (-2,014.4 сая)**

Тэтгэврийн санд дараа сарын 1-ны өдөр олгох тэтгэврийн санхүүжилт дутуу орсонтой холбоотой байна.

**Хөвсгөл. НДСан - Аймаг (-3,274.8 сая)**

Тэтгэврийн санд дараа сарын 1-ны өдөр олгох тэтгэврийн санхүүжилт дутуу орсонтой холбоотой байна.

**Хуримтлалын сан (-4,908.8 сая)**

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахьхэсэгт “Хуримтлалын болон Хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанкна дахь төрийн сангийн дансанд байршуулна.

**Ар. Барьцаа (-5,284.3 сая)**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийн үлдэгдлээс улсын төсөвт 1,669,017,114 төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, 2025 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр хэрэгжих барилга угсралт, их засварын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх зардалд 403,523,938 төгрөг, өмнөх онуудад хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын хугацаа дууссан 3,211,768,631.01 төгрөгийн барьцааг чөлөөлснөөр буурсан байна.

**Бх. Баянхонгор. Орлого (-2,142.2 сая)**

Тайлант онд орлого төвлөрүүлэлтээс шалтгаалан мөнгөн хөрөнгийн буурсан байна.

**Бх. Орлого (-1,951.3 сая)**

Тайлант онд орон нутгийн орлого тасарсантай холбоотойгоор үлдэгдэл бүүрсан байна.

**Бх. Техник хяналт, Барьцаа (-2,844.9 сая)**

Хөрөнгө оруулалтын техник хяналт, барьцаа хөрөнгийн чөлөөлснөөр үлдэгдэл буурсан байна.

**Бу. Булган. Орлого (-1,115.9 сая)**

Булган сумын төсөвт байгууллагад олгох урсгал санхүүжилт өмнөх оноос 4,417,458,402.99 төгрөгөөр өссөн нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурахад нөлөөлсөн байна.

**Бу. Орлого (-2,192.6 сая)**

Булган аймгийн ерөнхий орлогын данснаас аймгийн төсвийн шууд харьяа байгууллагад олгох урсгал санхүүжилтийн зардал өмнөх оноос 10.073.994.180 төгрөгөөр өссөн нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурахад нөлөөлсөн байна.

**Хөрөнгө оруулалтын барьцаа (-14,552.2 сая)**

Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төсөл арга хэмжээнээс хэрэгжүүлсэн арга хэмжээнд 11.2 тэрбум төгрөгийг олгосон. 3.6 тэрбум төгрөгийн улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

**Өв. Арвайхээр. Орлого (-3,158.0 сая)**

Сумын ОНӨОрлого цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 566.1 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлогын албан татвар 415.7 сая төгрөгөөр тасарсан нь төсвийн орлогын бүрдэлт урд жилүүдийнхээс буурсан. Эрдэнэс таван толгойн ногдол ашгаас суутгасан татвар төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйтэй холбоотой. Мөн аймгийн ИТХ-ын 08/01-р тогтоолоор сумдаас аймаг төвлөрүүлэх тэгшитгэл дүн 3.7 тэрбум төгрөгөөр, татварын буцаан олголт 1.3 тэрбум төгрөгөөр, бусад хөрөнгө оруулалт 2.0 тэрбумаар нэмэгдсэн нь үлдэгдэл буурахад нөлөөлсөн байна.

**Өв. Орлого (-1,238.0 сая)**

Аймгийн ИТХ-ын 02/12, 08/01-р тогтоолын дагуу газрын дуудлага худалдааны орлого 3.6 тэрбум төгрөг төлөвлөснөөс аж ажуй нэгж нэгж дуудлага худалдаанд оролцоогүй тул уг орлого тасарсан.

**Өв.Хөрөнгө оруулалтын барьцаа (-8,439.5 сая)**

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр "Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 249 дүгээр тогтоолын дагуу аймгийн барьцаа хөрөнгийн дансанд 13 төсөл арга хэмжээний 9.2 тэрбум төгрөгийг авснаас 8.6 тэрбум төгрөгийг олгосон тул үлдэгдэл буурсан.

**Өм. Авто замын сан (-4,620.0 сая)**

2025 оны төсвийн жилд аймгийн ИТХ-аар урьд оны үлдэгдлээр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн

**Өм. Даланзадгад. Орлого (-2,291.9 сая)**

Төсвийн орлогын төлөвлөгөө тасарснаас шалтгаалан мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан

**Өм. Ноён. Орлого (-1,128.3 сая)**

Уул уурхайн компаниудын үйл ажиллагаа зогссны улмаас ХХОАТ-ын суманд төлөх орлого тасарсан. ХХОАТ-ын орлогын төлөвлөгөө тасарснаас төсвийн орлогын эцсийн үлдэгдэл буурсан.

**Өм. Өмнөговь. Орон нутгийн хөгжлийн сан (-6,644.3 сая)**

2025 оны жилд аймгийн ИТХ-аар урьд оны үлдэгдлээр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн

**Өм. Тендерийн хороо (-3,167.7 сая)**

2025 онд Хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 335 гүйлгээгээр 8,021,354,964.7 төгрөгийн орлого төвлөрч, 222 гүйлгээгээр 11,189,050,799.58 төгрөгийн зарлага хийгдсэн буюу хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгө чөлөөлж, оны эхнээс 3,167,695,834.88 төгрөгөөр дансны үлдэгдэл буурсан.

**Өм. Цогтцэций. Орлого (-2,592.3 сая)**

Орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарч урьд оны үлдэгдлээс санхүүжүүлсэнтэй холбоотойгоор мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 2.5 тэр бум төгрөгөөр буурсан.

**Таван толгой (-88,310.4 сая)**

Борлуулалтын орлоготой холбоотой мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ буурсан

**Сү. Баруун-Урт. Орлого (-2,849.3 сая)**

2025 оноос аймагт төвлөрүүлэх татаас 2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотойгоор мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл багассан.

**Сү. Орлого (-2,853.0 сая)**

төсвийн хүндрэлтэй холбоотойгоор төсвийн орлого тасарсантай холбоотой.

**Сү. Хөрөнгө оруулалтын барьцаа (-4,643.0 сая)**

УТХО-ын төсөл арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотойгоор барьцаа дансруу татан төвлөрүүлээгүй. Барьцаа дансанд төвлөрүүлсэн гүйцэтгэлийг холбогдох баримтанд үндэслэн харилцагч байгууллагад шилжүүлсэн.

**Сэ. Барьцаа (-6,165.6 сая)**

Орон нутгийн болон улсын төсвийн барьцаа хөрөнгө данснаас 49 байгууллагын чанарын баталгааны мөнгө 895.1 сая, 16 байгууллагын зураг, төсвийн хяналтын зардлын 260.7 сая, 2 байгууллагын техник хяналтын зардал 81.7 сая, 21 байгууллагын барьцаа хөрөнгийн мөнгө 3509.3 сая төгрөгийг шилжүүлж, улсад 1418.8 сая төгрөгийг төвлөрүүлээ.

**Тө. Барьцаа (-3,737.1 сая)**

2024.2025 онуудын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын чанарын баталгааны барьцаа хөрөнгийг чөлөөлсөн

**Тө. Заамар. Орон нутгийн хөгжлийн сан (-1,465.3 сая)**

Шинэ сум төслөөр 55 өрхийн дулаан дэд бүтэц холбох ажлыг 2024 онд гэрээ байгуулаад 2025 онд ажил хийгдээд дууссан

**Ув. Барьцаа (-2,071.5 сая)**

Барилгын барьцаа дансанд ашиглалтад хүлээлгэн өгсөн төсөл, арга хэмжээний чанарын баталгааны 5% барьцаанаас гадна УТХО-ын үлдэгдэл санхүүжилтийн 2177.8 сая, ОНХО-ын үлдэгдэл санхүүжилтийн 1101.8 сая төгрөг байршуулсан тул нийт 6798.9 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнагдсан. Тайлангийн хугацаанд УТХО-ын болон ОНТХО-ын 17 төсөл арга хэмжээний санхүүжилт 2873.4 сая төгрөг, чанарын баталгааны хугацаа дууссанаас 4879.5 сая төгрөгийг чөлөөлсөн бол шинээр ОНТХО-ын үлдэгдэл санхүүжилт 1943.5 сая төгрөг, чанарын баталгааны 3024.9 сая төгрөгийг нэмж байршуулснаар 2025 оны эцэст 4727.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

**Ув. Увс. Орон нутгийн хөгжлийн сан (-1,076.5 сая)**

ОНХСангийн оны эхний үлдэгдлийг тайлант онд бүрэн дайчилахаар төсөвт тусгаж, хэрэгжилтийг хангаж ажилласан ба 2025 онд ОНХСангаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хугацаанд нь бүрэн гүйцэтгэж, санхүүжүүлсэн, мөн ОНХСангаас авахаар төлөвлөсөн санхүүжилт, шилжүүлгийн орлого 100.3 сая төгрөгөөр дутуу ирсэн зэргээс аймгийн ОНХСангийн данс оны эцэст 168.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан болно.

**Хо. Жаргалант. Орлого (-1,483.3 сая)**

Тайлант онд татварын болон татварын бус орлого давж биелэсэн ба 2024 оны үлдэгдлээс хөрөнгийн зардалд санхүүжүүлэхээр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталж зарцуулж мөнгөн хөрөнгө буурсан байна

**Хо. Орлого (-3,924.4 сая)**

Аж ахуйн нэгжийн 40 хувийн хувиарлалтаас орох орлого 6.0 тэрбум төгрөгөөр тасарсан нь мөнгөн хөрөнгө буурсан байна

**Хо. Орон нутгийн хөгжлийн сан (-3,216.5 сая)**

Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр аймгийн ИТХ-аар баталсаны дагуу санхүүжүүлж зарцуулсан.

**Хо. Техник хяналт (-6,475.3 сая)**

Барьцаа данснаас Улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтын барьцааг Сангийн яамнаас суутган авсан, орон нутгийн хөрөнгө оруулалтын барьцааг буцаан олгосон учир мөнгөн хөрөнгө буурсан.

**Хө. Мөрөн. Орлого (-2,995.0 сая)**

2025 онд сумын Орон нутгийн орлого нэр төрлөөр тасарч төлөвлөгөө биелээгүйтэй холбоотой байна

**Хө. Эрдэнэбулган. Орлого (-6,088.3 сая)**

аймагт төвлөрүүлсэн өмнөх оны үлдэгдэл

**Хөрөнгө оруулалтын барьцаа (-6,137.6 сая)**

Өмнөх онуудын хөрөнгө оруулалтын ажлуудын хугацаа дуусч барьцааг чөлөөлсөн

**Хэ. Хэрлэн. Орлого (-1,057.5 сая)**

Төсвийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлж баталсан орлогын үлдэгдэл буурсан байна

**АЗДТГазар -Найрамдал төсөл (-1,698.8 сая)**

Аймгийн Засаг Даргын Тамгын Газар, ХААИС-ийн Агроэкологи Бизнесийн Сургууль хамтран Европийн Холбооноос ЕХ-Монголын найрамдлыг бэхжүүлэх төсөл"-ийг 2022-2025 онд 3,0 сая еврогийн санхүүжилттэй төслийг хэрэгжүүлсэн. Тус төслийн тайланг 3 жил ТЕЗ-ийн нэгтгэлд тусгасан болно. 2025 онд тус төсөл хэрэгжиж дууссантай холбоотой Евролын холбооноос санхүүжилт ороогүй бөгөөд өмнөх оны үлдэгдэл 476,2 мян еврогоос гэрээний дагуу ХААИС-ийн харьяа Дархан салбарын сургуульд 448,6 мян евро буюу 1700,6 сая төгрөг, АЗДТГ-ын төслийн багт 106,9 сая төгрөг тус тус хуваарилж төслийн гүйцэтгэл 100 хувьтай, хэрэгжлээ. Тус төсөл 2022-2025 онд нийт 9,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн болно.

**Да. Орлого (-1,047.5 сая)**

Дамжуулан зээлийн өр төлбөр барагдуулсан.

**Да. Орон нутгийн хөгжлийн сан (-1,700.7 сая)**

Өмнөх оноос ОНХС -ийн шилжүүлгээр санхүүжих санхүүжилт буурсан.

**Да. Орон нутгийн хөрөнгө оруулалт (-19,656.3 сая)**

ОНХО -ын тайланд Барьцаа хөрөнгө оруулалтын дансны тайланг нэгтгэж тусгадаг байсныг 2025 оны тайланд салгаж тайлагнаснаас болон чанарын баталгаа болон гүйцэтгэлийн санхүүжилт олгосноос мөнгөн хөрөнгө буурсан.

**Нийтлэг үйлчилгээний нэгдсэн Авто бааз (-1,519.8 сая)**

2025 оны 01 дүгээр сарын 01-ны байдлаар 1,598,892.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан. Үүнээс: - Дансны өглөг 1,122,311.8 мянган төгрөгийг төлж барагдуулж, урьдчилж орсон орлого дансанд 2024 оны эцэст зарлагдсан тендер 2025 онд төлөлт хийгдсэн ба 2024 ондоо тухайн дүнг урьдчилж орсон орлогоор 376,648.5 мянган төгрөгөөр бүртгэсэн байсан ба тендерийн үр дүн 2025 онд гарч худалдан авалт хийгдсэн.

**Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ (-1,145.7 сая)**

2025 оны 12-р сарын цалингаа ондоо багтаан ажилчдад олгосон мөн НДШ, татварын өр төлбөрүүдээ барагдуулсан.

**УБ зам засвар арчлалтын газар (-1,675.4 сая)**

Нийт өөрчлөлтийн 80.9% нь бараа материал худалдан авахад төлсөн мөнгө, 7% ажилчдад төлсөн мөнгө, 8% баталгаа, барьцаанд төлсөн мөнгө бол үлдсэн 4.1% нь бусад мөнгөн хөрөнгийн зарлага эзэлж байна.

**УБ. Авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж (-38,055.5 сая)**

Байгууллагын барьцаа хөрөнгийн дансанд 2024 оны жилийн эцэст Зам тээврийн яамнаас Шинэ тойрог замын ТЭЗҮ 16.9 тэрбум, Шинэ ир тойруу хурдны зам төслийн ТЭЗҮ 16.0 тэрбум, УБ Трам төслийн ТЭЗҮ 5.5 тэрбум төгрөгийн үлдэгдэл байсан. Тайлант онд тус төслүүдийн ТЭЗҮ зураг төслийн ажил хийгдэж, гүйцэтгэгч компаниудад санхүүжилтийг олгон хэмнэлт болох 7.2 тэрбум төгрөгийг Сангийн яам руу буцаан төвлөрүүлсэн тул мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан.

#### **Уб. Бг. Орлого (-19,170.2 сая)**

2024 оны эцэст орлогын төлөвлөгөө 6.1 хувиар давж биелсэн. Нэмэлт санхүүжилтийн данснаас өглөгөөр тооцон төвлөрүүлсэн 1.6 тэрбум төгрөг зэргээс шалтгаалан өндөр дүнтэй гарсан 2025 онд орлогын төлөвлөгөө 30.0 т.б төгрөгөөр тасарсантай холбоотой өөрчлөлттэй гарсан байна.

#### **Уб. Орлого (-668,539.7 сая)**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 17 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 201, 264, 265 дугаар тогтоолуудаар гадаадын зах зээлд 500.0 сая ам доллар, дотоодын зах зээлд 1.0 их наяд төгрөгийн үнэт цаас гаргах зөвшөөрлийг авч дотоодын зах зээлээс 798,329.6 сая, гадаадын зах зээлээс 1,712,528.9 сая төгрөгийн бондын эх үүсвэр тус тус бүрдүүлж үүнээс Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1475 дугаар захирамжийн дагуу нийслэлийн гадаад үнэт цаасны хөрөнгийг “Сэлбэ дэд төв” төслийн зарцуулалт гарах хүртэл хугацаанд үр ашигтай хадгалах зорилгоор 2024 онд арилжааны 6 банканд 1,671,133.4 сая төгрөгийг хадгалуулснаас тайлант онд 1,567,408.0 сая төгрөг болж 103,725.4 сая төгрөгийг Сэлбэ дэд төвийн төсөлд зарцуулсан, мөн 2024 онд Монгол Улсын Засгийн газрын 264 дугаар тогтоолоор дотоодын зах зээлд гаргасан бондоос 298,271.2 сая төгрөгийг замд яваа мөнгөн хөрөнгөөр тайлагнаж байсныг тайлант онд төрийн санд татан төвлөрүүлж батарей хураагуурын төслийг санхүүжүүлсэнтэй холбоотойгоор тус тус нийслэлийн төрийн сангийн мөнгөн хөрөнгийн бууралтад голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

#### **Уб. Орон нутгийн хөгжлийн сан (-1,674.8 сая)**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024-2025 оны төсвийн жилд он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээний санхүүжилтийг батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу өмнөх оны үлдэглээс санхүүжүүлсний дагуу мөнгөн хөрөнгийн тайлант оны эцсийн үлдэгдэл буурсан байна.

#### **Уб. Сб. Орлого (-24,582.2 сая)**

Урьд оны үлдэгдэлээс орон нутгийн хөрөнгө оруулалтийн санхүүжилтийг олгосон

#### **Уб. Сх. Орлого (-11,126.1 сая)**

Дүүргийн засаг даргын тамгын газрын нэмэлт данснаас орлогын дансанд төвлөрүүлж татаас санхүүжилтийн өглөг үүсгэсэн дүн

#### **Уб. Сх. Орон нутгийн хөгжлийн сан (-1,204.2 сая)**

Дүүргийн барьцаа дансны үлдэгдлийг хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан дансны тайланд нэгтгэн гаргадаг байсан ба 2025 оны шинэ санхүүгийн системд тайлагнахад хөгжлийн сангийн дансны үлдэгдэл сангийн яамны үлдэгдэлтэй зөрсний улмаас тайлан илгээгдэх боломжгүй болж дүүргийн хөрөнгө оруулалт дансны тайланд барьцаа хөрөнгийг нэгтгэсэн. Өмнөх оны үлдэгдэл болох 2,607,221.6 мянган төгрөгөөс Орон нутгийн хөгжлийн сангийн оны эхний үлдэгдэл барьцаа 438,485.9 мянган төгрөгийг зарлагдаж хөрөнгө оруулалтын тайланд нэгтгэсэн. Мөн урьд оны дуусаагүй ажлын үлдэгдэл санхүүжилтийг олгосон.

#### **Ус сувгийн удирдах газар (-19,030.4 сая)**

· Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь өмнөх оноос 19,030,353.8 мянган төгрөгөөр буурсан байгаа нь энэ онд усны үнэ тариф нэмэгдээгүй, харин цахилгаан, дулаан гэх мэт ашиглалтын зардлууд өссөнтэй холбоотой, мөн Туул-1 төслийн тендерийн урьдчилгаа төлбөрийн баталгаа 5,716,703.6 мянган төгрөгийг банкинд байршуулсантай холбоотой байна.

#### **Гс. Барьцаа (-3,737.0 сая)**

ЗГ-ын тогтоолоор 3 164 799,3 мянган төгрөг төвлөрүүлсэн.

#### **Гс. Сүмбэр. Орлого (-1,541.3 сая)**

2024 онд орлогын төлөвлөгөө давж биелэсэн 2012,9 мянга үлдэгдэлтэй гарсан 2025 онд орлогын төлөвлөгөө тасарсан тул орлого буурсан үлдэгдэл 471,7 болсон.

Тодруулга №4а Богино хугацаат хөрөнгө оруулалт Санхүүгийн байдлын тайланд тусгасан богино хугацаат хөрөнгө оруулалт нь дараах зүйлсээс бүрдэнэ:

*/мянган төгрөгөөр/*

№	Дансны нэр, төрөл	Төсөвт байгууллага	Төсөл/Сан	Төрийн сан	ТӨҮГ болон ОНӨҮГ	Устгал	Нэгтгэсэн нийт дүн
1	Эхний үлдэгдлийн дүн	0	495,704,915.7	0.0	1,346,602,142	0.0	1,842,307,057.7
2	Эцсийн үлдэгдлийн дүн : Үүнээс	0	964,460,961.2	0	1,058,165,688	0	2,022,626,649.2
3	1.1.2.01 Үнэт цаас	0	964,460,961.2	0	1,058,165,688	0	2,022,626,649.2
4	1.1.2.01.01 Төгрө	0	964,460,961.2	0	1,058,165,688	0	2,022,626,649.2

Тодруулга №46 Богино хугацаат хөрөнгө оруулалтыг байгууллагаар нь харуулбал:

/мянган төгрөгөөр/

№	Байгууллага /Шатлал 2, ТЕЗ, Шатлал 1/-ын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Улаанбаатар	2,450,000	1,869,061.2
2	САНГИЙН САЙД	1,344,152,142	1,054,996,428.1
3	БОЛОВСРОЛЫН САЙД	58,225.8	1,319,762.9
4	Үндэсний баялгийн сан	495,646,689.9	964,441,396.8

Тэмдэглэл.(Богино хугацаат хөрөнгө оруулалттай холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 2,022.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 180.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдлийн 1,004.2 тэрбум төгрөг буюу 49.6 хувийг Төрийн банк ХК, 964.4 тэрбум төгрөг буюу 47.7 хувийг Хуримтлалын сан, 50.8 тэрбум төгрөг буюу 2.5 хувийг Монголын хөрөнгийн бирж ХК, 1.9 тэрбум төгрөг буюу 0.1 хувийг Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК, 1.3 тэрбум төгрөг буюу 0.1 хувийг Монгол Улсын Их сургууль тус тус эзэлж байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэлд эзлэх хувийг байгууллагын төрлөөр авч үзвэл 1,058.2 тэрбум төгрөг буюу 52.3 хувийг ТӨҮГ болон ОНӨҮГ, 964.5 тэрбум төгрөг буюу 47.7 хувийг төсөл сангийн хөрөнгө эзэлж байна.

## Тодруулга №5а Авлага Санхүүгийн байдлын тайланд тусгасан авлага нь дараах зүйлсээс бүрдэнэ:

/мянган төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Төсөвт байгууллага	Төсөл/Сан	Төрийн сан	ТӨҮГ болон ОНӨҮГ	Устгал	Нэгтгэсэн нийт дүн
1		Эхний үлдэгдлийн дүн	3,628,145,023.7	2,435,090,179.6	4,344,235,648.7	6,824,269,964.8	10,420,051,210.6	6,811,689,606.3
2		Эцсийн үлдэгдлийн дүн : Үүнээс	4,950,653,598.6	3,169,719,956.7	4,817,484,575.5	10,748,922,167.9	16,080,661,984.9	7,606,118,313.8
3	33	1.1.3 АВЛАГА	4,950,653,598.6	3,169,719,956.7	4,817,484,575.5	10,748,922,167.9	16,080,661,984.9	7,606,118,313.8
4	33100	1.1.3.01 Ажиллагчидтай холбогдсон авлага	4,618,047.1	36,677.7	0.0	3,523,737.3	49,909.4	8,128,552.6
5	33200	1.1.3.02 Төлбөртэй үйлчилгээний авлага	179,494,072.1	507,256	179,350.7	64,441,671.9	143,501,420.2	101,120,930.6
6	33300	1.1.3.03 Татаас, санхүүжилтийн авлага	563,451,562.8	200,089,635.4	91,752.8	2,610,309.2	538,757,881.2	227,485,378.9
7	33400	1.1.3.04 Зээлийн хүүгийн авлага	2,004,452.1	5,510,830.5	66,683,174.6	248,467,552	134,721,915.2	187,944,093.9
8	33401	1.1.3.05 Дансны авлага /ТӨҮГ/	989,914.6	706,619,320.9	0	1,679,503,474	1,074,640,104.1	1,312,472,605.3
9	33402	1.1.3.06 Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	7,145,229.3	590,430,660.1	253,924,014.3	484,028,837.9	5,972,929.2	1,329,555,812.4
10	33500	1.1.3.07 Бусад авлага	3,952,693,793	1,031,635,596.8	297,945,917	7,974,851,136.7	11,120,183,416.2	2,136,943,027.3
11	33510	1.1.3.07.01 Байгууллагаас авах авлага	3,794,069,502	1,010,973,323.3	297,463,654.3	7,876,296,463.4	11,011,226,911.3	1,967,576,031.7
12	33520	1.1.3.07.02 Хувь хүмүүсээс авах авлага	158,624,291	20,662,273.6	482,262.7	98,554,673.2	108,956,504.9	169,366,995.6
13	33600	1.1.3.08 Зээлийн авлага	240,256,527.6	634,889,979.2	4,198,660,366.2	291,495,449.1	3,062,834,409.4	2,302,467,912.7
14	33610	1.1.3.08.01 Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	227,256,527.6	633,272,408.3	47,809,525.3	291,495,449.1	16,316,814.9	1,183,517,095.5
15	33611	1.1.3.08.01.01 Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	45,154,434.4	0	46,548,927	0	15,373,355.9	76,330,005.5
16	33612	1.1.3.08.01.02 Хувь хүмүүст олгосон зээл	122,720,452.7	3,057,563.1	0.0	93,995,549.8	0.0	219,773,565.7
17	33613	1.1.3.08.01.03 Сургалтын төрийн сангийн зээлийн авлага	0	301,563,895.4	0.0	0.0	0.0	301,563,895.4
18	33614	1.1.3.08.01.04 Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	68,206.4	0	1,234,406.4	2,045,407.3	943,459	2,404,561
19	33615	1.1.3.08.01.05 Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	59,313,434.2	328,650,949.7	26,192	195,454,492	0.0	583,445,067.9
20	33620	1.1.3.08.02 Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	13,000,000	1,617,570.9	4,150,850,840.8	0	3,046,517,594.5	1,118,950,817.2
21	33621	1.1.3.08.02.01 Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	0	1,617,570.9	2,084,648,689.3	0	1,665,646,040.4	420,620,219.8

22	33622	1.1.3.08.02.02 Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	0	0.0	1,706,690,644.5	0	1,380,871,554.2	325,819,090.3
23	33623	1.1.3.08.02.03 Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	13,000,000	0.0	359,511,507.1	0.0	0.0	372,511,507.1

## Тодруулга №56 Авлагыг байгууллагаар нь харуулбал:

/мянган төгрөгөөр/

№	Байгууллага /Шатлал 2, ТЕЗ, Шатлал 1/-ын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Архангай	5,912,271.8	5,943,698.3
2	Баян-Өлгий	6,471,392.7	7,469,455.3
3	Баянхонгор	9,717,332.8	10,299,219.2
4	Булган	7,907,651	8,268,828.5
5	Говь-Алтай	12,862,808.1	12,504,147.7
6	Дорноговь	6,890,423.7	7,464,667.4
7	Дорнод	6,566,762.5	7,037,346
8	Дундговь	11,077,586.4	10,246,844.1
9	Завхан	6,251,660	7,454,766.2
10	Өвөрхангай	11,450,664.1	10,492,854.3
11	Өмнөговь	84,546,756.5	92,613,122.1
12	Сүхбаатар	4,110,676.6	4,625,222.1
13	Сэлэнгэ	13,063,903.6	13,757,254.3
14	Төв	26,534,897.5	24,367,784.9
15	Увс	8,079,201.1	7,761,069.9
16	Ховд	17,609,722.6	22,269,887.9
17	Хөвсгөл	10,461,792	13,524,119.2
18	Хэнтий	7,236,926.1	7,975,265
19	Дархан-Уул	2,309,479.6	3,173,267.3
20	Улаанбаатар	264,568,578.2	219,893,122.4
21	Орхон	24,320,455.2	26,838,020.1
22	Говь сүмбэр	1,247,323.9	2,334,562.6
23	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	637,892.5	85,883
24	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	74,674	96,741.8
25	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	4,390,343.1	8,399,453.2
26	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	1,764,239,533.8	1,957,655,956.5
27	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	3,965,158.2	3,986,138.4
28	САНГИЙН САЙД	137,143,754.9	130,945,883.5
29	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	34,589,550.5	56,175,095.8
30	ТӨВ ТӨРИЙН САН	1,413,794,446.1	1,646,852,255.2
31	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	6,257,334.2	12,841,430.6
32	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	3,035.6	3,035.6
33	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	24,113.5	38,707.6
34	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	563,536.4	66,820.4
35	ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	103	72.3

36	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	1,097,203.3	1,919,124.4
37	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	7,464.5	4,562.2
38	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	423.1	147,703.4
39	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	13,111,631.2	21,192,777.5
40	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	80,320.7	10,812.1
41	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	1,451,739.7	653,256.5
42	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	80,967,117.5	88,518,447.6
43	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	77,713,326.1	85,127,947
44	БОЛОВСРОЛЫН САЙД	338,570,456.3	338,026,158.3
45	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	244,334,734.7	380,113,011.3
46	АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД	16,986,950.6	46,078,034.7
47	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	586,958,686.2	583,873,789.5
48	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	123,723,672.4	222,425,234.4
49	ГЭР БУЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	154,163,598.2	160,363,319.7
50	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	3,085,553.8	2,242,667.7
51	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД, ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	334,314,456.2	202,792,006.8
52	ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	26,983,774.6	30,151,710.5
53	ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА	2,864.3	0.0
54	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	960.2	546
55	Эрүүл мэндийн даатгалын сан	166,538,986.9	192,724,877.4
56	Үндэсний баялгийн сан	0.0	43,983,753.9

Тэмдэглэл. (Авлага холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ.)

Авлага дансны үлдэгдэл 7,606.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 794.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны нийт үлдэгдлээс зээлийн авлага 2,302.5 тэрбум төгрөг буюу 30.3 хувийг, бусад авлага 2,136.9 тэрбум төгрөг буюу 28.1 хувийг, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн татвар, НДШ-ийн авлага 1,329.5 тэрбум төгрөг буюу 17.5 хувийг, дансны авлага 1,312.5 тэрбум төгрөг буюу 17.3 хувийг, татаас санхүүжилтийн авлага 227.5 тэрбум төгрөг буюу 3.0 хувийг, зээлийн хүүгийн авлага 187.9 тэрбум төгрөг буюу 2.5 хувийг, ажиллагсадтай холбоотой авлага болон төлбөртэй үйлчилгээний авлага 109.2 тэрбум төгрөг буюу 1.4 хувийг тус тус эзэлж байна.

Татвар, НДШ-ийн авлага 469.4 тэрбум төгрөгөөр, бусад авлага 160.0 тэрбум төгрөгөөр, зээлийн авлага 141.0 тэрбум төгрөгөөр, дансны авлага 118.3 тэрбум төгрөгөөр, татаас санхүүжилтийн авлага 29.8 тэрбум төгрөгөөр, төлбөртэй үйлчилгээний авлага 14.2 тэрбум төгрөгөөр, ажиллагсадтай холбоотой авлага 3.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ.

### 1.1.3 АВЛАГА

#### ӨССӨН БАЙГУУЛЛАГУУД (41)

##### Таван толгой төмөр зам (+77,974.1 сая)

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 21 дүгээр тогтоолын 2 дах заалт, Зам тээврийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 01/1646 дугаартай албан бичгээр Багахангай-

Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр замын барилга угсралтын ажлын эхлэлтийн санхүүжилтэд дэмжлэг үзүүлхээр "Монголын төмөр зам" ТӨХК-тай 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн СГ-2025/01 тоот гэрээ, 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн СГ/2025/02 тоот гэрээний дагуу санхүүжилт олгосноос шалтгаалж авлага өссөн.

#### **Эрдэнэс Монгол (+3,224,766.4 сая)**

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2025/02/18 өдрийн 03 дугаартай тогтоолоор 2024/2019 оны ү/а цэвэр ашгаас төрийн эзэмшлийн хувьцаанд 3,124.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилсан ба энэхүү ногдол ашгийн орлогыг хүлээн зөвшөөрч авлагаар бүртгэсэн болно. Мөн Охин компаниудаас авах менежментийн төлбөрийн авлага 69.6 тэрбум төгрөгөөр, арилжааны банкнуудын хүүгийн авлагын СТОУС-ын дагуу аккумуляц сууриар бүртгэж 5.2 тэрбум төгрөгийн авлага үүсгэсэн нь авлага өсөхөд нөлөөлсөн.

#### **Эрдэнэс таван толгой (+52,461.9 сая)**

Гадаад харилцагчаас авах нүүрсний авлагын хэмжээ өссөнтэй холбоотойгоор авлагын хэмжээ өссөн.

#### **Эрдэнэт үйлдвэр (+191,579.9 сая)**

Авлагын дансны үлдэгдэл 210,425.4 сая төгрөг болж, 191,579.9 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Тухайлбал: 1.Татвар, НДШ-ийн авлага 177,792.5 сая төгрөг болж 175,525.5 сая төгрөгөөр өссөн нь төсөвт төлөх татварыг бүрэн төвлөрүүлэх, 2026 оны татварын ноогдлыг урьдчилж төлөх чиглэлийг холбогдох төрийн байгууллагуудаас ирүүлсний дагуу татварыг урьдчилж төлснөөс шалтгаалсан, 2.Дансны авлага 26,995.1 сая төгрөг болж, 15,466.7 сая төгрөгөөр өссөн нь худалдан авагч тал экспортолсон бүтээгдэхүүний 3 худалдан авагчаас авах авлага 10,566.5 сая төгрөг (Үүнд: Кинг Файн, Стардаст инвестмент трейд, Миллифорд), 3 аж ахуйн нэгжтэй холбоотой дотоод борлуулалтын авлага 7,625.9 сая төгрөгөөр (ЭДЦС ТӨХК, Эрдэнэт ус ДТС ОНӨХК, Диспетчерийн үндэсний төв) нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

#### **УБ хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл /МССан/ (+9,238.9 сая)**

2025/12/31-ний байдлаар хүлээн авсан ба төлөгдөөгүй нэхэмжлэхийн дүнгээр санхүүжүүлэгч байгууллагад авлага үүсгэсэн.

#### **Зэвсэгт хүчний хөгжлийн сан (+19,247.6 сая)**

НҮБ-ийн нөхөн төлбөрийн орлогыг Монгол банкны долларын дансанд байршуулан тооцоо нийлсэн актыг үндэслэн авлагаар бүртгэсэн.

#### **Глобал сан сүрьеэ төсөл (+7,800.7 сая)**

Глобал сангийн одоо хэрэгжиж байгаа Үндсэн төсөл GC7 -д нэмэлт санхүүжилт хэлбэрээр D2H төсөл 2025.01.01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хөрөнгийн санхүүжилтийн дүн өссөн бөгөөд Глобал сангийн худалдан авалтын механизмын дагуу төслийн хүрээнд ханган нийлүүлэгдэх эм, бэлдмэл эмнэлгийн, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн төлбөр тооцоо Женев дэх төв оффисоос гадаад ханган нийлүүлэгч байгууллагууд руу 100% төлбөр тооцоо хийгдсэний дараа дээрх бараа материалууд Монгол улс руу ачигддаг. Мөн оношлуур, сүрьеэ болон БЗДХ-ын эм зэрэг нь хадгалах хугацаа, нөөцөөс шалтгаалан ХӨСҮТ-өөс ачилтын график гаргаж өгсний дагуу цуварч ачигддаг учир Гадаад байгууллагаас авах авлагын дүн өссөн.

#### **ОБЕГ-Улсын нөөцийн бараа бүрдүүлэлт сэлгэлт шинэчлэлт (+8,760.9 сая)**

Авлага МУ-ын ЗГ-ын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 22 дугаар хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу газрын тосны бүтээгдэхүүн импортлогч 5 аж ахуйн нэгж байгууллагад 3,400 тн 13,1 тэрбум төгрөгийн газрын тосны бүтээгдэхүүнийг улсын нөөцөд эргэн төлөгдөх, сэлгэн хадгалах богино хугацааны гэрээний үндсэн дээр олгож, авлагаар бүртгэсэн. Эргэн төлөгдөх гэрээний хэрэгжилт 80 гаруй хувийн гүйцэтгэлтэй байна. Өглөг МУ-ын ЗГ-ын 2025 оны 138 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд улсын нөөцөд нөхөн бүрдүүлсэн гэр, өвс тэжээлийн төлбөрийн үлдэгдэл бөгөөд өр төлбөрийг 2026 онд бүрэн барагдуулсан.

#### **ШШГЕГ. Шийдвэр гүйцэтгэх газар/төлбөр/ (+1,226,779.5 сая)**

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн хүрээнд төлбөр авагч төлбөр төлөгчийн хоорондын тооцооноос үүссэн, өссөн.

#### **Хөтөлийн цемент шохоо (+7,842.6 сая)**

Өмнөх оноос 7,842.6 сая төгрөгөөр өссөн нь дансны авлага 6,753.4 сая төгрөгөөр буюу зээлийн нөхцөлөөр гэрээгээр цемент худалдан авсан нэр бүхий 8 байгууллагын 10.1 тэрбум төгрөгийн борлуулалтын авлага нөлөөлсөн. Авлигатай тэмцэх газарт хэрэг үүсгэн шалгагдаж байна, нэмэгдсэн өртгийн албан татварын авлага 467.8 сая төгрөгөөр өссөн, бусад авлага 621.3 сая төгрөгөөр өссөн нь найдваргүй авлагын хасагдуулаг голлон нөлөөлсөн байна.

#### **Боловсролын зээлийн сан (+32,186.5 сая)**

Оюутны хөгжлийн зээлийн авлага 9.1 тэрбум төгрөгөөр, хөнгөлөлттэй зээлийн авлага 3.7 тэрбум төгрөгөөр буурсан ба гадаад зээлийн авлага 45.0 тэрбум төгрөгөөр нэмэгдснээр нийт авлага 32.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. /хэдэн хүний тоо хэрэгтэй/

#### **ЕБС-н гүйцэтгэл, үр дүнгээр олгох санхүүжилт (+6,007.7 сая)**

2025 оны 12 дугаар сард төрийн бус өмчийн 145 сургуульд олгосон санхүүжилтийн гүйлгээ буцсанаар тооцоо үүссэн.

#### **АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТЫН НЭГТГЭЛ (+15,154.5 сая)**

20 АЗЗА-ТӨХК-ийг 2025.04.11-ний өдөрөөр тасалбар болгон татварын ерөнхий газараас хасалтын картаар татан буулгаж тайлан балансыг албан ёсоор нэгтгэсэн. Авлагын өсөлт огцом өссөн байгаа нь 20 ТӨХК-тай баланс нэгдээгүй байсны эхний үлдэгдэл бөгөөд 20 сарбарын авлага нийлсэнээр өндөр өсөлттэй харагдаж байна.

#### **Иргэний нисэхийн үндэсний төв (+9,571.7 сая)**

Гадаад, дотоодын агаарын тээвэрлэгч нарт үзүүлсэн үйлчилгээний орлогоос үүссэн авлага нь тайлант хугацаа дамжин төлөгддөг тул тайлант хугацааны авлагаас гадна дансны авлагын томоохон өөрчлөлтийг дурдвал: - ИНҮТ-02 нэгж дээр Аэромонголиа ХХК-тай холбоотой 2021 оны шүүхийн шийдвэртэй 704.13 сая төгрөгийн авлагыг ИНЕГ-ын даргын 01/96 тоот албан бичиг, ИНҮТ ТӨХХК-ний гүйцэтгэх захирлын А/47 тоот тушаалын дагуу ИНЕГ-т балансаас балансад авлага шилжүүлсэн. - БУОУНБ-28 нэгж дээр Хүннү-Эйр ХХК-тай холбоотой хуримтлагдсан авлагыг Голомт банкт хамтран "Төлбөр барагдуулах гурвалсан гэрээ" хийснээр ажлын өдөрт 4.0-4.5 сая төгрөгөөр тус компаний харилцах данснаас тогтмол таталт хийж, БУОУНБ-ын харилцах дансанд төлөлт хийгдэж байгаа. Үүний үр дүнд 2.7 тэрбум төгрөгийн авлагыг жилийн эцэст 1.09 тэрбум төгрөгөөр бууруулсан. - ЧХОУНБ дах ШХА-29 нь 2025 оны 03 сарын 31-ний өдрөөр Эрчис ойл ХХК-д шилжснээр 246.6 сая төгрөгөөр дансны авлага буурсан. - Харин НАБХА-08 нэгж дээр ЧХОУНБ дээр дотоодын агаарын тээвэрлэгчдэд үзүүлсэн Аюулгүй байдлын үйлчилгээний орлогоос үүссэн авлагын төлөлт удаашралтай байгаа ба түүнд ногдох НӨАТ-ын төлөлт хийгдэхгүй байгаатай холбоотойгоор тус нэгжийн дансны авлага 2.02 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй тайлагнасан.

#### **МИАТ (+26,766.7 сая)**

Компанийн НӨАТ-ын авлага 24,457.2 сая төгрөгөөр өссөн нь авлага өсөхөд голлон нөлөөлсөн.

#### **Монголын төмөр зам (+99,364.3 сая)**

1.12-р сарын тээврийн орлогын авлага 1 сард орж ирсэн. 2. НӨАТ-ын хяналт шалгалтаар үүссэн хойшлуулан тооцох НӨАТ-ын актыг хуримтлагдсан ашигт хаасан бичилт залруулсан 42,3 тэрбум төгрөг 3.2022-2025,06,30 хүртэл хувь тэнцүүлэн хойшлуулсан НӨАТ-ын авлагыг НӨАТ-ын авлага дансанд бүртгэсэнийг залруулсан 8,2 тэрбум төгрөг. 4.БХХХ төслийн хойшлогдсон НӨАТ-ын авлага 22.4 тэрбум төгрөгөөс нэмэгдсэн байна. 5. БХХХ төслийн зам төмөр худалдан авсан гүйцэтгэлийн төлбөр 23.0 тэрбум төгрөг төлсөн зэрэг дээрх шалтгаанаар авлага нэмэгдсэн.

#### **Геологийн судалгаа-шинжилгээний төв ААТҮГ (+17,509.4 сая)**

нийт 20,185.03 сая төгрөгийн авлагаас 14,681.3 сая төгрөг буюу нийт авлагын 73% нь Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй Агаарын геофизик-2024, Булс төслийн санхүүжилт Үндэсний геологийн албанаас авах авлага, 1,707.7 сая төгрөг буюу 7%-н авлага Оюутолгой ХХК-ны шинжилгээний ажлын авлага дараа сар бүрийн 20-25-ны хооронд төлбөр хийгддэг ердийн авлага, 1,086.5 сая төг буюу 6% нь 7 төслийг тендерийн гүйцэтгэлийн баталгаанд байршиж буй мөнгө, 928.5 сая буюу 5.1 хувь нь хэвийн бус авлага үүнээс 451.8 сая төгрөгийн авлагын 2 шатны шүүхийн шийдвэр манай талд гарсан, 476.8 сая төгрөгийн 100 орчим харилцагчтай холбоотой авлага нь 2011-2022 оны хооронд үүссэн найдваргүй шинж чанартай бөгөөд 50% орчим хэргийн материалыг бүрдүүлж хууль хяналтын байгууллагуудаар явж байгаа бөгөөд зарим шийдвэр он дамжиж гарсан.

### **Эрчис ойл (+12,665.3 сая)**

Энэ нь Эрчис ойл ХХК 12,665,318.6 мянган төгрөгийн авлагын өсөлттэй бөгөөд холбогдох аж ахуй нэгжүүдтэй агаарын түлш худалдах, худалдан авах, сумалгаа хадгалалттай холбоотой үүссэн авлага байна.

### **Мал эмнэлгийн ерөнхий газар (+9,725.8 сая)**

2024 оныд Биокомбинат ТӨХК-иас авахаас 1.7 тэрбум төгрөгийн авлагатай гарч 2025 онд барагдсан болно. 2025 онд 11.5 тэрбум төгрөгөөр малын вакцинжуулалтын үйлчилгээний хөлсний өглөгөөр Сангийн яамнаас татаас санхүүжилтийн авлагатай гарс авлага 3 дугаар сард барагдсан болно.

### **Хөдөө аж ахуйн корпораци (+16,249.2 сая)**

2025 оны 4 улиралд Биржийн арилжаагаар худалдан борлуулсан хүнсний улаанбуудайн борлуулалтын үлдэгдэл төлбөр он авсан тул авлагын үлдэгдэл өссөн үзүүлэлттэй байна.

### **Амгалан дулааны станц (+8,596.6 сая)**

2025 онд УБДС ТӨХК мөнгөн урсгалын дутагдалтай ажилласнаас шалтгаалан жилийн эцсийн байдлаар борлуулалтын авлагыг бүрэн барагдуулаагүйгээс авлага өссөн.

### **Диспетчерийн үндэсний төв (+76,288.3 сая)**

2025 оны НХА-ын авлага өссөн шалтгаан: 1. Түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч 16 компанийн хуримтлагдсан авлагын хэмжээ нэмэгдсэн нь нийт авлагын өсөлтийн гол шалтгаан болсон. Ялангуяа томоохон түгээх компаниудын авлага мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн бөгөөд тухайлбал “УБЦТС” ТӨХК 45.4 тэрбум төгрөг, “ДБЭХС” ТӨХК 10.2 тэрбум төгрөг, “ДСЦТС” ХК 9.8 тэрбум төгрөг, “БНЗӨБЦТС” ТӨХК 1.9 тэрбум төгрөг, “Хөвсгөл ЭХ” ХХК 1.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Эдгээр байгууллагуудын хэрэглэгчдээс төлбөр төвлөрүүлэх хугацаа удааширч, орлогын төвлөрүүлэлт хангалтгүй байснаас төвлөрсөн авлагын хэмжээ нэмэгдэхэд нөлөөлсөн. 2. ЭХЗХ-ны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн №632 дугаар тогтоолоор Төв, Өмнөд, Алтай-Улиастайн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор хэрэглэгч төлбөрөө гэрээнд заасан хугацаанд нь бүрэн төлж чадахгүй, орлого төвлөрүүлэлт саатах нөхцөл үүссэн бөгөөд энэ нь түгээх компаниудын авлагыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн. 3. Өвлийн их ачаалалд эрчим хүчний хэрэглээ огцом нэмэгдэж, системийн ачаалал ихэссэн үед хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчийг хязгаарлахгүй байх чиглэлийг дээд шатны байгууллагаас өгсөн. Үүнтэй холбоотойгоор төлбөрөө хугацаанд нь төлөөгүй хэрэглэгчдэд хэрэглээний хязгаарлалт хийх боломж багасч, хэрэглээ хэвийн үргэлжилснээр төлбөрийн үлдэгдэл хуримтлагдан авлага өсөх нөхцөл бүрдсэн. 4. Томоохон түгээх компаниудын хэрэглэгчдийн бүтэц дотор аж ахуйн нэгж, төсөвт байгууллага, айл өрхийн төлбөрийн үлдэгдэл өндөр байгаа нь авлагын өсөлтөд шууд нөлөөлсөн. Ялангуяа томоохон аж ахуйн нэгжүүд болон төсөвт байгууллагуудын төлбөрийн үлдэгдэл өндөр байгаа нь авлагыг нэмэгдүүлэх шалтгаан болж байна.

### **Дулааны гуравдугаар цахилгаан станц (+15,368.2 сая)**

Авлага дансны үлдэгдэл 21,292,186.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 15,368,211.1 мянган төгрөгөөр өссөн нь Диспетчерийн үндэсний төв ТӨХК-иас авах цахилгаан эрчим хүч борлуулсны авлага 20,070,620.2 сая төгрөг болж өмнөх оноос 15,275,018.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой. ААН байгууллагаас авах уур болон жижиг хэрэглэгчийн цахилгаан, дулааны 420,765.7 мянган төгрөгийн, татварын 765,152.5 мянган төгрөгийн, ажилчдаас авах 6,242.9 мянган төгрөгийн, ААН байгууллагаас авах бусад 29,404.9 мянган төгрөгийн авлагууд бүртгэлтэй байна.

### **Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц (+16,932.3 сая)**

ДҮТ ТӨХК-с авах ЦЭХ-ны борлуулалтын авлага 17,773.1 сая төгрөгөөр өсөж, НАНөөц 493.3 сая төгрөгөөр буурсан нь авлагын өсөлтөд нөлөөлсөн. Мөн 2024 жилийн эцэст Сангийн яамны хаалтаар НӨАТ-т 1,427.0 сая төгрөг төлөгдсөн бөгөөд энэ дүнгээр илүү төлөлт үүссэн. 2025 онд уг татварыг суутган төлсөнөөр татварын авлага буурсан.

### **Таван толгой түлш (+19,651.5 сая)**

Борлуулалтын авлагын дүн өмнөх оноос 3,146.4 сая төгрөгөөр өссөн нь Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2025 оны 10 сарын 8-ны 6 дугаар тогтоолоор сайжруулсан шахмал болон хагас коксон шахмал түлшний борлуулалтад ногдох НӨАТ-ын авлага 3,146.5 сая төгрөгийг авлага, энэ нь нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд нийлүүлэх хагас коксон шахмал түлшний үнийг НӨАТ-аас чөлөөлөх асуудлыг 2025 ондоо багтаан УИХ-д өргөн мэдүүлж шийдвэрлүүлэхийг нийслэлийн засаг дарга болон Сангийн сайд нарт даалгасан боловч хэрэгжээгүй тул борлуулсан түлшинд ногдох НӨАТ-ыг авлагаар бүртгэсэн. Татвар,НДШ авлага болох 13,343.1 сая төгрөг нь хагас коксон түлшний борлуулалтаас үүссэн хойшлогдсон НӨАТ авлага болно. Ажиллагсдаас авах авлага 2,155,2 сая төгрөгөөр өссөн нь 2025 оны жилийн эцсийн тооллогоор борлуулалтын нярвуудын бэлэн бүтээгдэхүүнээс дутагдсан тул хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр хандсан.

### **Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ (+37,480.8 сая)**

Авлага өссөн шалтгаан нь 2024 оны 11 дүгээр сард цахилгаан борлуулах үнэ тариф нэмсэнтэй холбоотой 2025 онд авлага өсгөх дараах шалтгаануудыг бий болгосон.1.Аж ахуйн нэгжийн ангилалд 27,346.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагийн 39.2 хувь буюу 10,873.41 сая төгрөг нь Төрийн болон орон нутгийн өмчит, төсөвт байгууллагын авлага эзэлж байгаа ба Амгалан дулааны станц ТӨХК -8,272.7 сая төгрөг, Төв чандмань ДЭХГ - 382.1 сая төгрөг, Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ – 1,496.0 сая төгрөг, Монгол - Кувейтын судалгааны төв – 365.5 сая төгрөг авлагын үлдэгдэл багтаж байна. 2025 оны төсөв батлагдсаны дараа цахилгаан борлуулах үнэ тариф нэмэгдсэнээс санхүүжилт хүрэлцэхгүй байгаа гэсэн тайлбарыг Төрийн болон орон нутгийн өмчит, төсөвт байгууллагуудаас ирүүлж, Эрчим хүчний яамны зүгээс эдгээр хэрэглэгчдийг түдгэлзүүлэхгүй байх чиглэлийг өгсөн нь дээрх авлагыг үүсгэхэд нөлөөлсөн. 2.2025 оны эхний 3 сарын байдлаар үнэ тариф нэмсэнтэй холбоотой хэрэглэгчийн төлбөр төлөлт эрс буурч, ЭХЯ болон ЭХЗХ -оос хэрэглэгчдийг түдгэлзүүлэхгүй болон алданги ногдуулахгүй байх чиглэлүүдийг өгч, хамтарсан ажлын хэсгүүд гарган өргөдөл гомдол барагдуулах, хэрэглэгчдийн дулааныг хэмжих, хэмнэлтийн чиглэлээр заавар зөвлөмж өгөх зэргээр онцгой нөхцөл байдалд ажилласан. Ахуйн хэрэглэгчдийн цахилгаан борлуулах тарифыг шаталсан байдлаар нэмэгдүүлсэн нь хэрэглэгчдийн төлбөрийг өсгөхөд нөлөөлсөн бөгөөд үүнээс шалтгаалан ахуйн хэрэглэгчдийн төлбөр төлөх чадамж буурч, олон удаа шаардуулах, түдгэлзүүлэлт хийсний дараа төлөх гэх мэт нөхцөл байдлууд үүссэн.

### **Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ (+10,103.4 сая)**

Засгийн газраас 2025 оны туршид эрчим хүчний үнэ тарифыг нэмэгдүүлэхгүй байх бодлого баримталсантай холбоотойгоор дулааны эрчим хүчний тарифын шинэчлэл хойшлогдсон. Тодруулбал, 2025 оны 5 дугаар сарын 16-наас хэрэгжихээр төлөвлөж байсан дулааны тарифын нэмэгдлийг 2026 оны 1 дүгээр сар хүртэл хойшлуулсан нь эрчим хүчний компаниудын орлогын төлөвлөлт болон мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлж 1 худалдан авагчаас авч-аас авах авлага өссөн.

### **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (+181,432.3 сая)**

ХЭДС-ийн жилийн эцэст төвлөрүүлсэн орлогыг Сангийн яамтай тооцоо нийлж татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн. Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт, Ажлын байрны төлбөрийн урьдчилж орсон орлого, ХБИ ажиллуулаагүйн орлого зэрэг болно.

### **Мэдээлэл, холбооны сүлжээ ХХК (+6,238.0 сая)**

МЦХ ХК, Жимобайл ХХК-аас авах тооцоо тайлант онд төлөгдөөгүй тул авлага өссөн.

### **Дорноговь. НДСан - Аймаг (+6,618.2 сая)**

2025 оны авлагын эхний үлдэгдийг 33 хувиар бууруулсан боловч тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн авлага өссөн.

#### **Өмнөговь. НДСан - Аймаг (+7,639.2 сая)**

2025 онд дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ уналтад орж нүүрс олборлолтын хэмжээ өмнөх оноос 11 хувиар буурснаар нүүрсний олборлолт, гадаад худалдаа зогсонги байдалд орсон. Үүнтэй холбоотой тухайн салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа доголдож нийгмийн даатгалын шимтгэлийн авлага өссөн.

#### **Улаанбаатар. НДСан - УБ-Баянгол (+22,776.4 сая)**

Монгол Улсын эдийн засгийн болон улсын төсвийн нөхцөл байдал, - Иргэдийн амжиргааны болон худалдан авах чадвар буурсан, - Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа доголдоноос эмнэлэгийн байгууллагуудын санхүүжилт бүрэн олгогдоогүй, - Уул уурхай, барилга, зам тээвэр болон бусад салбаруудын үйл ажиллагаа хүндэрсэн, - Аж ахуйн нэгж байгууллагуудын улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлын гүйцэтгэлд холбогдох санхүүжилт олгогдоогүй гэх шалтгаанууд нөлөөлсөн.

#### **Улаанбаатар. НДСан - УБ-Баянзүрх (+15,304.6 сая)**

Улсын төсвөөс санхүүжилт авах Эрүүл мэндийн байгууллага болон зам, барилга гэх мэт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын санхүүжилт ороогүйгээс авлага өндөр дүнтэй үүссэн.

#### **Улаанбаатар. НДСан - УБ-Сонгинохайрхан (+18,030.6 сая)**

Авлага өссөн гол шалтгаан нь уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчдын үйл ажиллагаа 2025 онд доголдсон, ковидын үеэс хуримтлагдсан өр үүсгэсэн аж ахуй нэгжийн үйл ажиллагаа бүрэн сэргэж эдийн засгийн хямарлаас гарч чадахгүй байгаа зэрэг шалтгаанаас нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаанд нь төлөөгүй ажил олгогчдын өр, авлага өссөн.

#### **Улаанбаатар. НДСан - УБ-Сүхбаатар (+25,986.4 сая)**

Авлага дансны татвар, ндш-ийн авлага хэсэг өссөн. Авлага өссөн гол шалтгаан нь уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчдын үйл ажиллагаа 2025 онд доголдсон, ковидын үеэс хуримтлагдсан өр үүсгэсэн аж ахуй нэгжийн үйл ажиллагаа бүрэн сэргэж эдийн засгийн хямарлаас гарч чадахгүй байгаа зэрэг шалтгаанаас нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаанд нь төлөөгүй ажил олгогчдын өр, авлага өссөн.

#### **Улаанбаатар. НДСан - УБ-Хан-Уул (+24,361.1 сая)**

Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах, сангийн орлогын төлөвлөгөөг бүрдүүлэх ажлын хүрээнд авлага үүсгэсэн ажил олгогчдын судалгааг гаргаж, авлагыг барагдуулах ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулсан. Шат дараалсан арга хэмжээ авч ажилласны үр дүнд нийт 3316 ажил олгогчийн 110,604.6 сая төгрөгийн шимтгэлийн авлагаас 1714 ажил олгогчийн 32,076.05 сая төгрөгийн авлага барагдуулан ажилласан байна. Тус дүүргийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын өсөлт нь агаарын тээвэр, барилга, уул уурхай, газар тариалан гэх мэт улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд олонтой эдгээр байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй шууд хамааралтай байна.

#### **Улаанбаатар. НДСан - УБ-Чингэлтэй (+17,631.1 сая)**

Авлага өсөн шалтгаан нь ААНэгж байгууллага, уул уурхайн компаниудын орлого буурч, үйл ажиллагаа доголдсонтой холбоотой НДШимтгэлийн авлага өссөн.

#### **Хуримтлалын сан (+139,410.9 сая)**

Нийт авлагын 68.5 хувь буюу 95,427.2 сая төгрөг нь Үндэсний баялгийн сангийн хуульд заасны дагуу уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь хүртэлх бол түүний төрийн эзэмшилд ногдох бүх ногдол ашиг, 31.5 хувь буюу Монголбанкнаас 58.8 сая төгрөг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 43,924.9 сая төгрөгийн хүүгийн орлогын авлага бүртгэсэн байна.

#### **Да. Орлого (+11,140.0 сая)**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 сарын 17 ны өдрийн 708 дугаар тогтоолоор Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр бий болсон тус төслийн нийт 39,2 тэрбум төгрөгийн хөрөнгө өр төлбөрийг аймгийн өмчид бүртгэх /ашиглагч байгууллага Дархан ус суваг ХК/ шийдвэр гарсны дагуу Дархан Ус суваг ХК-тай тус хөрөнгө, өр төлбөрийн тооцоо нийлэн тайланд тусгалаа. Зээлийг орон нутгаас төлж Дархан ус суваг ХК тай дамжуулан зээлийн гэрээг байгуулан тус авлагыг тусгаж төслийн үр ашиг өгөөжөөс орон нутагт төлж барагдуулах нөхцөлтэй авлагын дүн болно.

#### **Уб. Нийслэлийн Захирагчийн ажлын алба (+14,717.9 сая)**

Нийт авлагын үлдэгдэл төлбөр 14,878,250.95 мянган төгрөг байна. Нэмэлт санхүүжилийн дансаар Угсармал орон сууцны барилгын дулаан алдагдлыг бууруулах, дулаалах "NAMA FACILITY" төсөл, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого зарцуулах тухай НЗД/1554 захирамжаар тусгай зориулалтын машин, түүний дагалдах хэрэгсэл худалдан авах мөн НЗД-ийн эрх шилжүүлэх А/164 захирамжаар шингэрүүлсэн нефтийн хийн LPG түлшээр 50-аас доошгүй айл өрхийг нэгдсэн шугамаар хангах ажлуудын санхүүжилт болох 14,717,928.64 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн.

#### **Улаанбаатар хотын хөгжлийн корпораци (+6,957.3 сая)**

Улаанбаатар Энержи ХХК-ийн Диспетчерийн үндэсний төвөөс авах авлага 6.246.058,2 мянган төгрөг, ажилчидаас авах авлага 393.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн байна.

#### **БУУРСАН БАЙГУУЛЛАГУУД (55)**

##### **Дарханы төмөрлөгийн үйлдвэр (-9,251.0 сая)**

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас авах кругийн борлуулалтын авлага оны эхнээс 4.5 тэрбум төгрөгөөс буурсан. 2025 оны эхэнд 2024 оны 12 сарын борлуулалтын авлага төлөгдөөгүй байсан бол 2025 оны 12 сарын борлуулалтын төлбөр урьдчилж төлөгдсөнөөр оны эцсээр тооцооны үлдэгдэлгүй гарсан. Мөн Хөрөнгийн биржээс авах төмрийн хүдрийн баяжмалын арилжааны гэрээний дэнчингийн авлага оны эхэнд 27.7 тэрбум төгрөг байсан бол оны эцэст 19 тэрбум төгрөг болж 8.7 тэрбум төгрөгөөр буурсан зэрэг нь авлагын бууралтанд нөлөөлсөн.

##### **Монголрос цветмет (-1,664.4 сая)**

Авлага барагдуулах комисс байгуулж ажилласнаар хууль хяналтын байгууллага болон бусад байдлаар авлагыг барагдуулан ажиллав.

##### **Эрдэнэс ашид ХХК (-1,396.3 сая)**

Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 45 дугаар тогтоолоор Эрдэнэс Ашид ХХК-ийн төсөв, хөрөнгө оруулалтыг 2,425,312,258 төгрөгөөр баталсан бөгөөд төсөв, хөрөнгө оруулалтын дүнгээр дүрмийн санг нэмэгдүүлэх шийдвэр гарсан. 2024 онд уг хөрөнгө оруулалтын санхүүжилтын үлдэгдэл 1,391,999,457.50 төгрөгийн авлага болон ажилчдаас авах авлага 4,281,456.43 төгрөг нийт 1,396,280,913.93 төгрөгийн авлагатай байсан ба 2025 онд үлдэгдэл санхүүжилтаа авч дууссан.

##### **Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл (-8,073.3 сая)**

Авлага буурсаннь өмнөх онд буруу бүртгэсэн авлагыг залруулсан.

##### **Төрийн банк (-17,715.5 сая)**

Богино хугацаат зээл 19.11 тэрбум төгрөгөөр буурч, бусад авлага 1.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

##### **Батлан хамгаалах яам (-22,788.1 сая)**

Батлан хамгаалах яамны 4 нэмэлт дансны харилцахын оны эцсийн үлдэгдэлийг төрийн санд төвлөрүүлэн авлагаар тусгасан. 2026 онд авлагаа барагдуулсан.

##### **Цэргийн төв эмнэлэг (-7,536.3 сая)**

2024 оны жилийн эцэст Эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж үйлчилгээний авлагатай гарсан бөгөөд уг авлага 2025 онд бүрэн барагдаж дууссан. 2025 оны жилийн эцсийн авлага нь 2025 оны тусламж үйлчилгээний авлага болно.

**Гэмтэл, согог судлалын үндэсний төв (-10,407.9 сая)**

ЭМД-аас авах өмнө оны авлагаа бүрэн авсан. Өглөг барагдуулсан.

**Дау. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-1,546.3 сая)**

ЭМД-аас авах өмнө оны авлагаа бүрэн авсан. Өглөг барагдуулсан.

**Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (-2,103.4 сая)**

ЭМД-аас авах өмнө оны авлагаа бүрэн авсан. Өглөг барагдуулсан.

**Тө. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-1,792.3 сая)**

ЭМД-аас авах өмнө оны авлагаа бүрэн авсан. Өглөг барагдуулсан.

**УБ. Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв (-1,938.8 сая)**

2024 оны эхний үлдэгдлээрх төлбөртэй үйлчилгээний авлага болох 3.196.103.590.62 төгрөгийг 2025 оны 2-р сард бүрэн авсан. 2025 оны 256.162.800 төгрөгийн авлага нь төлбөрт үйлчилгээний авлага болно.

**УБ. Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв (-2,939.9 сая)**

ЭМД-аас авах өмнө оны авлагаа бүрэн авсан. Өглөг барагдуулсан.

**УБ. Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг (-4,072.1 сая)**

ЭМД-аас авах өмнө оны авлагаа бүрэн авсан. Өглөг барагдуулсан.

**УБ. Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв (-1,438.4 сая)**

ЭМД-аас авах авлагатай, бараа материалын өртэй байгаа.

**УБ. Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг (-2,523.5 сая)**

Эхний үлдэгдэл болох, 2024 оны жилийн эцсээрх 3,280,832,889.10 төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлагыг бүрэн авсан. Эцсийн үлдэгдлээрх авлага нь 2025 оны жилийн эцсийн төлбөртэй үйлчилгээний авлага, хавдрын эмийн авлага болон ээлжийн амралтаас үүссэн авлага болно.

**УБ. Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв (-1,158.9 сая)**

ЭМД-аас авах авлагатай, бараа материалын өртэй байгаа.

**УБ. Түргэн тусламжийн төв (-1,788.7 сая)**

ЭМД-аас авах авлагатай, бараа материалын өртэй байгаа.

**Улсын гуравдугаар төв эмнэлэг (-14,185.3 сая)**

Тайлант онд цалин нэмэгдсэн, даатгалаас авлагатайгаас мөнгөн хөрөнгө буурсан. Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага буурсан.

**Улсын нэгдүгээр төв эмнэлэг (-13,806.1 сая)**

ЭМД-аас авах авлагатай, бараа материалын өртэй байгаа.

**Хавдар судлалын үндэсний төв (-5,592.4 сая)**

ЭМД-аас авах авлагатай, бараа материалын өртэй байгаа.

**Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг (-3,662.5 сая)**

Ажиллагсадтай холбоотой авлагын оны эхний үлдэгдэл 205,785.08 төгрөг байснаас тайлант онд 484,110,455.23 төгрөгийн авлага нэмэгдэж, 484,316,240.31 төгрөгийн авлага хорогдож оны эцэст үлдэгдэлгүй байсан. Татаас санхүүжилтийн авлагын оны эхний үлдэгдэл 3,520,000.00 төгрөг байснаас 1,092,989.59 төгрөгийн авлага нэмэгдэж, 3,520,000.00 төгрөгийн авлага хорогдож жилийн эцэст 1,092,989.59 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй. Байгууллагаас авах авлага (резидент эмчийн цалин, ЭМД-ын санхүүжилтийн авлага, аж ахуйн нэгжээс авах

авлага г.м)-ын оны эхний үлдэгдэл 5,074,901,842.08 төгрөг байснаас тайлант хугацаанд 1,418,330,299.73 төгрөгийн авлага нэмэгдэж, 5,078,187,092.08 төгрөгийн авлага хорогдож оны эцэст 1,415,045,049.73 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Бусад бараа материал, цалингийн урьдчилгаа, үндсэн хөрөнгийн урьдчилгаа, урьдчилж гарсан зардал, төсөвт байгууллагын авлагууд оны эхний үлдэгдэл байхгүй, тайлант хугацаанд нийт 13,599,290,525.29 төгрөгөөр нэмэгдэж, хорогдож, тайлант хугацааны эцэст үлдэгдэлгүй байна. Нийт тайлант онд 15,502,824,269.84 төгрөгийн авлага нэмэгдэж, 16,165,313,857.68 төгрөгийн авлага хорогсон тул авлага 3,662,489,587.84 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

#### **Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам (-9,434.8 сая)**

Орлогод нийцсэн, өртөг багатай орон сууцны нийлүүлэлтийг орон нутагт нэмэгдүүлэх зорилгоор загвар туршилтын орон сууцыг ашиглалтад оруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 2024/277 дугаартай гэрээний дагуу ТОСК руу шилжүүлсэн санхүүжилтээс гүйцэтгэгч компанид 2025 онд 9,299,858.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон нь ХББОСЯ-ны авлагыг бууруулсан.

#### **Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургууль (-4,135.5 сая)**

АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг, Монгол анагаах ухааны төв эмнэлэг нь Эрүүл Мэндийн Даатгалын сангаас авах авлага 2024 оны авлага орж ирснээр авлага буурсан байна.

#### **Боловсролын салбарын хөрөнгө оруулалт, их засвар (-39,638.0 сая)**

Тайлант онд 39,642,233,700 төгрөгийн авлага буурсан.

#### **Мэргэжлийн боловсрол, сургалтын газар ХО-ИЗ (-2,350.9 сая)**

Боловсролын салбарын тоног төхөөрөмжийн нийлүүлэлт нь 2025 оны 3 сард тоног хийгдэснээр авлага буурсан байна.

#### **Зам, тээврийн яам (-1,558.0 сая)**

Тус яамны нэмэлт санхүүжилтийн дансанд байсан мөнгө Сангийн яамтай тооцооны үлдэгдлийн дүнгээр баталгаажсан дүн. Жолоочийн даатгалын сангийн хөрөнгөөр санхүүжигдэх гэрээт ажлуудын төлбөр.

#### **Иргэний нисэхийн ерөнхий газар (-12,445.2 сая)**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 04 дүгээр тогтоолоор Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрыг хэрэгжүүлэгч агентлаг гэж, Монгол улсын засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай 193 дүгээр тогтоолоор Агаарын навигаци, нисэх буудал, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ болон аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг хариуцан хэрэгжүүлэх "Иргэний нисэхийн үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг тус тус заасан. 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн дээрх газрууд Сангийн яамны Э-Баланс, finform дээр санхүүгийн тайланг тус тусдаа оруулсан. Өмнөх онд санхүүгийн нэгтгэсэн дүнгээр бэлтгэн боловсруулж оруулдаг байсан. 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс тус тусдаа оруулж байгаа тул өмнөх оноос буурсан.

#### **Байгаль орчныг хамгаалах, ЖДҮ-ийг хөгжүүлэх 2 үе шаттай зээлийн төсөл (-1,973.4 сая)**

Авлага дансны үлдэгдэл 86,138,043,518.38 төгрөг болж 1,973,376,142.69 төгрөгөөр буурсан нь 37 аж ахуй нэгжид 13,856,930,000.00 төгрөгийн төслийн зээл олгож, 269 аж ахуйн нэгж байгууллагын 15,830,306,142.69 төгрөгийн үндсэн зээлийн төлбөр барагдуулсанаас шалтгаалжээ.

#### **Зээлийн батлан даалтын сан (-9,036.9 сая)**

СТОУС 9 дагуу бүртгэлд тусгасан.

#### **Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл (-14,260.5 сая)**

Сангийн яам, ХХААХҮЯ-ны хооронд 2020 онд байгуулсан 200515/01/161/56 тоот Дамжуулан зээлийн гэрээний дагуу нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зээлийг дамжуулан олгосон Хаан, Хас, Голомт, Худалдаа хөгжлийн банкаар дамжуулан олгосон авлага барагдсан дүн.

### **Улаанбаатар дулааны сүлжээ (-2,385.3 сая)**

Нэхэмжлээгүй авлага өмнөх оноос 2,385.2 сая төгрөгөөр буурсан шалтгаан нь төрийн сангаар төлдөг төсөвт байгууллагын 12 дугаар сарын хэрэглээний төлбөр ондоо багтаж төлж, өр авлагагүй гарсантай холбоотой.

### **Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ (-6,123.2 сая)**

Нийт авлага 15,068.6 сая төгрөг байгаа нь оны эхнээс 6,123.2 сая төгрөгөөр, зорилтот төвшний төлөвлөгөөнөөс 4,105.4 сая төгрөгөөр буурсан байна. Нийт авлагын 97% буюу 14,619.7 сая төгрөгийг цахилгаан эрчим хүчний авлага (93% Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, 3.6% ААНБ, 0.4%-ийг айл өрх), 0.4% буюу 60.2 сая төгрөгийг шөнийн тарифын хөнгөлөлтийн авлага, 0.2% буюу 31.5 сая төгрөгийг диспетчерийн үйлчилгээний төлбөрийн авлага, 2.1% буюу 312.1 сая төгрөгийг татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, 0.3% буюу 45.1 сая төгрөгийг бусад авлага эзэлж байна. Цахилгаан эрчим хүчний нийт авлагын 95.8% буюу 14,007.5 сая төгрөг нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас авах авлага, 4.2% нь бусад хэрэглэгчдээс авах авлага байна. 2025 оны 12 дугаар сард Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай хийсэн цахилгаан эрчим хүчээр хангах гэрээний 3.4 заалтын дагуу хуваарьт төлбөр дээр нэмж 8.0 тэрбум төгрөгийг хүлээн авсанаас хамааран авлага буурсан байна.

### **Завхан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан (-1,037.3 сая)**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөртэй холбоотой олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт хийгдсэнтэй холбоотой буурсан байна.

### **Өвөрхангай. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан (-1,155.1 сая)**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөртэй холбоотой олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт хийгдсэнтэй холбоотой буурсан байна.

### **Сүхбаатар. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан (-1,145.7 сая)**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөртэй холбоотой олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт хийгдсэнтэй холбоотой буурсан байна.

### **Монгол улсын хөгжлийн банк (-10,884.2 сая)**

Зээлээр ҮХХ худалдан борлуулах гэрээний хүрээнд эргэн төлөгдсөн төлбөрийн дүнгээр авлага буурсан.

### **Монголын цахилгаан холбоо ХК (-2,680.8 сая)**

Харилцагч байгууллагуудын дансны авлага 3,222.4 сая төгрөгөөр буурч, татвар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 14.0 сая төгрөг, бусад авлага 527,5 сая төгрөгөөр тус тус өссөн.

### **НДСан - НД Ерөнхий газар (-8,464.1 сая)**

Капитал банкны эрх хүлээн авагчаас 8 тэрбум гаруй төгрөгийн авлагыг барагдуулж бууруулсан байна.

### **Сэлэнгэ. НДСан - Аймаг (-1,737.2 сая)**

Нийгмийн даатгалын шимтгэл, акт, алданги, торгуулийн авлага багтах ба үүнээс эрүүл мэндийн даатгалын сангийн авлагыг бууруулсан болно.

### **Өм. Мал хамгаалах сан (-1,014.8 сая)**

Аймгийн Онцгой комиссын хурлаар малчдаас авах өвс тэжээлийн авлагыг бууруулсан.

### **Тө. Баян. Засаг даргын тамгын газар (-1,214.3 сая)**

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар ЕБС-ийн спорт залыг шинээр хийн хүлээлгэн өгсөн.

### **Тө. Орлого (-1,300.1 сая)**

Сэргэлэн сумын 2024 онд аймаг төвлөрүүлэх орлого 1,186.7 сая төгрөгийн авлага барагдуулсан.

### **Тө. Сэргэлэн. Засаг даргын тамгын газар (-3,982.6 сая)**

Сэргэлэн сумын төв доторх автозамын ажил 2025 онд дууссан учир авлагаа хаасан.

### **Хо. Орлого (-1,251.5 сая)**

Шим ус ОНӨААТҮГ-аас дамжуулан зээлийн авлага, хүүгийн 1.2 тэрбум төгрөгийг Аймгийн Засаг даргын захирамж Шүүхийн шийдвэрийн дагуу данс бүртгэлээс хассанучир авлага буурсан.

#### **Хо. Техник хяналт (-1,277.0 сая)**

Барьцаа данснаас аймгийн Засаг даргын шийдвэрийн дагуу мах, шатахууны нөөц бүрдүүлэхэд олгосон авлага барагдсан байна.

#### **Да. Хонгор. Орон нутгийн хөгжлийн сан (-1,522.9 сая)**

ОНХС-аас санхүүжилийн авлага буурсан.

#### **Зорчигч тээвэр 4 (-2,433.6 сая)**

Авлагын данс 2,548,720,593.77 төгрөг байснаас 2,433,618,105.59 төгрөгөөр буурсан нь 2024 оны 12 дугаар сарын санхүүжилт 2025 оны 01 дүгээр сард орж ирсэнтэй холбоотой.

#### **Нийслэлийн орон сууцны корпораци (-5,193.6 сая)**

Нийслэлийн орон сууцны корпораци ХК-н санхүүгийн түрээсийн авлага 2,921,868.2 мянган төгрөг, энгийн түрээсийн авлага 182,073.5 мянган төгрөг, орон сууцны ашиглалтын авлага 30,456.7 мянган төгрөг байна. НОСК 1-5 ТЗК ХХК-н санхүүгийн түрээсийн авлага 2,821,809.2 мянган төгрөг, санхүүгийн түрээсийн хүүгийн авлага 98,856.8 мянган төгрөг, байна. Тайлант 2025 оны татвар, НДШ-ийн авлага дансны авлагын үлдэгдэл 6,065,412.4 мянган төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татварын авлага 6,046,614.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 18,798.1 мянган төгрөгийн авлага байна. Тайлан онд бусад авлага 820,645.6 мянган төгрөгийн авлага оффисын байрны ашиглалтын төлбөрт 517.5 мянган төгрөг, суурин утасны төлбөрийн авлага 306.8 мянган төгрөг, Улаанбаатар орон сууцжуулалт ХХК-с энгийн түрээсийн орлого төвлөрүүлэлтийн авлага 343,328.6 мянган төгрөг, барилга захиалагчийн хяналтын авлага 225,000.0 мянган төгрөг, ажилчдаас авах авлага 10,097.0 мянган төгрөг, бусад иргэн аж ахуйн нэгжээс авах авлага 241,395.7 мянган төгрөгийн авлагыг тус тус бүртгэсэнтэй холбоотой байна.

#### **УБ зам засвар арчлалтын газар (-27,083.3 сая)**

Дансны авлагын бууралт буюу өөрөөр хэлбэл авлага цугларалт хийгдсэн.

#### **Уб. Бг. Засаг даргын тамгын газар (-1,378.8 сая)**

2024 оны 12 дугаар сарын 06 өдөр Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газар болон Сэтгэшгүй нэмэх ХХК-тай "Барс хоёр захын хойд талаар шинээр баригдах авто зам Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20 дугаар хороо,Петровис ШТС-ын баруун талаас 46/1 дүгээр байр хүртэл " 1,614,213,503 төгрөгөөр авто зам барихаар гэрээ байгуулсан. 2024 онд санхүүжилт гараагүй тул тооцоо нийлсэн актаар баталгаажуулан өр авлага үүсгэн ажилласан болно. 2025 онд Сэтгэшгүй нэмэх ХХК нь авто замын ажлын гүйцэтгэл захиалагчийн хяналт болон бусад хяналтаар баталгаажин 85.4 хувийн гүйцэтгэлтэй 1.378.840.774 төгрөгийн санхүүжилт олгосон болно. Гэрээний дагуу үлдэгдэл 235.372.729 төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан 2025 оны жилийн эцсийн тайланд өр авлага үүсгэн ажиллаж байна.

#### **Уб. Нийслэлийн тээврийн газар (-35,615.9 сая)**

42	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	3,387,804.4	5,412,915.8
43	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	25,554,749.1	30,201,644
44	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	122,427,445.9	127,410,646.2
45	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	1,258,559,808	1,433,909,928.8
46	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	323,531,036.8	318,261,847
47	БОЛОВСРОЛЫН САЙД	5,391,946,436.8	5,973,952,520.2
48	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	6,695,815,865.1	6,601,670,199.5
49	АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД	171,022,566	213,074,034.8
50	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	219,888,656.5	243,879,404.3
51	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	4,629,123,265	5,139,451,705.9
52	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	202,617,741.4	225,355,594.3
53	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	921,116,469.2	1,040,888,870.2
54	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД, ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	211,836,368.7	275,010,811.2
55	ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	359,986,917.9	377,358,251.3
56	ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА	1,195,074.9	3,562,848.6
57	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	3,843,545	3,316,622.5
58	Эрүүл мэндийн даатгалын сан	7,123,811.8	5,877,210.7

Тэмдэглэл.(Үндсэн хөрөнгөтэй холбоотой тайлбар тэмдэглэлийг хийнэ.)

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл цэвэр дүнгээр 67,746.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 8,172.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийн 42,465.6 тэрбум төгрөг буюу 62.7 хувийг биет хөрөнгө, 21,186.4 тэрбум төгрөг буюу 31.3 хувийг биет бус хөрөнгө, 4,047.9 тэрбум төгрөг буюу 6.0 хувийг бусад хөрөнгө, 46.1 тэрбум төгрөг буюу 0.1 хувийг газар тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,172.9 тэрбум төгрөгөөр өссөн нь барилга байгууламж, орон сууц 5,296.6 тэрбум төгрөг, машин тоног төхөөрөмж 1,600.8 тэрбум төгрөг, бусад биет бус хөрөнгө 1,559.1 тэрбум төгрөг, авто тээврийн хэрэгсэл 0.9 тэрбум төгрөг, бусад үндсэн хөрөнгө 0.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Дуусаагүй барилга, байгууламж дансны үлдэгдлийн улсын ТЕЗ 4,746.4 тэрбум төгрөг буюу 96.1 хувийг, орон нутгийн ТЕЗ 191.5 тэрбум төгрөг буюу 3.9 хувийг тус тус эзэлж байна.

## 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

### ӨССӨН БАЙГУУЛЛАГУУД (124)

#### Тагнуулын Ерөнхий газар (+17,900.3 сая)

Төсвийн болон хөрөнгө оруулалтын зардлаар хөрөнгө бэлтгэсэн.

#### Төрийн тусгай хамгаалалтын газар (+10,358.1 сая)

Төлөвлөсөн хөтөлбөр арга хэмжээний хүрээнд байрилга байгууламж 1.9 тэрбум, техник тоног төхөөрөмж 2 тэрбум, тээврийн хэрэгсэл 6.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

#### Дарханы төмөрлөгийн үйлдвэр (+9,054.7 сая)

Биет хөрөнгийн өсөлтөөс гадна тайлант хугацааны хойшлогдсон татварын хөрөнгө 1.86 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн.

#### Монголрос цветмет (+73,746.9 сая)

Уул уурхайн техник тоног төхөөрөмж болон шинээр АҮЭБЯамны харьяа уул уурхайн чиглэлийн далд уурхайн музейг ТӨБЗГ-ын 2025оны 12 сарын 23-ны 878 тоот тогтоолоор шилжүүлэн авсан.

#### Монголын газрын тос боловсруулах үйлдвэр (+524,889.3 сая)

ЕРС 01 багц ажлын хүрээнд нийт 9 барилга болон түүний дагалдах тоног төхөөрөмж, ГТҮ-ийн 95-1, оффис үйлчилгээний барилгууд ашиглалтанд орсноор өссөн.

#### Таван толгой төмөр зам (+1,531,741.1 сая)

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 103 дугаар "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах арга хэмжээ авах, тус төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцоо нийлж үндсэн хөрөнгөд бүртгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг даалгасны дагуу ухайн төслийн хөрөнгүүдийг үндсэн хөрөнгөөр бүртгэж эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлсэн. Мөн тайлант онд компанийн үйл ажиллагаатай холбоотой үндсэн хөрөнгө худалдан авснаас шалтгаалж нэмэгдсэн.

#### Эрдэнэс Монгол (+6,216.5 сая)

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 239км автозамын урсгал засварт олгосон санхүүжилт, компанийн ХО-ын төлөвлөгөөнд тусгагдсан ГСАЗ-ийн ажилчдын байр, ШНЦ-ийн барилгын ажил дуусч ҮХ-өөр бүртгэсэн болно.

#### Эрдэнэс оюу толгой (+7,592.2 сая)

Барилга үндсэн хөрөнгөөр бүртгэж орлогот авснаар үндсэн хөрөнгө өссөн.

#### Эрдэнэт үйлдвэр (+491,465.6 сая)

Үндсэн хөрөнгийн өсөлтөөс хамаарсан.

#### Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл - 3 /4342/ (+13,472.8 сая)

Дуусаагүй барилга байгууламж гүйцэтгэгчид олгосон урьдчилгаа төлбөрийн дүнгээр өссөн.

#### Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл -/3788/-ТХН (+49,266.7 сая)

Аудитын зөвлөмжийн дагуу бусад эргэлтийн хөрөнгөнд байсан үлдэгдлийг дуусаагүй барилга байгууламжинд шилжүүлсэн.

#### Төрийн банк (+26,331.4 сая)

Биет хөрөнгийн хөдөлгөөн - 9.4 тэрбум төгрөгөөр өссөн, биет бус хөрөнгө - 0.48 тэрбум төгрөгөөр буурсан, Дерватив санхүүгийн хөрөнгө - 17.2 тэрбум төгрөгөөр өссөн, Өмчлөх бусад хөрөнгө - 0.21 тэрбумаар өссөн байна.

## **УБ хотын төлбөрийн чадварт нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл- /3694/ (+121,044.0 сая)**

УСНББОУС-11, Азийн хөгжлийн банкны зөвлөмж, Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/З тоот тушаалыг тус тус үндэслэн хөрөнгийн шинж чанарыг харгалзан тайлант онд Санхүүгийн байдлын тайлангийн эргэлтийн хөрөнгийн “Бусад эргэлтийн хөрөнгө” бүлэгт хамаарах дансдын тайлант оны эхний үлдэгдэл 67,957,344,954.12 төгрөг болон тайланд онд бүртгэгдсэн 53,086,612,538.43 төгрөгийг буюу нийт хуримтлуулан бүртгэгдсэн үлдэгдэл болох 121,043,957,492.55 төгрөгийг эргэлтийн бус хөрөнгийн “Дуусаагүй барилга, байгууламж” бүлгийн холбогдох дансдад шилжүүлэн бүртгэсэн болно.

## **УГЕГ - Дорноговь, Замын-Үүд дэх гаалийн газар (+8,916.5 сая)**

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах төслөөс 1,715.1 сая төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, 1,891.6 сая төгрөгийн лабораторийн барилга Гаалийн ерөнхий газрын бусад эргэлтийн хөрөнгөөс 5,313.9 сая төгрөгийн рентген тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлэн авч бүртгэлд тусгасан.

## **УГЕГ - Өмнөговь Гашуун Сухайтын гаалийн хороо (+54,114.9 сая)**

1. ГЕГазраас -13,606.2 сая төгрөг 2. Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслөөс - 47,184.0 сая төгрөг 3. Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газраас – 267.2 сая төгрөгийн хөрөнгийг тус тус хүлээн авч үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгасан.

## **УГЕГ - Увс аймаг дахь гаалийн хороо (+21,068.3 сая)**

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслөөс Боршоо хилийн боомтын бүтээн байгуулалт 19,463.6 сая төгрөгийн хөрөнгө ГЕГ-ын бусад эргэлтийн хөрөнгөөс Увс аймаг дахь гүний гаалийн шинэ конторын барилга 2,638.6 сая төгрөгийн хөрөнгө мөн Боршоо хилийн боомтын ариутгалын байгууламж нийт 1,062.0 сая төгрөгийн хөрөнгийг тус тус хүлээн авч үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгасан.

## **Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл - нэмэлт-ТХН (+8,064.3 сая)**

Бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй дуусаагүй барилгыг Эргэлтийн бус хөрөнгөд бүртгэх шийдвэр гарсан. 2,111,957,719.65 төгрөгийн хөрөнгө оруулалт нэмэгдэж 21,178,675,738.70 төгрөгийн хөрөнгийг ашиглагчид шилжүүлсэн

## **Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл-1 (+36,679.7 сая)**

Бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй дуусаагүй барилгыг Эргэлтийн бус хөрөнгөд бүртгэх шийдвэр гарсан. Тухайн онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт 3,585,779,532.12 ба шилжүүлсэн хөрөнгө -672,324,030.45

## **Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл /3895/-ТХН (+46,322.4 сая)**

Аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу Барилгын гүйцэтгэлийг хуримтлуулан бүртгэж байсан Урьдчилж төлсөн зардал дансны ангилалын өөрчилж дуусаагүй барилга дансруу шилжүүлсэн. Тайлант хугацааны элэгдэл тооцсон

## **Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1 дэх үе (+18,387.7 сая)**

Тайлант хугацаанд Увс аймгийн НЭ-ийн өргөтгөл, эмнэлгийн тоног төхөөрөмж, БЗД, ЧД, СХД-ийн өрхийн эмнэлэг, Тариалан, Баян-Өндөр, Эрдэнэ, Дашинчилэн сумын эрүүл мэндийн төвийн барилга болон эмнэлгийн тоног төхөөрөмж, ХУД-ийн НЭ-ийн барилгын гүйцэтгэл гарч 45,304.6 сая төгрөгөөр дуусаагүй барилга данс өссөн ба Өвөрхангай аймгийн Баян-Өндөр СЭМТ-ийн барилга болон эмнэлгийн тоног төхөөрөмж, Увс аймгийн НЭ-ийн тоног төхөөрөмж, Дашинчилэн, Тариалан сумын ЭМТ-ийн эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу ашиглагч байгууллагад балансаас балансад шилжүүлэн 18,817.8 сая төгрөгийг данснаас хассан. Мөн 8,048.8 сая төгрөгийг урьдчилгаа данс руу шилжүүлэн бүртгэсэн. Төслийн нэгжид ашиглаж буй үндсэн хөрөнгийн тайлант хугацааны элэгдэл 50.0 сая төгрөг бөгөөд тухайн дүнгээр биет бус хөрөнгийн баланс дээрх дүн буурсан байна.

## **Зэв (+12,000.3 сая)**

28.3 сая төгрөгийн хөрөнгийг татаас санхүүжилтээр худалдан авалт хийж 11,972.3 сая төгрөгийн үйлдвэрийн зориулалттай хөрөнгийг БХАҮН-ээс үнэ төлбөргүй хүлээн авсан

**Зэвсэгт хүчний жанжин штаб (+2,009,408.1 сая)**

Батлан хамгаалах тухай хуулийг үндэслэн үндсэн хөрөнгийн хөдөлгөөний бүртгэлд тусгасан. УТХО, ЗХХСАН, нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээс үндсэн хөрөнгийн худалдан авалт авалт хийгдсэн болон гадаадын тусламжийн болон бараа материалын данснаас шилжүүлэн үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн.

**Бх. Аймгийн нэгдсэн эмнэлэг (+9,532.7 сая)**

ТӨБЗГ-ын 2025 оны 86 тогтоолоор амбулаторийн барилга шинээр орлогод авсан.

**Гэмтэл, согог судлалын үндэсний төв (+34,295.3 сая)**

ЭМС-ын 2025 оны А/05, А/344 тоот тушаалаар 36.4 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.

**Өв. Баян-Өндөр. Эмнэлэг (+6,241.7 сая)**

ТӨБЗГ-ын тогтоолоор Эмзэг бүлгийн иргэдийн төслөөр баригдсан барилга, тоног төхөөрөмж орогод авсан.

**Өв. Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг (Өв. Хархорин) (+11,425.9 сая)**

Өвөрхангай аймгийн ИТХ тогтоолоор эрх шилжин баригдсан 6.1 тэрбум төгрөгийн барилга, ЭМС-ын А/355 тушаалаар Люксембург төслийн санхүүжилтээр 1.0 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж авсан.

**УБ. Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв (+9,027.8 сая)**

ТӨБЗГ-ын тогтоолоор Амбулаторийн 9.3 тэрбум төгрөгийн барилга орлогод авсан.

**Ув. Аймгийн нэгдсэн эмнэлэг (+10,562.3 сая)**

ЭМС-ын 2025 оны А/355, А/373 тоот тушаалаар 11.2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн

**Улсын гуравдугаар төв эмнэлэг (+8,658.7 сая)**

ЭМС-ын 2025 оны А/355, А/514 тоот тушаалаар 4.0 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Хөрөнгийн дахин үнэлгээгээ хийсэн.

**Улсын нэгдүгээр төв эмнэлэг (+12,862.8 сая)**

ЭМС-ын 2025 оны А/05, А/356, А/360 тоот тушаалаар 9.6 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Их засвар орлогодсон

**Хавдар судлалын үндэсний төв (+16,402.7 сая)**

ЭМС-ын 2025 оны А/358, А/482, А/167 А/263 тушаалаар 41 тэрбумын тоног төхөөрөмж орлогодсон. Үүнд Австрийн төслийн тоног төхөөрөмж багтсан. Мөн 5.3 тэрбум төгрөгийн их засвар орлогодсон.

**Хүрээ амаржих газар (2) (+48,726.0 сая)**

Эмнэлгийн барилга 48 тэрбум төгрөгөөр орлогод авсан.

**Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (+35,438.8 сая)**

Их засвар болон ЭМС-ын тушаалаар хуваарилагдсан тоног төхөөрөмж орлогодсон.

**Архивын ерөнхий газар (+45,376.0 сая)**

Монгол Улсын Засгийн Газар болон БНСУ-ын Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн “Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт” төслийн хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг ТӨБЗГ-ын 2025 оны 292 дугаар тогтоолоор 54,4 тэрбум төгрөгийн хөрөнгийг орлогод авсан./MON-16 төсөл/

**Хил хамгаалах ерөнхий газар (+79,376.3 сая)**

УТХО, НҮБ, Хөгжлийн хөтөч, Бүс нутгийн хөгжил төсөл болон дуусаагүй үйлдвэрлэлээс шилжүүлэн авсан барилга 21,661.8 сая төгрөг, Санхүүгийн түрээсээр худалдан авсан нисдэг тэрэг, УТХО-аар авсан автомашин 51,592.2 сая төгрөг, ТӨБЗГ-ын н/07 тогтоолоор хөрөнгийн үнэ болон ашиглах хугацаа шинэчлэн тогтоосон хөрөнгө, ЗГ-ын мн/27 тогтоолоор орлого авсан газрын дүнгээр тус тус өссөн байна

### **Хууль зүйн үндэсний хүрээлэн (+8,017.1 сая)**

ТӨБЗГ-ын 2025.12.24-ны өдрийн “Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 801 дугаар тогтоолоор хүрээлэнгийн оффисын шинэ барилгыг 7,4 тэрбум төгрөгөөр, ТӨБЗГ-ын 2025.12.31-ны өдрийн А1/2724 тоот албан бичгээр 2025 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон “Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/” УТ/2501201091 дугаартай төсөл арга хэмжээний 4 багц ажлын 725,5 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэсэн.

### **ЦЕГ - Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын нэгж (+7,504.5 сая)**

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албанаас худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 25 ширхэг тээврийн хэрэгсэл, 16 ширхэг цахилгаан дугуйг ЦЕГ-ын Санхүү, ар талын алба, ЦЕГ-ын гэрээт харуул хамгаалалтын албанаас балансаас балансад шилжүүлэн авч, данс бүртгэлд тусгаж, орлогод авсан.

### **ЦЕГ - Техник засварын төв (+6,246.1 сая)**

Нууцын байгууллага

### **ЦЕГ - Цагдаагийн автобааз (+13,950.5 сая)**

Шинээр худалдан авсан болон, түрээсийн гэрээгээр 2024 онд худалдан авсан 96 ширхэг тээврийн хэрэгсэл данс бүртгэлд тусгаж, орлогод авснаар өссөн үзүүлэлттэй байна.

### **ШШҮТ - Шүүх шинжилгээний ерөнхий газар (+8,215.7 сая)**

ТӨБЗГ-ын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 201 дүгээр "Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай" тогтоолоор ийслэлийн Шүүх шинжилгээний газраас нийт 7,338,951,845.60 төгрөгийн үлдэх өртөгтэй машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, автотээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэн авсан. Мөн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А-1/1597 дугаартай "Үндсэн хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай" албан бичгээр Цагдаагийн ерөнхий газраас 110,233,680.54 төгрөгийн Киа спортейж автомашин 1 ширхгийг шилжүүлэн авсан. Мөн газрын 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А-1/2579 дугаартай "Зөвшөөрөл олгох тухай" албан бичгээр Нийслэлийн шүүх шинжилгээний газраас 22,233,333.76 төгрөгийн 3 автомашин, Өмнөговь аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төвөөс 1 ширхэг 1,680,000 төгрөгийн усан ванн балансаас балансад шилжүүлэн авсан. ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А-2/2433 дугаартай "Зөвшөөрөл олгох тухай" албан бичгээр бусад үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 8,067,483.20 төгрөгийн хөрөнгийг батлан хамгаалах зориулалттай тоног төхөөрөмж дансанд, 214,800 төгрөгийн хөрөнгийг машин тоног төхөөрөмж дансанд, бусад нөөц данснаас 43,306,200 төгрөгийг машин тоног төхөөрөмж дансанд шилжүүлэн бүртгэсэн. Мөн газрын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн "Хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай" А-1/309 тоот албан бичиг, 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А-1/2579 дугаартай "Зөвшөөрөл олгох тухай" албан бичгүүдээр харьяа газар, төв, хэлтсүүдэд 136,538,000 төгрөгийн балансын үнэтэй машин тоног төхөөрөмж, автомашин шилжүүлсэн. ТӨБЗГ-ын 2025 оны 02 дугаар 20-ны өдрийн 98, 2025 оны 12 дугаар сарын 17-ны өрийн 780 дугаар "Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай" тогтоолоор 672,047,216.60 төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан. ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А-1/2506 дугаартай "Хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай" албан бичгээр Хьюндай соната маркийн 22,757,400 төгрөгийн балансын үнэтэй 1 ширхэг автомашиныг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах ажлын албанд шилжүүлэн өгсөн. Мөн газрын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 368 дугаар "Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай" тогтоолоор 81,468,030 төгрөгийн машин тоног төхөөрөмжийг 32,587,212 төгрөгөөр, 23,598,349.4 төгрөгийн тавилга эд хогшлыг 9,439,339.8 төгрөгөөр, 4,500,000 төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг 1,800,000 төгрөгөөр, 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 737 дугаар "Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай" тогтоолоор 36,495,050 төгрөгийн машин тоног төхөөрөмжийг 21,897,030 төгрөгөөр, 31,606,000 төгрөгийн тавилга эд хогшлыг 18,963,600 төгрөгөөр тус тус үнэ, ашиглах жилийг шинэчилсэн.

### **Ар. Батцэнгэл. Сургууль /Ахлах/ (+6,368.6 сая)**

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 05/21 тоот орон нутгийн өмчид эд хөрөнгө хүлээн авах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай тогтоолоор сургуулийн 320 хүүхдийн суудал бүхий

өргөтгөлийн барилга 6,066,405,969 төгрөгийн, аймгийн орон нутгийн өмчийн газрын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 213 тоот зөвшөөрлөөр дотуур байрын их засварын капиталжуулалтаар 224,089,510 төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн авснаар өссөн байна.

**Ар. Цахир. Сургууль /Ахлах/ (+7,276.5 сая)**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 700 дугаар тогтоолын дагуу 5,375,678,572 төгрөгийн өртөг бүхий 3 давхар хичээлийн байрыг, аймгийн өмчийн газрын зөвшөөрлөөр бусад үндсэн хөрөнгө 1,706,901,428 төгрөгийн, машин тоног төхөөрөмж 87,250,647 төгрөгийн, тавилга 183,048,532 төгрөгийн, ном сурах бичиг 26,447,955 төгрөгийн, программ хангамж 132,000 төгрөгийн хөрөнгийг бүртгэж авснаар өссөн байна.

**Да. Дархан. Сургууль /31-р/ (+16,696.1 сая)**

Шинээр 2024 онд байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн сургуулийн хөрөнгийг Төрийн бодлого зохицуулалтын газраас 2025 онд гарсан тогтоолоор санхүүгийн тайланд хөрөнгийг бүртгэж авснаар өссөн байна. /тогтоолын сар өдөр дугаар оруулах/

**Да. Дархан. Сургууль /9-р/ (+7,699.1 сая)**

Шинээр 2024 онд байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн сургуулийн хөрөнгийг Төрийн бодлого зохицуулалтын газраас 2025 онд гарсан тогтоолоор санхүүгийн тайланд хөрөнгийг бүртгэж авснаар өссөн байна. /тогтоолын сар өдөр дугаар оруулах/

**До. Замын-Үүд. Сургууль /4-р/ (+9,984.1 сая)**

Тайлант он буюу 2025 оны 08 сард 640 хүүхдийн хичээлийн шинэ байр 9,200,000,000 төгрөг, бусад үндсэн хөрөнгө болох ширээ сандал, ном сурах бичиг болон бусад хөрөнгийн 784,081,672.43 төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

**Ду. Сайнцагаан. Сургууль /2-р/ (+14,286.8 сая)**

Шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн сургуулийн хөрөнгийг Төрийн бодлого зохицуулалтын газраас 2025 онд гарсан тогтоолоор санхүүгийн тайланд хөрөнгийг бүртгэж авснаар өссөн байна. /тогтоол шийдвэр/

**Ду. Сайнцагаан. Сургууль /3-р/ (+11,177.9 сая)**

Шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн сургуулийн хөрөнгийг Төрийн бодлого зохицуулалтын газраас 2025 онд гарсан тогтоолоор санхүүгийн тайланд хөрөнгийг бүртгэж авснаар өссөн байна. /тогтоол шийдвэр/

**МБСБ - Орхон аймаг дахь Политехник коллеж (+9,834.7 сая)**

ТӨБЗГ-ын даргын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 700 тоот тогтоолын дагуу 2013 оноос баригдаж эхэлсэн МСҮТ-ийн хичээлийн байр 10,557,657,904 төгрөгийн өртөг бүхий барилгыг хөрөнгийн орлогод бүртгэж, 2025 оны 05 дүгээр сарын 01-ны өдрийн 229 тоот тогтоолын дагуу Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургуулиас балансаас балансад 1 машин шилжилж ирсэн.

**Монгол тэмүүлэл - Олон Улсын Хөтөлбөрийн Сургалттай Төрийн Өмчит ЕБС (+8,056.8 сая)**

Шинэ барилга хүлээн авсантай холбоотой хөрөнгө өссөн.

**Монгол Улсын Их сургууль (+6,936.9 сая)**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 114,023.5 сая төгрөг болж 6,936.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд: - Тайлант хугацаанд 10,236.8 сая төгрөгийн хөрөнгө өөрийн хөрөнгөөр худалдан авч, 5,334.7 сая төгрөгийн хөрөнгө хандив тусламжаар хүлээн авсан; - ТӨБЗГ-ын 2025 оны 399, 452 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн 1,761.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассан тайлант үед 8,506.8 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон. /тайлбарын дүн таарахгүй байна, мөнгөн нэгж задлах/

**Өв. Бат-Өлзий 2-р сургууль (+7,483.4 сая)**

Хичээлийн 440 хүүхдийн байр нь 2023 онд ашиглалтад орсноор сумын 1 дүгээр сургуулийн балансад бүртгэгдсэн байсан ба 2025 онд аймгийн ИТХ-ын шийдвэрээр 1 дүгээр сургуулиас 2 дугаар сургууль руу барилгыг нь шилжүүлсэн. /шийдвэрийн он сар дугаар байна уу итх хөрөнгө шилжүүлэх эрх байх уу/

**Өв. Хархорин. Сургууль /1-р/ (+7,177.3 сая)**

Хичээлийн 320 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн өргөтгөл 2025 онд баригдаж ашиглалтад орсныг аймгийн ИТХ-ын шийдвэрээр балансад бүртгэсэн шийдвэрийн он сар дугаар байна уу итх хөрөнгө шилжүүлэх эрх байх уу/

**Өм. Даланзадгад. Сургууль /2-р/ (+6,888.1 сая)**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Даланзадгад сумын Ерөнхий Боловсролын 2-р сургуулийн Дотуур байр баригдаж 2025 оны 12 сард улсын комисс хүлээн авсантай холбогдолтойгоор сургуулийн дотуур байрыг хөрөнгөд бүртгэж авсан. /хөрөнгө балансад авах тогтоол шийдвэр байгаа юу/

**Өм. Даланзадгад. Сургууль /6-р/ (+19,605.5 сая)**

2025 оны 3 сард шинээр ашиглалтанд орсон ба барилга 18,045,356,323.36, то.тө-824,952,497.61, 718,013,471.67 тавилга шинээр бүртгэсэн

**Сү. Баруун-Урт. Сургууль /3-р/ (+10,028.3 сая)**

Шинээр сургуулийн барилга ашиглалтанд орсон тул бүртгэлд тусгасан.

**Тө. Зуунмод. Сургууль /3-р спортын төрөлжсөн/ (+6,148.5 сая)**

Төв аймгийн Засаг даргын 2025 оны А/601 тоот захирамжаар Зуунмод сумын 5-р сургууль, Спортын сургуультай нэгтгэх, бүтэц зохион байгуулалтыг өөрчилсөн ба ажлын хэсэг данс тооцоо, үндсэн хөрөнгө, биет хөрөнгийг тоолж нэгтгэн ажилласан байна.

**Уб. Бг. Сургууль /28-р/ (+15,513.8 сая)**

2025 онд 960 хүүхдийн хичээлийн шинэ байр ашиглалтанд орсон. Барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад тоног төхөөрөмж нэмэгдсэн.

**Уб. Бг. Сургууль /93-р/ (+12,096.5 сая)**

2025 онд 640 хүүхдийн хичээлийн шинэ байр ашиглалтанд орсон. Барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад тоног төхөөрөмж нэмэгдсэн.

**Уб. На. Сургууль /Голомт, цогцолбор/ (+11,908.7 сая)**

Хичээлийн шинэ байраа орлогод авсан.

**Уб. Сх. Сургууль /12-р/ (+20,545.3 сая)**

2024 онд ашиглалтад орсон хичээлийн А байраа орлогод авсан.

**Уб. Сх. Цэцэрлэг /341-р/ (+6,490.5 сая)**

Шинээр ашиглалтанд орсон тул цэцэрлэгийн барилгыг орлогод авсан.

**Уб. Чи. Сургууль /5-р/ (+6,714.5 сая)**

Бага сургууль ашиглалтанд орж барилга шинээр бүртгэж авсан.

**Ув. Улаангом. Сургууль /Шинэ ирээдүй, цогцолбор/ (+15,557.1 сая)**

Шинээр сургуулийн барилга ашиглалтанд орсон тул бүртгэлд тусгасан.

**Ув. Хяргас. Сургууль /Ахлах/ (+7,579.9 сая)**

Шинээр сургуулийн барилга ашиглалтанд орсон тул бүртгэлд тусгасан.

**Хө. Жаргалант. Сургууль (+14,571.7 сая)**

2025 онд 640 хүүхдийн хичээлийн байр ашиглалтанд орсон. Мөн нөхөн хангалтын тавилга тоног төхөөрөмж нэмэгдсэн.

### **Хө. Чандмань-Өндөр. Сургууль (+6,796.3 сая)**

2025 онд 320 хүүхдийн хичээлийн байр ашиглалтанд орсон. Бусад тоног төхөөрөмж тавилга нэмэгдсэн.

### **Хэ. Жаргалтхаан. Сургууль /11 жилийн/ (+7,141.4 сая)**

Шинээр сургуулийн барилга ашиглалтанд орсон тул бүртгэлд тусгасан.

### **АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТЫН НЭГТГЭЛ (+23,353.3 сая)**

20 АЗЗА-ТӨХК-ийг 2025.04.11-ний өдөрөөр тасалбар болгон татварын ерөнхий газараас хасалтын картаар татан буулгаж тайлан балансыг албан ёсоор нэгтгэсэн. Үндсэн хөрөнгийн өсөлт огцом өссөн байгаа нь 20 ТӨХК-тай баланс нэгдээгүй байсны эхний үлдэгдэл бөгөөд 20 сарбарын авлага нийлсэнээр өндөр өсөлттэй харагдаж байна.

### **Авто тээврийн үндэсний төв (+14,003.3 сая)**

Үндсэн хөрөнгийн 10 данстай холбоотой нийт 4.4 тэрбум төгрөгийн орлого болон 2.2 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн. Агуулах хоорондын 1.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Элэгдлийн зардал 921.0 сая төгрөг байна. 2025 онын санхүүгийн тайлангаар Биет үндсэн хөрөнгө -2.6 тэр бум төгрөгөөр, Дуусаагүй барилга данс -"Тээвэрчдийн ордны барилга"-9.6 тэр бум, Цогтцэций салбар барилга-1.5 тэр бум төгрөг, ХО-ын дагуу биет бус хөрөнгө болох Программ хангамж- 274.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

### **Иргэний нисэхийн үндэсний төв (+616,244.6 сая)**

ТӨБЗГ-ын 136, 438 дугаар тогтоол, ИНЕГ-ын А/627 дугаар тушаалаар ИНЕГ-т үлдэх ҮХ болон Чингисхаан ОУНБ дах ШХА-29 албаны үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн мөн тайлант хугацаанд хөрөнгүүдэд элэгдэл тооцсон, мөн хөрөнгө оруулалттай холбоотойгоор өссөн байна.

### **Монголын төмөр зам (+432,703.5 сая)**

1.ТӨБЗГ-ын 2025 оны 797 дугаар тогтоолыг үндэслэн ТТ-3Б чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын үр дүнд бий болсон 1,272.9 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, замын дээд бүтций хөрөнгөд орлого авсан. 2.ТӨБЗГ-ын 2025 оны 34-р тогтоолыг үндэслэн 6.6 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг “Дархан төмөрлөгийн үйлдвэр”ХХК-д шилжүүлсэн. 3.ТӨБЗГ-н А-1/1764 тоот албан бичгийн хүрээнд 13. тэрбум төгрөгний 8ш цахилгаан эрчим хүч дамжуулах шугамын газар орлогод авснаар биет бус хөрөнгийн дүн нэмэгдсэн.

### **Эрчис ойл (+50,453.9 сая)**

Тайлант Үндсэн хөрөнгийн 2025 оны эхний үлдэгдэл 51,999,946.84 төгрөг эцсийн үлдэгдэл 49,216,952,566.74 төгрөг үндсэн хөрөнгө 49,164,925,619.9 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Монгол улсын засгийн газрын 2025 оны 03 дугаар 19-ний №146 дугаар тогтоол,Төрийн өмчийн хорооны 2025 оны 10 сарын 23-ны №513 тоот тогтоолоор Замын-Үүд дэх “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үл хөдлөх үндсэн хөрөнгө болон бусад эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авах, Монгол улсын засгийн газрын 2025 оны 03 сарын 19-ний №136 дугаар тогтоол, Монгол улсын засгийн газрын 2025 оны 03 сарын 06-ны №116 тоот тогтоолоор тус тус балансаас балансад шилжүүлэн авсан.

### **Малын удмын сангийн үндэсний төв (+13,037.0 сая)**

Малын удмын сангийн захиралын 2025-12-05 өдрийн А/148 тоот тушаалаар бараа материалын мал амьтад данснаас 13,513,475,468.03 -н мал амьдтыг үндсэн хөрөнгийн биелогийн хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэсэн.

### **Амгалан дулааны станц (+9,620.3 сая)**

116МВт зуухны өргөтгөлийн төсөл бүрэн хэрэгжиж, улсын комисс хүлээн авсан тул холбогдох тоног төхөөрөмж, хөрөнгийг бүртгэлд тусгасантай холбоотой өссөн.

### **Диспетчерийн үндэсний төв (+52,259.8 сая)**

Нийт 70,033,677,736.41 төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийн 12,305,280,868.76 төгрөг нь үндсэн хөрөнгө, 57,728,396,867.65 төгрөг нь НХА-ын тарифын ЦЭХ худалдах, худалдан авах үнэ өртгийн сөрөг зөрүү буюу тайлант хугацааны алдагдлыг нөөц хөрөнгөөр /бусад эргэлтийн бус хөрөнгөөр/ бүртгэсэн. Үүнд: 1. Улирал бүр

хийдэг тарифын зохицуулалтаас шалтгаалж ҮТЗЭ-дээс худалдаж авах цахилгаан эрчим хүчний дундаж өртөг 23.34%-иар өссөн. 2. ДЦС-3 дээр гарсан аваартай холбоотойгоор чадлын тарифыг өсгөсөнтэй холбоотой. 3. 2025 оны I улиралд “Бөөрөлжүүт ДЦС”, II улиралд “Улаанбаатар энержи”, III улиралд “Тосон” ДЦС гэх зэрэг өндөр тарифтай эх үүсвэрүүд ашиглалтанд орж шинээр нэмэгдсэн 4. Импортын ЦЭХ-ний тарифын хэлэлцээр улирал бүр хийгдэж худалдан авсан ЦЭХ-ний дундаж өртөг 2024 оноос 28 % өссөн. 5.10-р сарын 1-нээс “Нэг худалдан авагчтай загвар”-ын бүтцийн өөрчлөлтийн дагуу баруун бүсийн импортын ЦЭХ-ний төлбөр 34.7 тэрбум төгрөгийг “Нэг худалдан авагч” төлсөн. 6. Импортлосон ЦЭХ-ний төлбөрийг төлөх үеийн ханшийн алдагдал.

### **Улаанбаатар дулааны сүлжээ (+35,669.2 сая)**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 05-р сарын 01-ний өдрийн 218 дугаар тогтоолоор хувийн хэвшлийн хуулийн этгээдээс өөрийн хүсэлтээр 637.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий ф250мм голчтой шугам хоолойг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн. ЕСБХБ-ны зээлээр санхүүжүүлсэн “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл”-ийн хүрээнд 4,611.4 сая төгрөгийн үнэ бүхий Скада хяналтын системтэй цахилгаан активатори бүхий бөмбөлгөн хаалт, 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 711 дүгээр тогтоолоор 3,302.2 сая төгрөгийн Бичил хорооллыг хангах дулааны шугам шинээр татах ажил ф400мм голчтой шугам хоолой нийт 7,913.7сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. Дэлхийн банкны зээлийн санхүүжилтээр “Улаанбаатар хотын дулааны хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд 9,019.7 сая төгрөгийн үнийн дүн бүхий 9Г магистраль ф500мм голчтой шугам хоолой, тусгай зориулалтын ачааны автомашин, 336.3 сая төгрөгийн балансын үнэ бүхий 2 ширхэг тээврийн хэрэгсэл, нийт 9,356.1сая төгрөгийн үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн. Хөрөнгийн дахин үнэлгээгээр 4,063.4 сая төгрөгийн үнийн дүн бүхий үндсэн хөрөнгийг бүртгэн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэн, Баянгол дүүргийн 15-р хорооны нутаг дэвсгэр дэх 239мкв талбайтай “Нарлаг худалдааны төвийн зүүн талаас бичил 6 дугаар хороолол буюу 28-р сургуулийн баруун хойд тал хүртэл шинээр барих дулааны шугамын дулаан дамжуулах төвийн газар, Хан-Уул дүүргийн 17-р хороо нутаг дэвсгэр дэх 40,198мкв талбайтай “Хийн дулаан станц” зориулалттай нийт 3,864.1 сая төгрөгийн үнийн дүн бүхий эзэмших эрхтэй газрыг бусад өмчид бүртгэсэн нийт 7,927.6сая төгрөгөөр бүртгэсэн.

### **Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ (+60,612.4 сая)**

"Үндсэн хөрөнгө цэвэр дүнгээрээ /Дансны үнэ 643,219.0 сая төгрөг, хуримтлагдсан элэгдэл 217,288.1 сая төгрөг / өмнөх оноос 60,830.6 сая төгрөг буюу 17 хувиар өссөн, өмнөх жилүүдийн өсөлттэй харьцуулбал, дундаж өсөлт болно. 2022 оноос хойш балансын үзүүлэлтээр үндсэн хөрөнгө нь 15 хувиар өсөлттэй байна. 2025 онд хувь хүн, хуулийн этгээдээс хүлээн авсан хөрөнгө 29,318.09 сая төгрөг, улс нийслэлийн хөрөнгө оруулалтаарх хөрөнгө 6,761.8 сая төгрөг байна. Тайлант оны үндсэн хөрөнгийн өсөлтийг задалж үзвэл, -Улсын, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлийн бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах” багц ажлуудын 35/10 кВа дэд станц, ЦДАШ 35/10кВ, ЦДКШ 35/10кВ, 10кВ-ийн шугамууд, хувиарлах дэд станц, ХТП, АТП, айл өрхийн тоолуур, щит зэрэг нийт 6,671.8 сая төгрөг - Иргэн, аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан гадна цахилгаан хамгамжийн ХТП, АТП, ЦДКШ, ЦДАШ, хэрэглэгчийн тоолуур хэмжих хэрэгсэл, щит хүлээн авч 29,318.0 сая төгрөгөөр бүртгэсэн. - Их засвар, техник зохион байгуулалтын ажлаар 82,068.6 сая төгрөгийн хөрөнгийг шинээр бүртгэлд тусгаж авсан. Үүний 25,031.9 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын өгөөжөөр буюу Ухаалаг тоолуур төслийн хөрөнгө байна.

### **Хөвсгөл дулааны станц (+7,029.6 сая)**

Үндсэн хөрөнгө 1056.1 сая төгрөгөөр буурч, биет бус хөрөнгө 8091.1 сая төгрөгөөр нэмэгдэж, хойшлогдсон татварын хөрөнгө 5.5 сая төгрөгөөр буурсан нь нийт эргэлтийн бус хөрөнгө өмнөх оноос 7029.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Орон нутгаас 8092.7 сая төгрөгийн газрыг ТӨБЗГазрын зөвшөөрлөөр хүлээн авсан нь эргэлтийн бус хөрөнгө нэмэгдэхэд гол нөлөөг үзүүлсэн байна.

### **Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ (+63,800.1 сая)**

Засгийн газрын 2025 оны 30 дугаар тогтоолын дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 604, 605 дугаар тогтоолоор Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК болон Алтай-Улиастайн эрчим хүчний систем

ТӨХК-аас шилжиж ирсэн хөрөнгө, болон ИЗА ТЗБАХ хөрөнгө орлуулалтын төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг хийж хөрөнгө бүртгэсэн.

### **Эрдэнэтийн ДЦС (+204,851.0 сая)**

ТГ -4 өртгөтгөлийг орлогод авч бүртгэлд тусгасан.

### **Академи - Одон орон, геофизикийн хүрээлэн (+8,589.7 сая)**

2025 онд нийт нэмэгдсэн хөрөнгийн дүн 10,765,457,931.57 төгрөг. Үүнээс: - Улсын төсвийн хөрөнгөөр 361,040,382.30 төгрөгний худалдан авалт хийсэн ба 4 нэр төрлийн тендер зарлагдсан болно. - Нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас буюу өөрийн хөрөнгөөр нийт 129,283,500.00 төгрөгний хөрөнгө бэлтгэн, ТӨБЗГ-ын 2025.09.24 А-1/1755, 2025.09.24 А-1/1767 тоот зөвшөөрлийн бичгийн дагуу хөрөнгө бүртгэлд авсан болно. - Арилжааны банкны харилцах данс буюу Гадны зээл тусламж, буцалтгүй хөрөнгөөр нийт 562,581,500.00 төгрөгний хөрөнгө бэлгэсэн. Дээрх худалдан авсан хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” тухай 271 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 4.1.1 дэх хэсэгт “Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэсэн болон хандив, тусламж, бэлэглэл төслийн шугамаар бий болсон хөдлөх хөрөнгийг бүртгэлд тусгахад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авах шаардлагагүй” гэж заасан байдаг. Үнэ төлбөргүйлгээр хүлээн авсан хөрөнгийн дүн 9,712,552,549.27 төгрөг. Үүнээс: Монгол Улсын Засгийн Газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн системээр дамжин үнэ төлбөргүйгээр орж ирсэн хөрөнгийн бүртгэл: - Монгол Улс болон Франц Улсын Засгийн газрын хооронд байгуулагдсан “Геофизикийн салбарт хамтран ажиллах тухай” 1996 оны гэрээний дагуу Франц Улсын Засгийн газрын хөрөнгөөр манай оронд байгуулсан газар хөдлөлтийг бүртгэх станцуудын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор Франц улсын Цөмийн Энергийн Комиссириатын Хүрээлэн Орчны Хяналтын Департамент нь 2025 онд тус хүрээлэнрүү “Цөмийн Туршилтыг Бүрэн Хориглох” гэрээний дагуу 6,548,519,932.22 (зургаан тэр бум таван зуун дөчин найман сая таван зуун арван есөн мянга есөн зуун гучин хоёр төгрөг 22 мөнгө) төгрөгийн багаж тоног төхөөрөмж үнэ төлбөргүйгээр явуулсан. Үүнд: серверийн компьютер, газар хөдлөлийн хэмжигч багаж, Агаар мандлын цацраг идэвхи хэмжигч цогц төхөөрөмж болох SPALAX NG болон бусад багаж тоног төхөөрөмжүүдийг машин тоног төхөөрөмж дансанд бүртгэсэн болно. 2025.12.26-ны өдөр 679 тоот албан бичгээр ТӨБЗГ-т мэдээлэл хүргэсэн болно. - Тус хүрээлэнд хэрэгжиж буй гадаад хамтын ажиллагааны төслийн хүрээнд манай хариуцан ажиллуулдаг чичирхийллийн хяналтын станцуудын хэвийн үйл ажиллагааг хангах, техникийн болон засвар үйлчилгээг хийх зориулалтаар ашигладаг 3 ширхэг Ланд круйзер 71 авто машиныг 141,000,000.00 (нэг зуун дөчин нэг сая) төгрөгөөр авто тээврийн хэрэгсэл дансанд бүртгэсэн, ТӨБЗГ-ийн 2026.01.13 өдөр А-1/80 тоот зөвшөөрөл олгох бичгийн дагуу бүртгэж авсан болно. - Ази, Номхон далан хамтын ажиллагааны байгууллага (APSCO)-аас үнэ төлбөргүйгээр Дэлхийн соронзон орны хувьслыг 1 сек нарийвчлалтай бүртгэх Соронзон хувьслын станц болох Магнетометр 169,051,500.00 (нэг зуун жаран есөн сая тавин нэг мянга таван зуун) төгрөгөөр машин тоног төхөөрөмж дансанд бүртгэсэн, - Худалдан авах ажилын хүрээнд Саммит компьютер технологи ХХК-аас үнэ төлбөргүйгээр Benq дэлгэц 999,900.00 (есөн зуун ерөн есөн мянга есөн зуу) төгрөгөөр машин тоног төхөөрөмж дансанд бүртгэсэн. - Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/28 дугаар тушаалаар Засгийн газрын нөөц сангийн 1 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Одон орон судлах оргилд шинээр барих дурангийн байгууламжийн зураг төсөл болон хүрээлэнгийн гадна тохижилт, ажилчдын амралтын байрны засвар, холбогдох тоног төхөөрөмж худалдан авах эрхийг Шинжлэх Ухааны Академид шилсэн. Тус ажилын хүрээнд ажилчдын амралтын байрны засвар, зам засвар, хурлын танхимын тоног төхөөрөмж болон тавилга эд хогшил 911,145,820.00 төгрөгөөр худалдан авсанг, ТӨБЗГ-ын 2026 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 31 тогтоолоор хөрөнгийн дансанд бүртгэсэн болно. - Тус хүрээлэнгийн бараа материалын дансанд бүртгэлтэй байсан 74,922,084.55 төгрөгний сэлбэг хэрэгсэлийг ТӨБЗГ 2026 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн А1/76 тоот зөвшөөрөл олгох бичгийн дагуу шилжүүлэн бүртгэсэн. 1. ТӨБЗГ-ын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн №220, ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 24-ий өдрийн №815 дугаар тогтоолын дагуу ашиглах хугацааг сунгаж, үнэ шинэчлэн тогтоосон хөрөнгийн дүн 1,866,913,312.50 төгрөг. 2025 онд нийт хасагдсан хөрөнгийн дүн 2,767,535,478.13 төгрөг байна. 1. ТӨБЗГ-ын 2025 оны 05 дугаар сарын 01-ний №239, 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн №896 тоот тогтоолын дагуу акталсан хөрөнгийн дүн 262,013,837.51 төгрөг байна. 2. ТӨБЗГ-

ын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн №220, ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 24-ий өдрийн №815 дугаар тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 2,330,391,640.62 төгрөгийн хөрөнгийн ашиглах жилийг сунгаж үнэ шинэчлэн тогтоосон болно. 3. Хот байгуулалт, хотын стандартын газраас 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр тус хүрээлэнд 2 ширхэг нийт 175,130,000.00 төгрөгний иж бүрэн Хөрсний хурдатгал хэмжтгч багаж өгч, хүрээлэнгийн хөрөнгөнд бүртгэн авч газар хөдлөлтийн хэмжилтэнд ашиглаж байсан ч 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Хот байгуулалт, хотын стандартын газраас “Нийслэлийн Дотоод Аудитын Улсын ахлах байцаагчийн актаар дээрх хөрөнгийг эргүүлэн татах тухай” 01/728 тоот албан бичиг ирсэн тул, ТӨБЗГ-аас Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл хүсч 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн №459 тогтоолын дагуу дээрх нэр бүхий 2 ширхэг иж бүрдэл Хөрсний хурдатгал хэмжигч багажийг Хөрөнгийн данснаас хассан болно.

#### **Монгол улсын хөгжлийн банк (+52,508.1 сая)**

Борлуулах зориулалттай хөрөнгөөр бүртгэсэн дуусаагүй барилгуудыг бусад хөрөнгө рүү эрсдэлийн сангаар цэвэршүүлж, шилжүүлж бүртгэсэн.

#### **Үндэсний дата төв /ЦХИХХС/ (+18,265.6 сая)**

Өглөгийн үлдэгдэл 1,567,120,662.57 төгрөгөөр буурсан нь үндсэндээ нийлүүлэгч байгууллагуудтай хийсэн төлбөр тооцоог хугацаанд нь барагдуулсан, урьдчилгаа болон тооцоо нийлүүлэлтээр суутгасан дүнгийн нөлөөлөлтэй холбоотой. Тайлант хугацаанд үүссэн шинэ өглөг өмнөх хугацааны төлөлтийг нөхөөгүй тул нийт өглөгийн хэмжээ буурсан байна.

#### **Цэцэрлэг хотын хот тохижилтийн газар (+13,661.1 сая)**

2024 онд төсвийн байгууллага байсан ба 2025 онд ОНӨААТҮГ болон өөрчлөгдснөөр өссөн байна.

#### **ЦШСГазар (+8,564.2 сая)**

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Алтай Таван Богдын бүсэд шинээр цахилгаан хангамж 3,548.1 мянган төгрөг, Цэнгэл сумын 1,2 дугаар заставт цахилгаан хангамж 3,724.7 мянган төгрөг, Өлгий сумын айл өрхүүдэд ухаалаг тоолуур тавих зардалд 367.3 мянган төгрөг, Өлгий сум болон бусад сумдад дэд станц барихад 514.3 мянган төгрөгөөр хийгдсэн хөрөнгө бүртгэгдсэн. Байгууллагын өөрийн хөрөнгөөр тээврийн хэрэгсэл 177.0 мянган төгрөгөөр, бусад тавилга, тоног төхөөрөмж 232.7 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэн тайлант онд хөрөнгийн орлогод авсан байна.

#### **До. Өргөн. Засаг даргын тамгын газар (+6,454.2 сая)**

Туслах замаас сумын төв хүртэлх 18.3 км зам 6.3 тэрбум, Сүмбэр багт скайтелийн сүлжээ оруулсан 300.0 сая төгрөгийн биет бус хөрөнгийг бүртгэсэн.

#### **До. Сайншанд. Хот тохижилтийн алба (+23,869.1 сая)**

Сайншанд хотын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02/06 дугаар тогтоолоор Сайншанд тохижилт үйлчилгээний газар болон Захирагчийн ажлын алба гэж бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэн. Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 04/02 дугаар тогтоолоор 11.3 тэрбум төгрөгийг хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авсан. Мөн ОНХО-аар 12.5 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

#### **Гурвансайхан орон сууцны корпораци (+7,850.4 сая)**

2025 онд нийт 8,585,624.6 мянган төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

#### **Гүний ус (+11,087.8 сая)**

2025 онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн цэвэр бохир усны шугам сүлжээний өргөтгөлийг бүртгэсэн болно.

#### **Өм. Даланзадгад хотын ЗААлба (+22,705.5 сая)**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 2,134,443,736 төгрөгийн Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн барилга, 311,722,500 төгрөгийн авто тээврийн хэрэгсэл,

22,836,052.15 төгрөгийн Тавилга, аж ахуйн эд хогшил, 13,476,410,063 төгрөгийн авто зам, Зам, гүүрийн байгууламж болон Бусад үндсэн хөрөнгийг шинээр орлого авсан байна.

**Өм. Ханбогд. Засаг даргын тамгын газар (+57,645.1 сая)**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн бүтээн байгуулалт хөрөнгийн нэмэгдэл Зам, зогсоол, барилга байгууламж, Мөн аймгаас хийгдсэн дэмчогийн зам Онцгойн 66 ангийн барилга бусад хөрөнгө оруулалтаар бий болсон үндсэн хөрөнгийн нэмэгдсэн дүн.

**Өм. Ханхонгор. Засаг даргын тамгын газар (+18,800.9 сая)**

2025 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХСан, Говийн оюу хөгжилийг дэмжих сан болон бусад эх үүсвэрээр бий болсон 20,104,332.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгасан ба үүний дотор Даланзадгад Ханхонгор сумын чиглэлийн 12.5 км зам ашиглалтанд орж 18,019,517,158 төгрөгөөр замын байгууламжийг бүртгэсэн болно.

**Өм. Цогтцэций. Засаг даргын тамгын газар (+18,936.8 сая)**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 26-н төсөл арга хэмжээг үндсэн хөрөнгийн бүртгэлд шинээр бүртгэсэн.

**Тэгш дүүрэн тохижилт (+7,698.6 сая)**

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах барилга, байгууламж, офиссын барилга болон Хог тээвэрлэх машин, техник хэрэгслээр хангах, тавилга хэрэгслээр хангах ажлуудыг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн.

**Хөгжил хөрөнгө оруулалтын газар (+11,144.7 сая)**

Улаанбаатар хот дахь оюутны хотхны барилга байгууламж, тавилга аж ахуйн эд хогшил, тоног төхөөрөмж шинээр нэмэгдсэн.

**Дөрвөлж (+13,825.4 сая)**

Дамжууланзээлээр баригдсан барилга байгууламжийг хөрөнгөд бүртгэх холбогдох байгууллагын шийдвэрийн дагуу ашиглагч байгууллагад хөрөнгөд бүртгэсэн.

**Тө. Батсүмбэр. Засаг даргын тамгын газар (+8,673.2 сая)**

Цогт-Өндөр, Үдлэг 2 багт бага сургуулийн Сөгнөгөрийн услалтын системийг шинээр бүртгэн авсан.

**Тө. Баян. Засаг даргын тамгын газар (+8,492.5 сая)**

шинээр 8 газар орлого авсан.

**Тө. Зуунмод. Засаг даргын тамгын газар (+13,077.4 сая)**

Зуунмод сумын нийтийн эзэмшлийн 38 газрыг дахин үнэлээд 9,2 төгрөгөөр нэмэгдүүлэн орлогдож авсан.

**Улаангом тохижилт үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газар (+21,036.4 сая)**

Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь 19,1 тэрбум төгрөгийн зам гүүрийн байгууламжийн үндсэн хөрөнгийг баланс хооронд шилжүүлэн авсан ба аймаг, сумын ХО-аар хийгдсэн 2.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусшасан.

**Хо. Мөст. Засаг даргын тамгын газар (+9,675.6 сая)**

Мөст сумын Засаг даргын тамгын газар 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан замын барилга байгууламжийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр орлого авсан учир үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

**Хө. Мөрөн. Засаг даргын тамгын газар (+6,983.2 сая)**

Хот тохижилт үйлчилгээний төв ХХК татан буугдаж Үндсэн хөрөнгийг Аймгийн ИТХ-ын шийдвэрээр балансаас балансад шилжүүлэн авсан, мөн УЛС аймаг, сумын хөрөнгө оруулалтаар хийгдсэн нийтийн эзэмшлийн хөрөнгүүд бүгд ЗДТГ-т бүртгэгддэг.

### **Хэнтий-Ус (+44,581.8 сая)**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй ирсэн Бэрх станцын 15.0 тэрбум болон 1.2-р багийн шугам сүлжээний 29.4 тэрбумыг тайлант онд бүртгэж авсан

### **Да. Дархан. Засаг даргын тамгын газар (+7,200.1 сая)**

УТЭШХО-аар хэрэгжсэн Дархан сумын 1,2,3 дугаар багийн төвийн барилга 6373.7 сая, ХХААЯамнаас бичил үйлдвэр үйлчилгээг дэмжих зорилгоор мах боловсруулах цех тоног төхөөрөмж 956.3 сая төгрөг бүртгэлд тусгаж хөрөнгө нэмэгдсэн.

### **Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ (+25,294.7 сая)**

Нийслэл болон дүүргийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө.

### **Зорчигч тээвэр 2 (+23,976.8 сая)**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 91,743,857.81 мянган төгрөг болж өмнөх оноос 23,976,830.37 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Барилга байгууламж дансанд Нийслэлийн засаг даргын 2022 оны 02-р сарын 01-ний өдрийн А/124 тоот захирамжын хүрээнд депогийн их засварын ажил 2,288,403.36 мянган төгрөг, 2024 оны дээврийн засварын ажлын урьдчилж төлсөн зардлаар бүртгэгдсэн 266,0 сая төгрөгөөр тус тус капиталжуулсан, Компьютер дагалдах хэрэгсэлд Нийслэлийн Засаг даргын 2025 оны Н/25 тоот захирамжыг үндэслэн 2,266,825.73 мянган төгрөгийн хөрөнгө, Биет бус хөрөнгөнд мөн захиармжийг үндэслэн 507,306.80 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн. Тээврийн хэрэгсэл данс нэмэгдсэн нь Нийслэлийн засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/1349 тоот захирамжын дагуу 15 ширхэг Skyworth загварын 10,836,681.47 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, Нийслэлийн засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/688 тоот захирамжыг үндэслэн Yutong загварын их багтаамжийн автобус 14,809,437.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус орлогод авсан.

### **Зорчигч тээвэр 3 (+9,186.5 сая)**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 48,045,745.53 мянган төгрөг болж өмнөх оноос 9,462,122.29 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Нийслэлийн засаг даргын 2025 оны А/800 дугаар захирамж, “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГазрын даргын А/47 тоот тушаалаар автобус паркийн угаалгын цех, кузов засварын барилга, байгууламж 3,154,329,14 мянган төгрөг, Нийслэлийн засаг даргын 2025 оны А/1308 дугаар захирамж, “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГазрын даргын А/76 тоот тушаалаар Шатахуун түгээх станцын барилга 184,000 мянган төгрөгөөр, Нийслэлийн Засаг даргын А/1428 дугаар захирамж, Даргын А/66 дугаар тушаалаар 3 дугаар гараашийн барилга 7,978,139.2 мянган төгрөгийг данс бүртгэлд тусган орлогод авсан орлогод авсан, Нийслэлийн Өмчийн харилцааны газрыг албан бичгээр Ай Ст Ти групп ХК-аас хүлээн авсан хөрөнгийг Даргын А/85 тоот тушаалаар орлогод авсан. Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГазрын даргын тушаалаар нийт Машин тоног төхөөрөмж 223,907.89 мянган төгрөг, Компьютер дагалдах хэрэгсэл 164,978.00 мянган төгрөг, Тээврийн хэрэгсэл 134,200.00 мянган төгрөг, тавилга эд хогшил 54,055.00 мянган төгрөг, 10,670.00 мянган төгрөгөөр бусад хөрөнгийг данс бүртгэлд бүртгэсэн.

### **Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ (+9,622.4 сая)**

Үндсэн хөрөнгө нь тайлант онд 9,622,353,976.48 төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнийг задалж үзвэл 170,501,472.20 төгрөгийн хөрөнгийг балансаас балансад буюу өөр байгууллагад шилжүүлсэн. /Үүнээс 104,518,400 төгрөгийн газар эзэмших эрх буюу биет бус хөрөнгө болно/. 476,171,701.57 төгрөгийн хөрөнгийг акталж, урт хугацаат өр төлбөрөөр 7,027,140,500 төгрөгийн хөрөнгийг худалдан авч, орон нутгийн төсвийн хөрөнгийн санхүүжилтээр үнэ төлбөргүйгээр 3,986,897,800 төгрөгийн тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгсэл нэмэгдэж, бараа материал болон тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй байсан үндсэн хөрөнгийн шинж чанартай 189,135,500 төгрөгийн хөрөнгийг машин тоног төхөөрөмжийн дансанд шилжүүлэн бүртгэсэн Нийт 11,087,555,834 төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж 870,676,788.17 төгрөгөөр хөрөнгө хасагдаж, 1,848,582,937.39 төгрөгөөр элэгдэл тооцсон болно.

### **Төв цэнгэлдэх хүрээлэн (+17,890.9 сая)**

Төв цэнгэлдэх хүрээлэнгийн 12661 мкв 17,833,728,000 төгрөгийн газрыг өмчийн харилцааны газрын даргын тушаалаар үнэ төлбөргүйгээр биет бус хөрөнгөд өмчид гаргасан өөрчлөлтөөр орлогод авсан мөн төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө худалдан авсан.

#### **Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ (+21,931.8 сая)**

2025.10.22-ны НЗД-н А/1484 Захирамж. НЗДТГ-н Багаж тоног төхөөрөмжийн зардлаас 31.000.000, 2025.10.13-нд Суурин компьютер 10ш нийт 49.077.000, НАОБТГ-ын даргын 2024.12.10-ны 01/958 Угаарын хий мэдрэгчийн төхөөрөмжийн төлбөр 157.000 ш 150.000 төгрөгөөр нийт 23.550.000.000 болсоныг бүртгэсэн болно.

#### **Уб. Бз. Засаг даргын тамгын газар (+16,039.2 сая)**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 207,004,549.0 мянган төгрөг болж 16,039,208.0 мянган төгрөгөөр өссөн нь НӨХГ-ын 1/1640 дугаар албан бичгээр 1,966,800.0 мянган төгрөгийн 16 дугаар хорооны ӨЭМТ-ын барилга, гадна тохижилт, явган зам, НӨХГ-ын 1/1702 дугаар албан бичгээр 42,220.8 мянган төгрөгийн Налайх дүүргийн цагдаагийн постын газар, барилга, Нийслэлийн Засаг даргын 03/6183 дугаар захирамжаар 114,474.0 мянган төгрөгийн өртөг бүхий автобусны хяналтын камер, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 34,653,489.7 мянган төгрөгийн авто зам, гэрэлтүүлэг, тохижилтын ажлууд, 298,750.0 мянган төгрөгийн барилга, 271,522.4 мянган төгрөгийн компьютер, принтер, 500,750.0 мянган төгрөгийн цагаан давааны хог дээр баригдсан цаас боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 184,315.7 мянган төгрөг тавилга, тоног төхөөрөмж зэрэг нийт 38,032,322.5 мянган төгрөгийн орлого бүртгэсэн.

#### **Уб. Замын хөдөлгөөний удирдлагын төв (+16,772.8 сая)**

1.Нийслэлийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн МН/002 дугаартай "Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлагын төвд байрлах нэгдсэн дата төвд шаардлагатай сервер, тоног төхөөрөмж, программ хангамж нийлүүлэх" гэрээг байгуулж тус ажлын хүрээнд 8,188,041.8 мянган төгрөгийн үнэ бүхий өртөгтэй хөрөнгийг хүлээн авсан. 2.Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/770 дугаартай "Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай" тушаалын дагуу 6,829,046.2 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг хүлээж авсан. 3.Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн МН/004 дугаартай захирамжийн хүрээнд "Нэгдсэн хяналт, удирдлагын төвийн серверийн өрөөнд шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах" гэрээг байгуулж нийт 2,170,198.4 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг хүлээн авсан. 4.Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/172 дугаар захирамжын хүрээнд хийгдсэн Бага тойруугийн 5 уулзварт иж бүрэн камер суурилуулах ЗХУТ/202306004 дугаартай гэрээт ажлаар нийлүүлсэн 2,907,165.6 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг хүлээн авсан.

#### **Уб. На. Засаг даргын тамгын газар (+79,639.9 сая)**

Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар нь 2025 онд 4,439,721 мкв 37 төрлийн газар эзэмших эрхийг бүртгэлд авч 102,705,619.4 мянган төгрөгөөр газар эзэмших эрх тайлант онд нэмэгдсэн. Дүүргийн Засаг даргын захирамжаар 2,932,392 мкв талбайтай Цэнгэлдэх хүрээлэн, наадмын талбайн зориулалт бүхий газрыг Засаг даргын Тамгын газарт 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэнийг бүртгэлд тусгасан. Тайлант онд 3 төрлийн зориулалт бүхий 24,207,937.5 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг шилжүүлж 78,497,681.9 мянган төгрөгөөр өссөн.

#### **Уб. Нийслэлийн Засаг даргын тамгын газар (+6,145.3 сая)**

Үндсэн хөрөнгийн өсөлт нь Мэдээлэл технологийн газар (МТГ) татан буугдсантай холбоотойгоор тухайн байгууллагын нэр дээр бүртгэлтэй хөрөнгүүдийг шилжүүлэн бүртгэн авсан нь өсөлтөд нөлөөлсөн.

#### **Уб. Сб. Засаг даргын тамгын газар (+9,984.3 сая)**

Улс, Нийслэл, Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2025 онд нийт 23,401,804,898.73 төгрөгийн нийтийн эзэмшил, барилга байгууламж, тоног төхөөрөмж шинээр бий болсон. Дахин төлөвлөлт орж буулгасан, ашиглалтын хугацаа дууссан эвдэрсэн 1,715,025,742.38 төгрөгийн хөрөнгө актлагдсан болно Хурамтлагдсан элэгдэлтийг дүнгээр 9,984,306,722.92 өссөн байна.

#### **Уб. Соёлын төв өргөө (+14,258.8 сая)**

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 14,969,064.2 мянган төгрөг болж, 14,258,762.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд өөрийн хөрөнгөөр 94,637.55 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, мөн Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/796 дугаар захирамж, НӨХГ-ын 1/953, 1/1932 дугаар шийдвэр, НСТӨ ОНӨААТҮГ-ын захирлын А/37 дугаар тушаалын дагуу нийт 17,881,112.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр (үүнээс 3,236,406.8 мянган төгрөгийн элэгдэлтэй) хүлээн авсан, түүнчлэн НӨХГ-ын даргын А/25 дугаар тушаалаар 480,137.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 443,114.3 мянган төгрөгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

#### **Уб. Сх. Засаг даргын тамгын газар (+6,902.0 сая)**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 31,503,275.4 мянган төгрөг болж 6,902,006.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 1,092,891.1 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 7,069,990.3 мянган төгрөг, шилжүүлэн авсан 24,900.0 мянган төгрөг, нийт 8,187,781.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, 24,900.0 мянган төгрөгийн хөрөнгийг дотооддоо шилжүүлж, тайлант онд 1,260,875.3 мянган төгрөгийн элэгдэл тооцсоноос шалтгаалжээ.

#### **Улаанбаатар орон сууцжуулалт ХХК (+21,910.9 сая)**

Носк аас түр суурьшуулах 4 байр шилжиж ирсэнтэй холбоотой хөрөнгө оруулалтын зориулалтай үл хөдлөх хөрөнгө 21,488,696,638.61 төгрөгөөр нэмэгдсэн. Шинээр худалдаж авсан 408,713,139.18 төгрөгийн хөрөнгө, 13,457,422.00 төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

#### **Улаанбаатар смарт карт ХХК (+17,344.3 сая)**

2025 оны үндсэн хөрөнгийн хөдөлгөөн: Энэ онд биет хөрөнгө 12,834,035,077.16 төгрөгөөр нэмэгдэж 26,085,166,38 төгрөгөөр хасагдаж /акталсан/ 2,147,633,326.21 төгрөгийн элэгдэл үүсч нийт 10,660,316,584.57 төгрөгийн өөрчлөлт орсон. Биет бус хөрөнгөд 417,519,104.72 төгрөгийн хөрөнгө нэмэгдэж үүнээс 46,819,104.72 төгрөгийн биет бус хөрөнгө худалдан авч мөн 2025 оны 12 сарын 31 өдрийн 1/2444 тоот Өмчийн харилцааны газраас ирсэн хөрөнгө бүртгэх тухай албан бичигт заасан 12,866,492,694 төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалтаас 370,700,000 төгрөгийн хөрөнгийг биет бус хөрөнгөд бүртгэж энэ онд биет бус хөрөнгийн элэгдэл 555,235,862.44 төгрөг үүссэнтэй холбоотой өөрчлөлт болно.

#### **Улаанбаатар хотын хөгжлийн корпораци (+269,700.0 сая)**

Улаанбаатар Энержи ХХК-ийн Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 274,632,300.8 мянган төгрөг болж нэмэгдсэн нь тайлант онд "Багануур Батерей хуримтлуурын станцын 220/\*110/35 кВ-ын дэд станцын 110кВ-ын хуваарилах байгууламжийн өргөтгөл, 110/35 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35 кВ-ын дэд станц, 50 МВт-ын хүчин чадалтай 200 МВт.цагийн багтаамж бүхий эрчим хүчний хуримтлуурын станцын барилга, байгууламж, тоног төхөөрөмж нийт 286,141,012.0 төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого болгосон, 160,109.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, тайлант онд 11,668.8 мянган төгрөгийн элэгдэл тооцон бүртгэсэн нь голчлон нөлөөлсөн байна.

#### **Ус сувгийн удирдах газар (+17,732.0 сая)**

· Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 387,593,739,4 мянган төгрөг байсанаас оны эцэст 405,325,730.4 мянган төгрөг болсон байна. Өөрийн хөрөнгө оруулалтаар 7,692,192.5 мянган төгрөг, их засвараар 2,045,520.2 мянган төгрөг, бараа материалаас 39,748.2 мянган төгрөг, шугам доторлосон 2,388,041.7 мянган төгрөг, нийт 12,165,492.5 мянган төгрөг, улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 31,568,198.0 мянган төгрөг, хандив тусламжаар 190,000.0 мянган төгрөг, нийт 43,923,690.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, НӨХГ-ын даргын А/75, А/107, А/248 дугаар тушаалаар 3,415,334.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасаж, 263,000.0 мянган төгрөгийн 3 тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлсэн байна. Тайлант оны элэгдлийн зардал 27,870,175.5 мянган төгрөг байна. Мөн УБЗААлбатай хотын аж ахуйн ажил, үйлчилгээнд нэн шаардлагатай тусгай зориулалтын машин механизмыг төлбөртэй ашиглуулах гэрээг байгуулан 2,014,000.0 мянган төгрөгийн 8 тээврийн хэрэгслийг бусад эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэсэн.

#### **Ор. Баян-Өндөр. Засаг даргын тамгын газар (+16,013.4 сая)**

Шинээр байгуулагдсан багуудын үндсэн хөрөнгө, нийтийн эзэмшлийн байгууламжуудаар нэмэгдсэн.

#### **Ор. Баян-Өндөр. Хот тохижуулах газар (+99,277.3 сая)**

Өмнөх онд аймгийн шууд дээр нэгтгэгддэг байсан учраас Эхний үлдэгдэл нь аймгийн шууд дээр байгаа.

#### **Эрдэнэт-Ус (+22,707.9 сая)**

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ИШСүлжээ, дэд бүтцүүдийн хөрөнгийг орон нутгаас шилжүүлсэн тул хөрөнгө өссөн.

### **БУУРСАН БАЙГУУЛЛАГУУД (93)**

#### **Шивээ овоо (-4,456.8 сая)**

Үндсэн хөрөнгийн данс нь 76,275.7 сая төгрөгт хүрч 4,456.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардал 14,056.6 сая төгрөгөөр тооцсонтой холбоотой.

#### **Эрдэнэс алт ресурс (-2,508.3 сая)**

Үндсэн хөрөнгө 14.7 тэрбум төгрөгөөр буурсан, хайгуул үнэлгээний хөрөнгө 12.2 тэрбум төгрөгөөр буурсан.

#### **Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар (-1,158.3 сая)**

Засгийн газрын 2025 оын 90 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2024 оны 21 дүгээр хуралдааны тэмдэглэлээр 1.1 тэрбум төгрөгийн ДБҮЭГ-т бүртгэлтэй барилгыг ГХЯ-ны балансаас балансад шилжүүлснээр гарсан өөрчлөлт байна.

#### **Сангийн яам (-1,787.0 сая)**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 857 дугаар тогтоолыг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/257 тушаалыг үндэслэн 1.787.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасаж бүртгэсэн.

#### **УГЕГ - Өмнөговь Шивээ хүрэн гаалийн хороо (-1,192.3 сая)**

Тайлант хугацааны элэгдэлийн дүнгээр нийт хөрөнгийн дүн буурсан үзүүлэлттэй байна.

#### **УГЕГ - Үйлчилгээний алба (-3,878.9 сая)**

Тайлант хугацааны элэгдэлийн дүнгээр нийт хөрөнгийн дүн буурсан үзүүлэлттэй байна.

#### **Улаанбаатарын төвийн дулаан хангамжийн төсөл /Европын сэргээн босголт хөгжлийн банк/ (-6,641.0 сая)**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолыг үндэслэн 6.6 тэрбумын хөрөнгийг Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК дээр бүртгэсэн.

#### **ҮТЕГ - Өмнөговь аймгийн татварын хэлтэс (-1,109.7 сая)**

2024 оны жилийн эцсийн аудитын дүгнэлтээр Үндсэн хөрөнгөд 1,097,190.5 мянган төгрөгийн өртөгтэй орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдсан барилга давхар бүртгэлтэй байна гэж өгсөн зөвлөмжийн дагуу ТӨБЗГ-ын 2025 оны А-1/2287 тоот албан бичгийн дагуу орон нутгийн өмчид шилжүүлсэн.

#### **Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл /Хятад/ (-108,144.6 сая)**

БНХАУ -ын дамжуулан зээлийн эх үүсвэрээр хэрэгжижи дууссан төслийн хөрөнгө болох 35 МВт-ын турбин генераторын барилга угсралтын ажил, тоног төхөөрөмжийг ТӨБЗГ-ын тогтоол гарч "эрдэнэтийн дулааний цахилгаан станц" ТӨХК нь хөрөнгөд бүртгэн авч төслийн эргэлтийн хөрөнгөөс хассан.

#### **Цэргийн төв эмнэлэг (-4,269.0 сая)**

2025 оны жилийн эхний хуримлагдсан элэгдлийн үлдэгдэл 31,554,980,416.98 төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд 4,710,943,569.26 төгрөгийн элэгдлийн зардал нэмэгдэж жилийн эцэст 36,265,923,986.24 төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэлтэй болсон бөгөөд зөрүү нь хөрөнгийн анхны өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хассан үлдэгдэл байна. Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/496 дугаар тушаалаар Зэвсэгт хүчний 189 дүгээр ангиас 7 нэр төрлийн 22,907.5 мянган төгрөгийн компьютерийг үнэ төлбөргүй хүлээн авсан. Мөн сайдын 2025 оны А/500 дугаар тушаалаар эмнэлгийн төв корпус, гал тогооны барилгад 323,018.4 мянган төгрөгөөр нэмж капиталжуулалт хийгдсэн. Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/501 дүгээр тушаалаар 27

нэр төрлийн 283,154.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг эргэлтийн хөрөнгөнөөс шилжүүлэн бүртгэсэн. Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/187 дугаар тушаалаар 14 нэр төрлийн 187,119.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй 187,119.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй тоног төхөөрөмжийг данс бүртгэлээс хасч акталсан.

**Амгалан амаржих газар (3) (-1,465.1 сая)**

800.0 сая хөрөнгө акталсан, 540.0 сая төгрөгийн дуусаагүй барилга хасч бүртгэсэн, машин тоног төхөөрөмжийн тайлант хугацааны элэгдлийн зардал 1.3 тэрбум төгрөг болсон.

**Ар. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-2,079.0 сая)**

Машин тоног төхөөрөмжийн балансын дүн 10 тэрбум төгрөг, тайлант хугацааны элэгдлийн зардал 2.3 тэрбум төгрөг болсон.

**Бө. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-1,613.1 сая)**

Элэгдэлийн зардал өссөн. Аймгийн ИТХ-ийн 2025 оны 09-р сарын 11 өдрийн 91-р тогтоолоор үндсэн хөрөнгө акталсан. Мөн ИТХ-ийн 2025 оны 09-р сарын 11-ний өдрийн 68-р тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн.

**Дд. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-1,504.8 сая)**

Дд. Аймгийн нэгдсэн эмнэлэг Элэгдлийн зардал өссөнтэй холбоотой буурсан.

**Дд. Баянтүмэн. Хүн эмнэлэг (-1,409.2 сая)**

Дд. Баянтүмэн. Хүн эмнэлэг Эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг давхардуулан бүртгэсэн. Өмнө авсан дүнгээ залруулга хийж шинэ дүнгээр нь данхин бүртгэж авсан.

**Өм. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-4,810.5 сая)**

1 тэрбум төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй бүртгэсэн, тайлант хугацааны элэгдлийн зардал 4.4 тэрбум төгрөг, 1.7 тэрбум төгрөгийн өмнө оны элэгдлийг аудитын явцад нөхөн байгуулсан байна.

**Сү. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-1,299.5 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**Сэ. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-2,529.0 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**Тө. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-1,399.5 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**УБ. Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв (-2,555.0 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**УБ. Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг (-1,374.1 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**УБ. Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв (-1,115.1 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**Халдварт өвчин судлалын үндэсний төв (-3,973.9 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

### **Хо. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-2,330.4 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

### **Эрүүл мэндийн яам (-1,490.6 сая)**

Дата төвд байршдаг эрүүл мэндийн системийн программ хангамж бөгөөд 692.0 сая төгрөг тайлант хугацааны элдэгдлийн хасагдуулга, 590.0 сая төгрөг өмнө оны хасагдуулга тооцон бүртгэсэн.

### **Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэний төв - 2 (-5,034.2 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

### **Замын үүд чөлөөт бус (-1,924.0 сая)**

Биет бус хөрөнгөд бүртгэлтэй зураг төсөвт хуримтлагдсан элэгдэл тооцож, өртөг бууруулсныг аудитаар илрүүлж залруулга хийгдсэн.

### **ОБЕГ - Агаараас эрэн хайх, аврах 111-р анги (-4,327.0 сая)**

Тайлант онд 795,799,615.42 төгрөгийн үндсэн хөрөнгийг шинээр хөрөнгөд бүртгэж, 283,307,897.58 төгрөгийг балансаас балансд шилжүүлсэн. Тайлант хугацааны нийт хөрөнгийн элэгдлийн дүн 4,839,491,043.70 төгрөг.

### **ОБЕГ - Ар талын 115-р анги (-3,312.7 сая)**

Онцгой байдлын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар хүлээн авсан Төв орон нутгийн онцгой байдлын байгууллагуудад хувиараар олгох тоног төхөөрөмж багаж хэрэгслийн нөөцөөр нэмэгдсэн. Тайлант оны хөрөнгийн элэгдлийн дүнгээр буурсан.

### **Төрийн үнэт цаас хэвлэл (-4,066.4 сая)**

Тухайн жилд хөрөнгө оруулалт буюу худалдан авалт хийгдээгүй бөгөөд санхүүгийн болон татварын жилээр үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн элэгдэл, хорогдлоор буурсан.

### **Улаанбаатар. Улсын бүртгэлийн ерөнхий газар (-2,794.3 сая)**

Засгийн газрын 2025 оны 196 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн улсын бүртгэлийн газрын чиг үүргийг УБЕГ-т шилжүүлсэнтэй холбоотой үүссэн бууралт.

### **Улаанбаатар. ШШҮТ - Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын харъяа Шүүхийн шинжилгээний алба (-8,645.0 сая)**

ЗДТГ болон ГХУСАЗСЗ-д албаны үйл ажиллагааг сайжруулах хүрээнд цахилгаан дугуй ашиглах боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мөн лабораторын техник хэрэгслээр хангах хүсэлт гаргасны дагуу нийт 66.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шийдвэрлүүлж, бэлтгэсэн. ТӨБЗГ-ын 2025.02.13-ны өдрийн “Хөрөнгө шилжүүлэх тухай” А-1/309 дүгээр албан бичиг - 1 нэрийн, нийт 4.6 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2025.12.23-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” А-1/2579 дүгээр албан бичиг - 3 нэрийн, нийт 20.2 сая төгрөг, ШШЕГ-ын даргын 2025.12.19-ний өдрийн “Хөрөнгө, бараа материал шилжүүлэх тухай” А/178 дугаар тушаал - 6 нэрийн, нийт 11.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэж авсан. Мөн тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр 17.9 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийг 10.5 сая төгрөгийн үнэ шинэчлэн тогтоосон. ТӨБЗГ-ын 2025.12.23-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” А-1/2579 дүгээр албан бичгийн дагуу 4 нэрийн нийт 191.1 сая төгрөгийн анхны өртөгтэй 59.4 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий авто-тээврийн хэрэгслийг ШШЕГ болон Говьсэмбэр баймгийн ШШХ-т балансаас балансад шилжүүлсэн. НШШГ-ын даргын 2024.12.04-ны өдрийн Б/14 дүгээр тушаалаар "Үнэлгээний хороо" байгуулагдсаны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан 135.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг худалдан авсан. Тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол шийдвэрийн дагуу байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 36 нэрийн 229.2 төгрөгийн хөрөнгийг акталж устгасан.

### **Улсын бүртгэлийн ерөнхий газар (-8,352.8 сая)**

ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэх тогтоох тухай” 318 дугаар тогтоолоор 235,202.5 мянган төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож бүртгэсэн; ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай” 333 дугаар тогтоолоор 524.015.9 мянган төгрөгийн хөрөнгийг Гадаад харилцааны яам, Гадаадын иргэн харьяатын газарт болон харьяа нэгжүүдэд шилжүүлэн өгсөн; ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 338 дугаар тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 838,906.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэх тогтоох, балансаас балансад шилжүүлэх тухай” 363 дугаар тогтоолоор 286,817.9 мянган төгрөгийн хөрөнгийг Гадаад харилцааны яам, Дотоод хэргийн их сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт шилжүүлэн өгсөн байна. ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгө бүртгэх тухай” 418 дугаар тогтоолоор 211,350.0 мянган төгрөгийн хөрөнгийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шилжүүлэн авсан байна. ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэх тогтоох тухай” 816 дугаар тогтоолоор 1,662,528.9 мянган төгрөгийн төгрөгийн хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоож дансанд бүртгэсэн байна.

#### **ЦЕГ - Захиргааны удирдлагын газар (-3,189.7 сая)**

Цагдаагийн байгууллагын бүтэцээр Гэмт хэрэг, зөрчил шалгах алба, Урьдчилан сэргийлэх албыг тусад салгаж төсөв захирагч болгосноор дээрх 2 албанд ашиглагдаж байсан үндсэн хөрөнгийг дагуулж шилжүүлэн өгсөн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу балансаас балансад шилжүүлсэн.

#### **ЦЕГ - Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба (-2,082.6 сая)**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын шийдвэрээр акталж данс бүртгэлээс хассан үндсэн хөрөнгө, Нийслэлийн нийтийн өмчид шилжүүлсэн газрыг данснаас хассан.

#### **Хөтөлийн цемент шохоо (-6,240.0 сая)**

Шүүхийн шийдвэрээр 377.0 сая төгрөгийн орон сууцыг барилга байгууламжийн дансанд бүртгэсэн мөн өөрийн хөрөнгөөр 3,620.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 2,108.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж бэлтгэсэн. Тайлант он элэгдлийн зардал 12,875.9 сая төгрөгөөр байгуулсан нь үндсэн хөрөнгө буурахад нөлөөлсөн.

#### **Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургууль (-10,581.4 сая)**

ТӨБЗГ-ын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А1/861 тоот тогтоолоор хөрөнгө акталж машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг данснаас хассан, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 236 тоот тогтоолоор үндсэн хөрөнгө акталж данснаас хассан, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 236 тоот тогтоолоор Орхон аймаг дахь Политехникийн коллеж-д 1 машин балансаас балансад шилжүүлсэн, 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 231 тоот тогтоолоор 3 машиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрлийн дагуу худалдан данснаас хасалт хийгдсэн байна.

#### **МБСБ - Дархан-Уул аймаг дахь Политехник коллеж (-1,247.2 сая)**

ТӨБЗГ-ын 2025 оны 11 сарын 28-ны өдрийн 623 тоот тогтоолоор хөрөнгө акталж данснаас хасалт хийгдэж, тайлант онд элэгдэлийн зардлаар буурсан байна.

#### **Монгол Улсын Боловсролын Их Сургууль (-1,673.9 сая)**

Ректорын тушаалын дагуу нийт 2,2 тэр бум төгрөгийн хөрөнгийг худалдан авсан. Тайлант онд барилга байгууламж дансанд 358.2 сая төгрөгийн капиталжуулалт, Дуусаагүй барилга байгууламж 106,6 сая төгрөг, Тээврийн хэрэгсэл дансанд 74.5 сая төгрөг, Машин тоног төхөөрөмжийн дансанд 1,1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт, Программ хангамж дансанд 51.3 сая төгрөг, Номын фондод 74.5 сая төгрөг, Тавилга, эд хогшлын дансанд 403.0 сая төгрөгийн тавилга эд хогшлын худалдан авалтыг тус тус бүртгэсэн. Үнэ төлбөргүй авсан 208.8 сая төгрөгийн хөрөнгө нь боловсролын ерөнхий газраас 46,7 сая төгрөгийн компьютер, ширээ сандал, хамтын ажиллагааны хүрээнд Өвөр монголын их сургуулиас 820.0 мянган төгрөгийн ном сурах бичиг, Боловсролын яамнаас 6.5 сая төгрөгийн зөөврийн компьютер, Азийн хөгжлийн банкнаас 12.5 сая төгрөгийн ширээ сандал, зөөврийн компьютер, Эрасмус төслөөс 129,1 сая төгрөгийн компьютер, МУБИС-ийн төв номын сангаас 2.2 сая төгрөгийн номыг Баян-Өлгийн багшийн сургуульд хандивласан, Ангилал хооронд 4.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг шилжүүлж данс бүртгэлд тус тус бүртгэж авсан. Төрийн өмчийн бодлого

зохицуулалтын газрын 2025 оны 7 дугаар сарын 4 өдрийн 343 дугаар тогтоолоор Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрлийн дагуу барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, номын фонд, программ хангамжийн хөрөнгийг тус тус данс бүртгэлээс хассан.

**Өмнөговь. Боловсролын газар (-1,588.5 сая)**

Өмнөговь аймгийн Даланзадгад суманд шинээр 6-р сургууль ашиглалтанд орсноор орон нутгаас олгосон үндсэн хөрөнгийг 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд орлого авсан ба аймгийн ИТХ-ын 2025оны 04 сарын 11-ний өдрийн 5/22 тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн хөрөнгөөр буурсан байна.

**Сү. Баруун-Урт. Нэгдсэн дотуур байр (-2,047.6 сая)**

Сүхбаатар аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 1 дүгээр сарын 23-ны 03 дугаар тогтоолоор татан буугдаж Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн харьяанд шилжснээр балансаас балансад үндсэн хөрөнгийг шилжүүлсэн.

**Төв. Зуунмод. Сургууль /1-р Хүмүүн, цогцолбор/ (-4,639.5 сая)**

Төв Зуунмод Хүмүүн цогцолбор сургуулийг Төв аймгийн Засаг даргын А/601 тоот захирамжаар татан буугдаж 1,2 дугаар сургууль болгон бүтэц зохион байгуулалтыг өөрчилсөн байна. Төв аймгийн засаг даргын захирамжаар батлагдсан ажлыг хэсэг Хүмүүн цогцолбор сургуулийн үндсэн хөрөнгө, биет хөрөнгийг тоолон тулган баталгаажуулж аймаг, сумын ИТХ-аар батлуулсан байна.

**Ув. Бх. Сургууль /Хангай, цогцолбор/ (-2,226.7 сая)**

Сургуулийн бүтэц өөрчлөгдөж 91, 94-р сургууль болж хуваагдсан. 94-р сургуульруу хөрөнгө шилжүүлсэн.

**Да. АЗЗА (-1,393.4 сая)**

20 АЗЗА ТӨХК-иудыг нэгтгэсэнтэй холбоотойгоор бүх үндсэн хөрөнгийг АЗЗА нэгтгэл ТӨХК-д шилжүүлсэн. Үүнтэй холбоотойгоор нэгдсэн нэг тайлан гаргаж салбаруудын хаалтын тайлан гаргасанаар хөрөнгүүд тэг үлдэгдэлтэй болж буурсан байна.

**Зам, тээврийн хөрөнгө оруулалт, их засвар (-373,841.7 сая)**

ТӨБЗГ-ын 2025 оны 796 дугаар тогтоолоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 4 нэрийн Дуусаагүй үйлдвэлэл данснаас Зам, гүүрийн байгууламж дансанд капиталжуулан бүртгэсэн.

**Иргэний нисэхийн ерөнхий газар (-689,246.0 сая)**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 04 дүгээр тогтоолоор Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрыг хэрэгжүүлэгч агентлаг гэж, Монгол улсын засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай 193 дүгээр тогтоолоор Агаарын навигаци, нисэх буудал, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ болон аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг хариуцан хэрэгжүүлэх "Иргэний нисэхийн үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг тус тус заасан. 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн дээрх газрууд Сангийн яамны Э-Баланс, finform дээр санхүүгийн тайланг тус тусдаа оруулсан. Өмнөх онд санхүүгийн нэгтгэсэн дүнгээр бэлтгэн боловсруулж оруулдаг байсан. 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс тус тусдаа оруулж байгаа тул өмнөх оноос буурсан.

**Өв.Хх. АЗЗА (-1,768.2 сая)**

20 АЗЗА ТӨХК-иудыг нэгтгэсэнтэй холбоотойгоор бүх үндсэн хөрөнгийг АЗЗА нэгтгэл ТӨХК-д шилжүүлсэн. Үүнтэй холбоотойгоор нэгдсэн нэг тайлан гаргаж салбаруудын хаалтын тайлан гаргасанаар хөрөнгүүд тэг үлдэгдэлтэй болж буурсан байна.

**Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц (-31,539.9 сая)**

Үндсэн хөрөнгө 53,483.8 сая төгрөгөөр, элэгдлийн зардал 85,895.8 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн. Тухайлбал барилга 5,175.7 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 42,331.5 сая төгрөгөөр, бусад хөрөнгө 5,976.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Харин барилгын хуримтлагдсан элэгдэл 8,045.5 сая төгрөгөөр,

машин тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдэл 72,969.5 сая төгрөгөөр, бусад хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 4,880.8 сая төгрөгөөр тус тус өссөн.

#### **Дулааны хоёрдугаар цахилгаан станц (-7,976.4 сая)**

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 33,979.8 сая төгрөг болж өмнөх оноос 7,976.4 сая төгрөгөөр буурахад ТӨБЗГ-ын 2025 оны 122 дугаар тогтоолоор 6,658.6 сая төгрөгийн газар эзэмших эрхийг хассан. Мөн ТӨБЗГ-ын 2025 оны 398 дугаар тогтоолоор 345 нэр төрлийн 107.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан нь голлон нөлөөлсөн байна.

#### **Таван толгой түлш (-3,261.7 сая)**

үндсэн хөрөнгө тайлант хугацааны элэгдлийн дүнгээр буурсан.

#### **Дархан-Уул. Аймаг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар (-1,160.9 сая)**

Тус газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан Зулзагын гол зуслангийн барилга, байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга, аж ахуйн эд хогшлийг балансаас балансанд шилжүүлсэн.

#### **Мэдээлэл, холбооны сүлжээ ХХК (-2,904.5 сая)**

ТӨБЗГ-ын 2024 оны 700 тоот тогтоол, 2025 оны 35, 478 тоот тогтоол, 2025 оны 1/1758 тоот албн бичгийн дагуу нийт 1,493.0 сая төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2024 оны 660 тогтоолоор 142.8 сая төгрөгөөр хөрөнгө хасагдаж, мөн 13,229.2 сая төгрөгийн элэгдлийн зардлаар хөрөнгийн дүн өөрчлөгдсөн.

#### **Радио телевизийн үндэсний сүлжээ ТӨҮГ (-1,447.8 сая)**

Хөрөнгө тайлант онд 147.67 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант оны элэгдлийн зардал 1,588.54 сая төгрөг тус тус нөлөөлсөн.

#### **Ар. Хот тохижилт үйлчилгээний газар (-14,444.6 сая)**

2024 онд төсвийн байгууллага байсан ба 2025 онд ОНӨААТҮГ болон өөрчлөгдснөөр буурсан байна.

#### **Булганмээж (-1,219.3 сая)**

Булган мээж ОНӨХХК-ний 2025 онд үндсэн хөрөнгөнд тооцсон 1,750,914,743.99 төгрөгийн элэгдлийн зардал нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурахад нөлөөлсөн байна. Булган мээж ОНӨХХК 2025 онд нийт 531,632,619.03 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

#### **До. Сайншанд. Захирагчийн ажлын алба (-8,525.1 сая)**

Сайншанд хотын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02/06 дугаар тогтоолоор Сайншанд тохижилт үйлчилгээний газар болон Захирагчийн ажлын алба гэж бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэн. Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 04/02 дугаар тогтоолоор Сайншанд тохижилт үйлчилгээний газрын 8.5 тэрбум төгрөгийг хөрөнгийг балансаас балансд шилжүүлсэн.

#### **Өв. Хархорин. Засаг даргын тамгын газар (-1,255.3 сая)**

Нийт хөрөнгийн 88.2 хувь буюу 15.3 тэрбум төгрөгийг барилга байгууламжийн үлдэгдэл эзэлж байгаа бөгөөд барилга байгууламжийн тайлант хугацааны элэгдэл нь өмнө оноос 1.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж хөрөнгийн эцсийн үлдэгдэл буурахад нөлөөлсөн байна.

#### **Өм. Баяндалай. Засаг даргын тамгын газар (-2,852.7 сая)**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл болон эцсийн үлдэгдлийн зөрүү болох 2,853,279,056.02 төгрөг нь үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардал болон хуримтлагдсан элэгдлийн залруулга байна.

#### **Өм. Орон нутгийн өмчийн газар (-1,884.2 сая)**

Аймгийн ИТХ-ын тогтоолоор ашиглагч байгууллага руу шилжүүлсэн.

#### **Өм. Төрийн үйлчилгээний алба (-1,186.8 сая)**

Татан буугдсан.

#### **Таван толгой (-1,075.5 сая)**

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаар буурсан болно.

#### **Цэмцгэр Өмнөговь ОНӨААТҮГ (-1,808.7 сая)**

Татан буугдсан.

#### **Сэ. Ерөө. Засаг даргын тамгын газар (-1,133.1 сая)**

2024 онд дуусаагүй барилгаар бүртгэсэн байсан 6 хөрөнгийн үлдэгдэл санхүүжилтийг 2025 онд олгож дуусган, холбогдох байгууллагуудад нь шилжүүлэн өгсөн нь хөрөнгийн бууралтанд нөлөөлсөн.

#### **Сэ. Орхонтуул. Засаг даргын тамгын газар (-6,201.9 сая)**

Үндсэн хөрөнгийн дуусаагүй барилга байгууламж дээр бүртгэлтэй байсан баригдаж буй гүүрийг 2025 оны аудитын тайлангийн шалгалтаар залруулж, бараа материалын бусад хангамжийн материалын дансанд шилжүүлэн бүртгэсэн.

#### **Тохилог Хараа ААТҮГ (-1,933.5 сая)**

2025 онд аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Хово машин 277.0 сая төгрөг, сумын хөрөнгө оруулалтаар хийгдсэн шахдаг ногоон машин 110.0 сая төгрөг, хог шатаадаг зуух 55.9 сая төгрөгөөр тус тус орлогод авч, зам гүүрийн байгууламжуудын элэгдлийн зардал өндөр тооцогдсоноос хуримтлагдсан элэгдэл 1,490.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хөрөнгийн бууралтад нөлөөлсөн.

#### **Цант Орхон (-3,682.0 сая)**

2018 онд газрын суурь үнийн нэгж үнэлгээг андууран хэт өндөр үнэлсэн байсныг мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгүүлж, залруулга хийн 3,760.6 сая төгрөгөөр бууруулан үнэлж хөрөнгөнд бүртгэсэн нь хөрөнгийн бууралтанд нөлөөлсөн.

#### **Шим-Ус (-1,717.7 сая)**

Алтай Зэрэг Мянгад сумдад шугам сүлжээ, ус татуургын хөрөнгийг аймгийн ИТХ-ын шийдвэрээр балансаас балансад шилжүүлсэн.

#### **Хө. Хот тохижилт, үйлчилгээний газар (-4,221.6 сая)**

Хот тохижилт үйлчилгээний төв ХХК татан буугдаж Үндсэн хөрөнгийг Аймгийн ИТХ-ын шийдвэрээр балансаас балансад сумын ЗДТГ-т шилжүүлсэн.

#### **Хөдөөгийн шийдэл (-2,456.7 сая)**

2022 оны ОНӨГ-ын даргын тушаалаар Худалдан борлуулах зориулалттай хөрөнгийг Үндсэн хөрөнө дээрээ бүртгэсэн учир аудитын явцад залруулга хийн бараа материалын дансанд бүртгэсэн.

#### **Шинэ мөрөн худалдааны төв (-5,296.1 сая)**

Барилга байгууламж шатаж улсын комиссын дүгнэлт гарч акталсан.

#### **Хэ. Биндэр. Засаг даргын тамгын газар (-3,082.5 сая)**

2025 онд Их хуралдайн гадна тохижилт, шугам сүлжээ, зоорийн ажил, газрын хамт Чингис хаан музей руу СЯам шилжүүлсэн /2,966,012,556 төг/ болно.

#### **Да. Засаг даргын тамгын газар (-2,001.9 сая)**

Боловсрол 2030 хөтөлбөрийн хүрээнд ҮХ-с ЕБС-уудад ширээ сандал шилжүүлсэн болон тайлант хугацааны ҮХ-ийн элэгдлийн зардлаар хөрөнгө буурсан.

#### **Дархан орон нутгийн зам тээвэр (-5,269.5 сая)**

Аймгийн хэмжээний замын байгууламж автозам бүртгэлтэй байгаагаас ҮХ -ийн элэгдлийн зардлын дүнгээр хөрөнгө буурсан.

#### **Дархан хотын тохижилт үйлчилгээний газар (-1,350.8 сая)**

Нийтийн эзэмшлийн зам байгууламжийн хөрөнгө ҮХ -ийн элэгдлийн зардлын дүнгээр хөрөнгө буурсан.

### **Дархан-Ус суваг (-4,305.2 сая)**

Мөн төслийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалт нэмэгдсэнээс ҮХ -ийн элэгдлийн зардал өссөнөөм нийт хөрөнгө буурсан.

### **Геодези, усны барилга байгууламжийн газар (-3,706.0 сая)**

803,508,833.63 төгрөгийн үндсэн хөрөнгө шинээр худалдаж авсан. 3,537,496,198.38 төгрөгийн үнэ төлбөргүй шилжүүлж авсан. 62,519,746.34 төгрөгийн акталсан 7,984,523,560.18 төгрөг нь элэгдэлийн зардал тус тус байна.

### **Зорчигч тээвэр 1 (-1,179.7 сая)**

Дахин үнгэлгээний өөрчлөлт орсон тул буурсан.

### **Зорчигч тээвэр 4 (-3,302.3 сая)**

2025 онд Нийслэлийн засаг даргын тамгын газар луу шилжүүлсэн 10ширхэг Ютонг маркийн автобусны үнэ 2,759,832,000 төгрөгөөр буурсан, 2025 онд хөрөнгөөр 2,374,899,040.7 төгрөгийн орлого бүртгэж авсан. Нийт хөрөнгийн элэгдэл 542,462,469.99 төгрөгөөр буурсан байна.

### **Зорчигч тээвэр 5 (-3,447.9 сая)**

НЗДаргын А/1428 захирамжаар 414.3 сая төгрөгийн газар эзэмших эрхийг Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГазарт шилжүүлсэн.

### **Нийслэлийн орон сууцны корпораци (-6,657.3 сая)**

Нийслэлийн засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/392 дугаар захирамж, НИТХ-ын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 25/40 дугаар тогтоолын дагуу “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК руу 21,731,708,631.85 төгрөгний үнэтэй 21,653,308,848.95 төгрөгний үлдэх өртөгтэй барилга байгууламж балансаас баланст шилжүүлэв. Үүнд 21,488,696.6 мянган төгрөгний хөрөнгө оруулалтын зориулалттай орон сууц, 97,176.0 мянган төгрөгний нийтийн эзэмшлийн хөрөнгө, 145,836.0 мянган төгрөгний барилга байгууламжийг тус тус данс бүртгэлээсээ хасаж балансаас баланст шилжүүлсэн. Мөн тус байгууллагад зарим ажилчин, албан хаагч шилжсэнтэй холбоотойгоор шилжсэн албан хаагчдын эд хөрөнгийн карт дээрх бүх хөрөнгийг “Нийслэлийн өмчийн харилцааны газар”-ын тушаалаар балансаас баланст шилжүүлсэн ба нийт 59,346,350.72 төгрөгний үнэтэй 20,728,544.22 төгрөгний үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгө буюу үүнээс тавилга эд хогшил 11,372.3 мянган төгрөг, тоног төхөөрөмж 17,997.5 мянган төгрөг, компьютер бусад хэрэгсэл 28,276.6 мянган төгрөг, програм хангамж 1,700.0 мянган төгрөгийн эд хөрөнгө болно. Тайлант 2025 онд өөрийн хөрөнгөөр 3,178.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 25,229.4 мянган төгрөгийн тавилга, 118,373.8 мянган төгрөгийн компьютер бусад хэрэгсэл, 88,181.8 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл өөрийн хөрөнгөөр худалдан авч, нийт 3,104,089.0 мянган төгрөгийн газар үнэ төлбөргүй хүлээн авсан байна. “Нийслэлийн өмчийн харилцааны газар”-ын 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/309 дугаар тушаалын дагуу нийт 84,908,3 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө акталснаас тавилга эд хогшил 16,248.2 мянган төгрөг, тоног төхөөрөмж 23,742.1 мянган төгрөг, компьютер бусад хэрэгсэл 24,034.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 7,404.0 мянган төгрөг, нийтийн эзэмшил 8,200.0 мянган төгрөг, програм хангамж 5,280.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус данс бүртгэлээсээ хассан болно.

### **Нийслэлийн төр захиргааны авто бааз (-2,850.4 сая)**

2025 онд нийт 722.1 сая төгрөгийн хөрөнгийг балансад бүртгэсэн, 8.15 сая төгрөгийн анхны үнэтэй 775.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг дансаас хасах, балансаас балансад шилжүүлэх хөдөлгөөн хийгдсэн. Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хөрөнгийн өсөлт гарсан.

### **Уб. Монгол наадам төслийн нэгж (-1,561.5 сая)**

Хөрөнгө буурсан нь элэгдэл тооцогдсоноос шалтгаалсан. Мөн НӨХГ-ын даргын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/706 тоот тушаалаар 198,007,247.80 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хууль журманд гийцүүлэн данс бүртгэлээс хассан.

### **Уб. Мэдээлэл технологийн газар (-4,203.5 сая)**

Үндсэн хөрөнгийн бууралт нь Мэдээлэл технологийн газар (МТГ) татан буугдсантай холбоотойгоор хөрөнгийг НЗДТГ, ЗХУТ-т шилжүүлэн бүртгэснээс хасалт хийсэн. НӨХГ-ын шийдвэрээр ашиглалтын шаардлага хангахгүй үлдэх өртөгөө бүрэн нөхсөн хөрөнгүүдийг акталсан.

#### **Уб. Нийслэлийн Захирагчийн ажлын алба (-9,808.2 сая)**

2025 онд нийт 12,608,652.00 мянган төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгсэл дансанд бүртгэлтэй автомашины бүртгэлийг бусад эргэлтийн хөрөнгө дансанд шилжүүлж бүртгэсэн. Энэ онд 35,509,297.85 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл шилжиж ирсэн бөгөөд харьяа газар болон хог тээврийн байгууллагатай 5-н жилийн ашиглах гэрээ хийж сар бүр төлбөрийг төвлөрүүлж байна. Хөрөнгө оруулалтаар дансаар гарсан 3,033,775.35 мянган төгрөгийг бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэсэн. Тухайн хөрөнгийг өмчийн харилцааны газрын шийдвэр гарахаар ашиглагч газар дээр балансаас балансад бүртгэнэ. тавилга, эд хогшил болон тоног төхөөрөмжийг шилжүүлэн авсан. Үүнээс: Нийслэлийн Засаг даргын А/1346 дугаар Захирамжаар 12,608,652.0 мянган төгрөгийн үнэ бүхий 33 тээврийн хэрэгслийг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын А/635 дугаар тушаалаар УБ хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл, НЗДТГазраас 26 нэр төрлийн 189,643.32 мянган төгрөгийн тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмжийг шилжүүлж авсан. Бусад хөрөнгөнд 1,178,963.59 мянган төгрөгийн зөөврийн майхан, сандал. Газар эзэмших эрхийн бүртгэлд Мод үржүүлгийн газрыг бүртгэсэн байна. Урсгал санхүүжилтээс UB engineering-ийг байршуулах сервер, НЗД А/1237 захирамжаар агаараас зураглал хийх тоног төхөөрөмж нийт 461,983.15 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан болно.

#### **Уб. Өмчийн харилцааны газар (-8,881.5 сая)**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11,878,765.5 мянган төгрөг болж өмнөх оноос 8,881,545.3 мянган төгрөгөөр буурсан нь НЗД-ын 2026 оны А/77 дугаар захирамжаар Багахангай Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ын 2,397,219,9 мянган төгрөгийн хөрөнгө, НЗД-ын 2025 оны А/382 дугаар захирамжаар Улаанбаатар сан ОНӨААТҮГ-ын 719,596.3 мянган төгрөгийн хөрөнгө балансаас баланст шилжүүлэн авснаар нэмэгдсэн;

#### **Уб. Хот тохижилт, үйлчилгээний газар (-4,424.7 сая)**

Нийслэлийн ӨХГ-2025-12-30 №А/904 тоот тушаалаар 90,999,000.00 төгрөгийн үндсэн хөрөнгө дансаас хассан, Мөн өдрийн А/902 тоот тушаалаар 1,233,333,350.42 төгрөгийн үндсэн хөрөнгө дансаас хассан, НИТХ-ын 2025оны 25/160 дугаар тогтоолоор 2,975,664,875.4 төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн, Нийслэлийн засаг даргын 2025/05/15-ны өдрийн А/684 тоот захирамжаар 2,018,939,559.56 төгрөгийн 14 тээврийн хэрэгсэл данснаас хассан

#### **Уб. Ху. Засаг даргын тамгын газар (-1,238.8 сая)**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 212,104,240.1 мянган төгрөг болж урьд оныхоос 1,238,811.4 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн дансны өөрчлөлт нь дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 12,763,091.3 мянган төгрөг, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 4,304,075.3 мянга нийт үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 17,067,166.68 мянган төгрөг, 2,5,6,21 хороод, 19 хорооны өрхийн эмнэлгийн байр, дүүргийн иргэдэд үйлчлэх төв байрны 9 давхарт шаардлагатай засварыг хийж, нийт 218,492.78 мянган төгрөгийн сайжруулалт, тайлант хугацаанд худалдан авсан 454,931.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус данс бүртгэлдээ тусгасан. Тайланд хугацаанд 3,691,923.67 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн аклан, 26,000.00 мянган төгрөгийн өртөг бүхий приус, 35,046.27 мянган төгрөгийн газрыг Хан-Уул яармаг ОНӨААТҮГ руу балансаас баланс руу шилжүүлсэн. Тайлант хугацааны элэгдлийн зардал 18,689,477.6 мянган төгрөгийн элэгдэл тооцсон болно.

#### **Уб. Чи. Засаг даргын тамгын газар (-1,772.1 сая)**

Нийслэлийн өмчийн харилцааны газрын 813-р тогтоолоор акталсан барилга, машин тоног төхөөрөмж, зам гүүр гэсэн үндсэн хөрөнгөөр буурсан байна.

#### **Ор. Орон нутгийн өмчийн алба (-28,846.1 сая)**

Дууссан барилга байгууламжуудыг ашиглагч байгууллагуудад шилжүүлсэн.

#### **Ор. Хот тохижуулах газар (-65,678.5 сая)**

Аймгийн шууд дээр нэгтгэгдэж байгаад Баян-Өндөр сумын төв. Захирагчийн тайланд шилжүүлсэн.

## 1.2.2.02 Биет хөрөнгө

### ӨССӨН БАЙГУУЛЛАГУУД (107)

#### Тагнуулын Ерөнхий газар (+21,526.4 сая)

Төсвийн болон хөрөнгө оруулалтын зардлаар хөрөнгө бэлтгэсэн.

#### Төрийн тусгай хамгаалалтын газар (+10,363.3 сая)

Төлөвлөсөн хөтөлбөр арга хэмжээний хүрээнд байрилга байгууламж 1.9 тэрбум, техник тоног төхөөрөмж 2 тэрбум, тээврийн хэрэгсэл 6.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

#### Дарханы төмөрлөгийн үйлдвэр (+7,857.3 сая)

2025 оны бизнес төлөвлөгөөний дагуу хийгдсэн хөрөнгө оруулалтаар нэмэгдсэн. Нэмэгдсэн хөрөнгийн 5.1 тэрбум төгрөг нь Монголын төмөр зам ТӨХК-аас Төмөртэй өртөөг шилжүүлж авсантай холбоотойгоор ТӨБЗГ-ын тогтоолын дагуу төлбөртэй нөхцөлөөр шилжүүлэн авсан хөрөнгө байна.

#### Монголрос цветмет (+47,575.6 сая)

Уул уурхайн техник тоног төхөөрөмж болон шинээр АҮЭБЯамны харьяа уул уурхайн чиглэлийн далд уурхайн музейг ТӨБЗГ-ын 2025оны 12 сарын 23-ны 878 тоот тогтоолоор шилжүүлэн авсан.

#### Монголын газрын тос боловсруулах үйлдвэр (+524,898.5 сая)

ЕРС 01 багц ажлын хүрээнд нийт 9 барилга болон түүний дагалдах тоног төхөөрөмж, ГТҮ-ийн 95-1, оффис үйлчилгээний барилгууд ашиглалтанд орсноор өссөн.

#### Таван толгой төмөр зам (+2,810,346.6 сая)

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 103 дугаар "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээссийн гэрээгээр ашиглуулах арга хэмжээ авах, тус төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцоо нийлж үндсэн хөрөнгөд бүртгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг даалгасны дагуу тухайн төслийн хөрөнгүүдийг үндсэн хөрөнгөөр бүртгэж эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлсэн.

#### Эрдэнэс оюу толгой (+7,305.4 сая)

Барилга үндсэн хөрөнгөөр бүртгэж орлогот авснаар биет хөрөнгө өссөн.

#### Эрдэнэс таван толгой (+628,895.3 сая)

Уулын техникийг 390.5 тэрбум төгрөгөөр, дуусаагүй баридга болох конвейерын байгууламж 250.3 тэрбум төгрөгөөр, НБУ 98.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

#### Эрдэнэт үйлдвэр (+564,341.8 сая)

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,487,961.5 сая төгрөг болж, 564,341.8 сая төгрөгөөр өссөн нь дараах үзүүлэлтүүдээс хамаарсан байна. Үүнд: 1.Барилга байгууламжийн дахин үнэлгээг Тэгшхэм групп үнэлгээ ХХК-иар хийлгэж барилга байгууламжийн дансны үнэ 468,672.1 сая төгрөгөөр нэмэгдсэн. 2.Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хүрээнд худалдан авсан 294,973.1 сая төгрөг, 3.Дуусаагүй барилгын дансанд бүртгэлтэй 410 ширхэг хөрөнгийг ашиглалтад оруулж, үндсэн хөрөнгөд бүртгэсэн 160,129.9 сая төгрөг, 4.Их засвар, шинэчлэлийн ажилтай холбоотой 30,582.6 сая төгрөг, 5.Уул уурхайн зориулалттай 467.4 сая төгрөгийн хөрөнгүүд тус тус нэмэгдсэн.

#### Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл - 3/4342/ (+13,474.1 сая)

Дуусаагүй барилга байгууламж гүйцэтгэгчид олгосон урьдчилгаа төлбөрийн дүнгээр өссөн.

#### Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл -/3788/-ТХН (+49,266.7 сая)

Аудитын зөвлөмжийн дагуу бусад эргэлтийн хөрөнгөнд байсан үлдэгдлийг дуусаагүй барилга байгууламжинд шилжүүлсэн.

#### **Төрийн банк (+9,409.0 сая)**

Барилга байгууламж - 5.3 тэрбум, тээврийн хэрэгсэл - 2.36 тэрбум, компьютер болон тоног төхөөрөмж - 3 тэрбум, эд хогшил - 0.74 тэрбум, дуусаагүй барилга - 0.56 тэрбум төгрөгөөр тус тус өссөн ба бусад хөрөнгө/түрээсийн хөрөнгө, БЗХ/-2.56 тэрбум төгрөгөөр буурсантай холбоотой байна.

#### **УГЕГ - Дорноговь, Замын-Үүд дэх гаалийн газар (+8,920.6 сая)**

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах төслөөс 1,715.1 сая төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, 1,891.6 сая төгрөгийн лабораторийн барилга Гаалийн ерөнхий газрын бусад эргэлтийн хөрөнгөөс 5,313.9 сая төгрөгийн рентген тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлэн авч бүртгэлд тусгасан.

#### **УГЕГ - Өмнөговь Гашуун Сухайтын гаалийн хороо (+54,102.3 сая)**

1. ГЕГазраас -13,606.2 сая төгрөг 2.Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслөөс - 47,184.0 сая төгрөг 3. Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газраас – 267.2 сая төгрөгийн хөрөнгийг тус тус хүлээн авч үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгасан.

#### **УГЕГ - Увс аймаг дахь гаалийн хороо (+21,099.6 сая)**

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслөөс Боршоо хилийн боомтын бүтээн байгуулалт 19,463.6 сая төгрөгийн хөрөнгө ГЕГ-ын бусад эргэлтийн хөрөнгөөс Увс аймаг дахь гүний гаалийн шинэ конторын барилга 2,638.6 сая төгрөгийн хөрөнгө мөн Боршоо хилийн боомтын ариутгалын байгууламж нийт 1,062.0 сая төгрөгийн хөрөнгийг тус тус хүлээн авч үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгасан.

#### **Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл - нэмэлт-ТХН (+8,064.3 сая)**

Бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй дуусаагүй барилгыг Эргэлтийн бус хөрөнгөд бүртгэх шийдвэр гарсан. 2,111,957,719.65 төгрөгийн хөрөнгө оруулалт нэмэгдэж 21,178,675,738.70 төгрөгийн хөрөнгийг ашиглагчид шилжүүлсэн

#### **Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл-1 (+36,679.7 сая)**

Бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй дуусаагүй барилгыг Эргэлтийн бус хөрөнгөд бүртгэх шийдвэр гарсан. Тухайн онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт 3,585,779,532.12 ба шилжүүлсэн хөрөнгө -672,324,030.45 төгрөг байна.

#### **Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл /3895/-ТХН (+46,322.4 сая)**

Аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу Барилгын гүйцэтгэлийг хуримтлуулан бүртгэж байсан Урьдчилж төлсөн зардал дансны ангилалын өөрчилж дуусаагүй барилга дансруу шилжүүлсэн. Тайлант хугацааны элэгдэл тооцсон.

#### **Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1 дэх үе (+18,387.9 сая)**

Тайлант хугацаанд Увс аймгийн НЭ-ийн өргөтгөл, эмнэлгийн тоног төхөөрөмж, БЗД, ЧД, СХД-ийн өрхийн эмнэлэг, Тариалан, Баян-Өндөр, Эрдэнэ, Дашинчилэн сумын эрүүл мэндийн төвийн барилга болон эмнэлгийн тоног төхөөрөмж, ХУД-ийн НЭ-ийн барилгын гүйцэтгэл гарч 45,304.6 сая төгрөгөөр дуусаагүй барилга байгууламж данс өссөн ба Өвөрхангай аймгийн Баян-Өндөр СЭМТ-ийн барилга болон эмнэлгийн тоног төхөөрөмж, Увс аймгийн НЭ-ийн тоног төхөөрөмж, Дашинчилэн, Тариалан сумын ЭМТ-ийн эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу ашиглагч байгууллагад шилжүүлэн 18,817.8 сая төгрөгийг данснаас хассан. Мөн 8,048.8 сая төгрөгийг урьдчилгаа данс руу шилжүүлэн бүртгэсэн. Төслийн нэгжид ашиглаж буй үндсэн хөрөнгийн тайлант хугацааны элэгдэл 50.0 сая төгрөг бөгөөд тухайн дүнгээр биет бус хөрөнгийн баланс дээрх буурсан байна.

#### **Зэв (+12,000.6 сая)**

28.3 сая төгрөгийн хөрөнгийг татаас санхүүжилтээр худалдан авалт хийж 11,972.3 сая төгрөгийн үйлдвэрийн зориулалттай хөрөнгийг БХАҮН-ээс үнэ төлбөргүй хүлээн авсан.

**Зэвсэгт хүчний жанжин штаб (+91,983.9 сая)**

Батлан хамгаалах тухай хуулийг үндэслэн үндсэн хөрөнгийн хөдөлгөөний бүртгэлд тусгасан. УТХО, ЗХХСАН, нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээс үндсэн хөрөнгийн худалдан авалт авалт хийгдсэн болон гадаадын тусламжийн болон бараа материалын данснаас шилжүүлэн үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн.

**Бх. Аймгийн нэгдсэн эмнэлэг (+9,541.9 сая)**

ТӨБЗГ-ын 2025 оны 86 тогтоолоор амбулаторийн барилга шинээр орлогод авсан.

**Гэмтэл, согог судлалын үндэсний төв (+34,301.2 сая)**

ЭМС-ын 2025 оны А/05, А/344 тоот тушаалаар 36.4 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.

**Өв. Баян-Өндөр. Эмнэлэг (+6,238.7 сая)**

ТӨБЗГ-ын тогтоолоор Эмзэг бүлгийн иргэдийн төслөөр баригдсан барилга, тоног төхөөрөмж орогод авсан.

**Өв. Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг (Өв. Хархорин) (+11,425.9 сая)**

Өвөрхангай аймгийн ИТХ тогтоолоор эрх шилжин баригдсан 6.1 тэрбум төгрөгийн барилга, ЭМС-ын А/355 тушаалаар Люксембург төслийн санхүүжилтээр 1.0 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж авсан.

**УБ. Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв (+9,027.8 сая)**

ТӨБЗГ-ын тогтоолоор Амбулаторийн 9.3 тэрбум төгрөгийн барилга орлогод авсан.

**Ув. Аймгийн нэгдсэн эмнэлэг (+10,562.3 сая)**

ЭМС-ын 2025 оны А/355, А/373 тоот тушаалаар 11.2 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.

**Улсын гуравдугаар төв эмнэлэг (+8,143.2 сая)**

ЭМС-ын 2025 оны А/355, А/514 тоот тушаалаар 4.0 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Хөрөнгийн дахин үнэлгээгээ хийсэн.

**Улсын нэгдүгээр төв эмнэлэг (+12,717.5 сая)**

ЭМС-ын 2025 оны А/05, А/356, А/360 тоот тушаалаар 9.6 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Их засвар орлогодсон.

**Хавдар судлалын үндэсний төв (+16,808.3 сая)**

ЭМС-ын 2025 оны А/358, А/482, А/167 А/263 тушаалаар 41 тэрбумын тоног төхөөрөмж орлогодсон. Үүнд Австрийн төслийн тоног төхөөрөмж багтсан. Мөн 5.3 тэрбум төгрөгийн их засвар орлогодсон.

**Хүрээ амаржих газар (2) (+48,726.7 сая)**

Эмнэлгийн барилга 48 тэрбум төгрөгөөр орлогод авсан.

**Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (+35,422.8 сая)**

Их засвар болон ЭМС-ын тушаалаар хуваарилагдсан тоног төхөөрөмж орлогодсон.

**Архивын ерөнхий газар (+42,054.8 сая)**

Монгол Улсын Засгийн Газар болон БНСУ-ын Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн “Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт” төслийн хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг ТӨБЗГ-ын 2025 оны 292 дугаар тогтоолоор 54,4 тэрбум төгрөгийн хөрөнгийг орлогод авсан.

**Хил хамгаалах ерөнхий газар (+77,044.0 сая)**

УТХО, НҮБ, Хөгжлийн хөтөч, Бүс нутгийн хөгжил төсөл, дуусаагүй үйлдвэрлэлээс шилжүүлэн авсан барилга 21,661.8 сая төгрөг, УТХО, санхүүгийн түрээсээр авсан нисдэг тэрэг, автомашин 51,592.2 сая төгрөг, ТӨБЗГ-ын н/07 тогтоолоор үнэ, хугацаа шинэчлэн тогтоосон бүртгэсэн.

### **Хууль зүйн үндэсний хүрээлэн (+8,017.5 сая)**

ТӨБЗГ-ын 2025.12.24-ны өдрийн “Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 801 дугаар тогтоолоор хүрээлэнгийн оффисын шинэ барилгыг 7,4 тэрбум төгрөгөөр, ТӨБЗГ-ын 2025.12.31-ны өдрийн А1/2724 тоот албан бичгээр 2025 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон “Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/” УТ/2501201091 дугаартай төсөл арга хэмжээний 4 багц ажлын 725,5 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэсэн.

### **ЦЕГ - Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын нэгж (+7,205.8 сая)**

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албанаас худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 25 ширхэг тээврийн хэрэгсэл, 16 ширхэг цахилгаан дугуйг ЦЕГ-ын Санхүү, ар талын алба, ЦЕГ-ын гэрээт харуул хамгаалалтын албанаас балансаас балансад шилжүүлэн авч, данс бүртгэлд тусгаж, орлогод авсан.

### **ЦЕГ - Техник засварын төв (+6,289.3 сая)**

Нууцын байгууллага

### **ЦЕГ - Цагдаагийн автобааз (+13,950.5 сая)**

Шинээр худалдан авсан болон, түрээсийн гэрээгээр 2024 онд худалдан авсан 96 ширхэг тээврийн хэрэгсэл данс бүртгэлд тусгаж, орлогод авснаар өссөн үзүүлэлттэй байна.

### **ШШҮТ - Шүүх шинжилгээний ерөнхий газар (+6,629.1 сая)**

ТӨБЗГ-ын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 201 дүгээр "Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай" тогтоолоор ийслэлийн Шүүх шинжилгээний газраас нийт 7,338,951,845.60 төгрөгийн үлдэх өртөгтэй машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, автотээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэн авсан. Мөн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А-1/1597 дугаартай "Үндсэн хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай" албан бичгээр Цагдаагийн ерөнхий газраас 110,233,680.54 төгрөгийн Киа спортейж автомашин 1 ширхгийг шилжүүлэн авсан. Мөн газрын 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А-1/2579 дугаартай "Зөвшөөрөл олгох тухай" албан бичгээр Нийслэлийн шүүх шинжилгээний газраас 22,233,333.76 төгрөгийн 3 автомашин, Өмнөговь аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төвөөс 1 ширхэг 1,680,000 төгрөгийн усан ванн балансаас балансад шилжүүлэн авсан. ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А-2/2433 дугаартай "Зөвшөөрөл олгох тухай" албан бичгээр бусад үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 8,067,483.20 төгрөгийн хөрөнгийг батлан хамгаалах зориулалттай тоног төхөөрөмж дансанд, 214,800 төгрөгийн хөрөнгийг машин тоног төхөөрөмж дансанд, бусад нөөц данснаас 43,306,200 төгрөгийг машин тоног төхөөрөмж дансанд шилжүүлэн бүртгэсэн. Мөн газрын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн "Хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай" А-1/309 тоот албан бичиг, 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А-1/2579 дугаартай "Зөвшөөрөл олгох тухай" албан бичгүүдээр харьяа газар, төв, хэлтсүүдэд 136,538,000 төгрөгийн балансын үнэтэй машин тоног төхөөрөмж, автомашин шилжүүлсэн. ТӨБЗГ-ын 2025 оны 02 дугаар 20-ны өдрийн 98, 2025 оны 12 дугаар сарын 17-ны өрийн 780 дугаар "Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай" тогтоолоор 672,047,216.60 төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан. ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А-1/2506 дугаартай "Хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай" албан бичгээр Хьюндай соната маркийн 22,757,400 төгрөгийн балансын үнэтэй 1 ширхэг автомашиныг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах ажлын албанд шилжүүлэн өгсөн. Мөн газрын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 368 дугаар "Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай" тогтоолоор 81,468,030 төгрөгийн машин тоног төхөөрөмжийг 32,587,212 төгрөгөөр, 23,598,349.4 төгрөгийн тавилга эд хогшлыг 9,439,339.8 төгрөгөөр, 4,500,000 төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг 1,800,000 төгрөгөөр, 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 737 дугаар "Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай" тогтоолоор 36,495,050 төгрөгийн машин тоног төхөөрөмжийг 21,897,030 төгрөгөөр, 31,606,000 төгрөгийн тавилга эд хогшлыг 18,963,600 төгрөгөөр тус тус үнэ, ашиглах жилийг шинэчилсэн.

### **Ар. Батцэнгэл. Сургууль /Ахлах/ (+6,368.6 сая)**

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 05/21 тоот орон нутгийн өмчид эд хөрөнгө хүлээн авах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай тогтоолоор сургуулийн 320 хүүхдийн суудал бүхий

өргөтгөлийн барилга 6,066,405,969 төгрөгийн, аймгийн орон нутгийн өмчийн газрын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 213 тоот зөвшөөрлөөр дотуур байрын их засварын капиталжуулалтаар 224,089,510 төгрөгийн хөрөнгийг бшртгэсэн авснаар өссөн байна.

**Ар. Цахир. Сургууль /Ахлах/ (+7,277.3 сая)**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 700 дугаар тогтоолын дагуу 5,375,678,572 төгрөгийн өртөг бүхий 3 давхар хичээлийн байрыг, аймгийн өмчийн газрын зөвшөөрлөөр бусад үндсэн хөрөнгө 1,706,901,428 төгрөгийн, машин тоног төхөөрөмж 87,250,647 төгрөгийн, тавилга 183,048,532 төгрөгийн, ном сурах бичиг 26,447,955 төгрөгийн, программ хангамж 132,000 төгрөгийн хөрөнгийг бүртгэж авснаар өссөн байна.

**Да. Дархан. Сургууль /31-р/ (+14,511.8 сая)**

Шинээр 2024 онд байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн сургуулийн хөрөнгийг Төрийн бодлого зохицуулалтын газраас 2025 онд гарсан тогтоолоор санхүүгийн тайланд хөрөнгийг бүртгэж авснаар өссөн байна.

**Да. Дархан. Сургууль /9-р/ (+7,700.0 сая)**

Шинээр 2024 онд байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн сургуулийн хөрөнгийг Төрийн бодлого зохицуулалтын газраас 2025 онд гарсан тогтоолоор санхүүгийн тайланд хөрөнгийг бүртгэж авснаар өссөн байна.

**До. Замын-Үүд. Сургууль /4-р/ (+9,982.1 сая)**

Тайлант он буюу 2025 оны 08 сард 640 хүүхдийн хичээлийн шинэ байр 9,200,000,000 төгрөг, бусад үндсэн хөрөнгө болох ширээ сандал, ном сурах бичиг болон бусад хөрөнгийн 784,081,672.43 төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

**Ду. Сайнцагаан. Сургууль /2-р/ (+14,288.5 сая)**

Шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн сургуулийн хөрөнгийг Төрийн бодлого зохицуулалтын газраас 2025 онд гарсан тогтоолоор санхүүгийн тайланд хөрөнгийг бүртгэж авснаар өссөн байна.

**Ду. Сайнцагаан. Сургууль /3-р/ (+11,177.9 сая)**

Шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн сургуулийн хөрөнгийг Төрийн бодлого зохицуулалтын газраас 2025 онд гарсан тогтоолоор санхүүгийн тайланд хөрөнгийг бүртгэж авснаар өссөн байна.

**МБСБ - Орхон аймаг дахь Политехник коллеж (+9,840.0 сая)**

ТӨБЗГ-ын даргын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 700 тоот тогтоолын дагуу 2013 оноос баригдаж эхэлсэн МСҮТ-ийн хичээлийн байр 10,557,657,904 төгрөгийн өртөг бүхий барилгыг хөрөнгийн орлогод бүртгээ, 2025 оны 05 дүгээр сарын 01-ны өдрийн 229 тоот тогтоолын дагуу Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургуулиас балансаас балансад 1 машин шилжилж ирсэн.

**Монгол тэмүүлэл - Олон Улсын Хөтөлбөрийн Сургалттай Төрийн Өмчит ЕБС (+8,057.1 сая)**

Шинэ барилга хүлээн авсантай холбоотой хөрөнгө өссөн.

**Өв. Бат-Өлзий 2-р сургууль (+7,483.7 сая)**

Хичээлийн 440 хүүхдийн байр нь 2023 онд ашиглалтад орсноор сумын 1 дүгээр сургуулийн балансад бүртгэгдсэн байсан ба 2025 онд аймгийн ИТХ-ын шийдвэрээр 1 дүгээр сургуулиас 2 дугаар сургууль руу барилгыг нь шилжүүлсэн.

**Өв. Хархорин. Сургууль /1-р/ (+7,177.6 сая)**

Хичээлийн 320 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн өргөтгөл 2025 онд баригдаж ашиглалтад орсныг аймгийн ИТХ-ын шийдвэрээр балансад бүртгэсэн.

**Өм. Даланзадгад. Сургууль /2-р/ (+6,886.1 сая)**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Даланзадгад сумын Ерөнхий Боловсролын 2-р сургуулийн Дотуур байр баригдаж 2025 оны 12 сард улсын комисс хүлээн авсантай холбогдолтойгоор сургуулийн дотуур байрыг хөрөнгөд бүртгэж авсан. /хөрөнгө балансад авах тогтоол шийдвэр байгаа уу/

**Өм. Даланзадгад. Сургууль /6-р/ (+19,599.7 сая)**

2025 оны 3 сард шинээр ашиглалтанд орсон ба барилга 18,045,356,323.36, то.тө-824,952,497.61, 718,013,471.67 тавилга шинээр бүртгэсэн.

**Сү. Баруун-Урт. Сургууль /3-р/ (+9,901.7 сая)**

Шинээр сургуулийн барилга ашиглалтанд орсон тул бүртгэлд тусгасан.

**Уб. Бг. Сургууль /28-р/ (+15,513.9 сая)**

2025 онд 960 хүүхдийн хичээлийн шинэ байр ашиглалтанд орсон. Барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад тоног төхөөрөмж нэмэгдсэн. /хөрөнгө бүртгэж авах тогтоол шийдвэр байна уу/

**Уб. Бг. Сургууль /93-р/ (+12,098.0 сая)**

2025 онд 640 хүүхдийн хичээлийн шинэ байр ашиглалтанд орсон. Барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад тоног төхөөрөмж нэмэгдсэн. /хөрөнгө бүртгэж авах тогтоол шийдвэр байна уу/

**Уб. На. Сургууль /Голомт, цогцолбор/ (+11,908.7 сая)**

Хичээлийн шинэ байраа орлогод авсан.

**Уб. Сх. Сургууль /12-р/ (+20,545.3 сая)**

2024 онд ашиглалтад орсон хичээлийн А байраа орлогод авсан.

**Уб. Сх. Цэцэрлэг /341-р/ (+6,490.5 сая)**

Шинээр ашиглалтанд орсон тул цэцэрлэгийн барилгыг орлогод авсан.

**Уб. Чи. Сургууль /5-р/ (+6,712.8 сая)**

Бага сургууль ашиглалтанд орж барилга шинээр бүртгэж авсан.

**Ув. Улаангом. Сургууль /Шинэ ирээдүй, цогцолбор/ (+15,560.4 сая)**

Шинээр сургуулийн барилга ашиглалтанд орсон тул бүртгэлд тусгасан.

**Ув. Хяргас. Сургууль /Ахлах/ (+7,579.9 сая)**

Шинээр сургуулийн барилга ашиглалтанд орсон тул бүртгэлд тусгасан.

**Хө. Жаргалант. Сургууль (+14,573.1 сая)**

2025 онд 640 хүүхдийн хичээлийн байр ашиглалтанд орсон. Мөн нөхөн хангалтын тавилга тоног төхөөрөмж нэмэгдсэн.

**Хө. Чандмань-Өндөр. Сургууль (+6,796.3 сая)**

2025 онд 320 хүүхдийн хичээлийн байр ашиглалтанд орсон. Бусад тоног төхөөрөмж тавилга нэмэгдсэн.

**Хэ. Жаргалтхаан. Сургууль /11 жилийн/ (+7,141.4 сая)**

Шинээр сургуулийн барилга ашиглалтанд орсон тул бүртгэлд тусгасан.

**АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТЫН НЭГТГЭЛ (+17,001.2 сая)**

20 АЗЗА-ТӨХК-ийг 2025.04.11-ний өдрөөр тасалбар болгон татварын ерөнхий газараас хасалтын картаар татан буулгаж тайлан балансыг албан ёсоор нэгтгэсэн. Биет хөрөнгийн өсөлт огцом өссөн байгаа нь 20 ТӨХК-тай баланс нэгдээгүй байсны эхний үлдэгдэл бөгөөд 20 сарбарын авлага нийлсэнээр өндөр өсөлттэй харагдаж байна.

**Авто тээврийн үндэсний төв (+13,729.9 сая)**

2025 онын санхүүгийн тайлангаар Биет үндсэн хөрөнгө -2.6 тэр бум төгрөгөөр, Дуусаагүй барилга данс - "Тээвэрчдийн ордны барилга"-9.6 тэр бум, Цогтцэций салбар барилга-1.5 тэр бум төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

### **Монголын төмөр зам (+419,359.9 сая)**

1.ТӨБЗГ-ын 2025 оны 797 дугаар тогтоолыг үндэслэн ТТ-ЗБ чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын үр дүнд бий болсон 1,272.9 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, замын дээд бүтций хөрөнгөд орлого авсан. 2.ТӨБЗГ-ын 2025 оны 34-р тогтоолыг үндэслэн 6.6 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг “Дархан төмөрлөгийн үйлдвэр”ХХК-д шилжүүлсэн.

### **Эрчис ойл (+49,165.0 сая)**

Тайлант Үндсэн хөрөнгийн 2025 оны эхний үлдэгдэл 51,999,946.84 төгрөг эцсийн үлдэгдэл 49,216,952,566.74 төгрөг үндсэн хөрөнгө 49,164,925,619.9 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Монгол улсын засгийн газрын 2025 оны 03 дугаар 19-ний №146 дугаар тогтоол,Төрийн өмчийн хорооны 2025 оны 10 сарын 23-ны №513 тоот тогтоолоор Замын-Үүд дэх “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үл хөдлөх үндсэн хөрөнгө болон бусад эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авах, Монгол улсын засгийн газрын 2025 оны 03 сарын 19-ний №136 дугаар тогтоол, Монгол улсын засгийн газрын 2025 оны 03 сарын 06-ны №116 тоот тогтоолоор тус тус балансаас балансад шилжүүлэн авсан.

### **Алтай-Улиастайн эрчим хүчний систем (+12,196.1 сая)**

ТӨБЗГ-н 2025 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 714 дугаар тогтоолоор Борх нарны станц, сэрвэн батерай хуримтлуурын станц 22,601.4 сая төгрөгийн хөрөнгийг Богдын гол УЦС ХХК-д бүртгэх шийдвэр гарсантай холбоотой нэмэгдсэн. Мөн 2025 оны худалдан авах төлөвлөгөөний дагуу 4,350.1 сая төгрөгийн хөрөнгө, нэмэгдсэн. Тайлант хугацаанд ТӨБЗГ-н 2025 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн 604 дугаар тогтоолоор 4,819.8 сая төгрөгийн хөрөнгийг ЦДҮС ТӨХК-д шилжүүлсэн.

### **Амгалан дулааны станц (+9,206.1 сая)**

116МВт зуухны өргөтгөлийн төсөл бүрэн хэрэгжиж, улсын комисс хүлээн авсан тул холбогдох тоног төхөөрөмж, хөрөнгийг бүртгэлд тусгасантай холбоотой өссөн.

### **Дорнод бүсийн эрчим хүчний систем (+16,848.3 сая)**

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 29780.2 сая төгрөгөөр, биет бус хөрөнгө 313.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдэлд 13,021.6 сая төгрөг байгуулсан байна. Монгол улсын Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ний өдрийн А/16 тоот тушаалаар баталсан "ДБЭХС" ТӨХК-ийн 2025 онд их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажил 4,920.94 сая төгрөг батлагдаж, үндсэн хөрөнгийн 811.49 сая төгрөгийн худалдан авалт, 553.51сая төгрөгийн капиталжуулалт хийгдсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 05 ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн 26,224.17 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг бүртгэв. Монгол улсын Эрчим хүчний сайдын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/307 тоот тушаалаар баталсан "ДБЭХС" ТӨХК-ийн 2024 онд их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын тодотгосон төлөвлөгөөнд тусгагдсан ХА/2024/54 тоот гэрээний дагуу 2025.03.20 ны өдөр өөрөө буулгагч Нowo брендийн 10тн автомашиныг 71.07 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалт хийсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 775 дугаар тогтоолоор 83 нэр төрлийн 99 ширхэг 430.68 сая төгрөгийн өртөгтэй, 392.96 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 37.71 сая төгрөгийн үлдэгдэл өртөйтэй хөрөнгийг акталж данснаас хассан. Монгол улсын Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ний өдрийн А/16 тоот тушаалаар баталсан "ДБЭХС" ТӨХК-ийн 2025 онд их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажил 4,920.94 сая төгрөг батлагдаж үүнээс 108.55 сая төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэгдсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 05 ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн 26,224.17 саятөгрөгийн дахин үнэлэгдэж үүнээс 97.78 сая төгрөгийн биет бус хөрөнгийн дахин үнэлгээг бүртгэв. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 775 дугаар тогтоолоор 1 нэр төрлийн 1 ширхэг 7.7 сая төгрөгийн өртөгтэй, 7.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй биет бус хөрөнгийг акталж данснаас хассан.

### **Дулааны гуравдугаар цахилгаан станц (+55,771.3 сая)**

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгдсэний үр дүнг тайлант хугацаанд тусгасан. Хөрөнгийн бодит үнэ цэнэ 63,533,199.1 мян төгрөгөөр нэмэгдсэн. Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний ажлын гүйцэтгэлээр 19,589,150.32 мян төгрөгийн капиталжуулалт хийгдсэн. Хөрөнгө оруулалтаар шинээр худалдсан авсан хөрөнгийн дүн 4,592,681.5 мян төг байна. Үүнд: тоног төхөөрөмж - 2,236,539.6 мян төг, тээврийн хэрэгсэл - 2,059,865.4 мян төг, тавилга эд хогшил - 42,846.4 мян төг, компьютер, бусад хэрэгсэл - 162,123.6 мян төг, биет бус хөрөнгө - 91,306.4 мян төг байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 29 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон 168 нэр төрлийн 4,583,425.73 төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгүүдийг акталж, данс бүртгэлээс хассан.

### **Улаангомын дулааны хоёрдугаар станц (+6,553.8 сая)**

Төрийн өмчийн хорооны 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 714 тоот тогтоолоор 8,519,691,962.00 төгрөгийн өртөгтэй хөрөнгийг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн нь биет хөрөнгө өсөх шалтгаан болсон байна.

### **Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ (+63,238.5 сая)**

Засгийн газрын 2025 оны 30 дугаар тогтоолын дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 604, 605 дугаар тогтоолоор Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК болон Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-аас шилжиж ирсэн хөрөнгө, болон ИЗА ТЗБАХ хөрөнгө орлуулалтын төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг хийж хөрөнгө бүртгэсэн.

### **Эрдэнэтийн ДЦС (+204,864.3 сая)**

ТГ -4 өртөгтөлийг орлогод авч бүртгэлд тусгасан.

### **Үндэсний дата төв /ЦХИХХС/ (+20,358.0 сая)**

ЦХИХХЯ-ны яамны төрийн нарийн бичгийн даргын 2025.08.20-ны өдрийн А/244 тоот тушаалаар ухаалаг засаг - 2 төслийн гэрээний дагуу 12 нэр төрлийн 80206 ширхэг 22,094.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан нь хөрөнгө өсөхөд гол нөлөө үзүүлсэн.

### **Цэцэрлэг хотын хот тохижилтийн газар (+13,613.2 сая)**

2024 онд төсвийн байгууллага байсан ба 2025 онд ОНӨААТҮГ болон өөрчлөгдснөөр өссөн байна.

### **ЦШСГазар (+8,511.8 сая)**

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Алтай Таван Богдын бүсэд шинээр цахилгаан хангамж 3,548.1 мянган төгрөг, Цэнгэл сумын 1,2 дугаар заставт цахилгаан хангамж 3,724.7 мянган төгрөг, Өлгий сумын айл өрхүүдэд ухаалаг тоолуур тавих зардалд 367.3 мянган төгрөг, Өлгий сум болон бусад сумдад дэд станц барихад 514.3 мянган төгрөгөөр хийгдсэн хөрөнгө бүртгэгдсэн. Байгууллагын өөрийн хөрөнгөөр тээврийн хэрэгсэл 177.0 мянган төгрөгөөр, бусад тавилга, тоног төхөөрөмж 232.7 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэн тайлант онд хөрөнгийн орлогод авсан байна.

### **До. Өргөн. Засаг даргын тамгын газар (+6,454.2 сая)**

Туслах замаас сумын төв хүртэлх 18.3 км зам 6.3 тэрбум, Сүмбэр багт скайтелийн сүлжээ оруулсан 300.0 сая төгрөгийн биет бус хөрөнгийг бүртгэсэн.

### **До. Сайншанд. Хот тохижилтийн алба (+23,854.0 сая)**

Сайншанд хотын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02/06 дугаар тогтоолоор Сайншанд тохижилт үйлчилгээний газар болон Захирагчийн ажлын алба гэж бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэн. Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 04/02 дугаар тогтоолоор 11.3 тэрбум төгрөгийг хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авсан. Мөн ОНХО-аар 12.5 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

### **Гурвансайхан орон сууцны корпораци (+7,850.7 сая)**

2026 онд нийт 8,585,624.6 мянган төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

### **Гүний ус (+11,063.7 сая)**

2025 онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн цэвэр бохир усны шугам сүлжээний өргөтгөлийг бүртгэсэн болно.

**Өм. Даланзадгад хотын ЗААлба (+22,703.6 сая)**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 2,134,443,736 төгрөгийн Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн барилга, 311,722,500 төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 22,836,052.15 төгрөгийн Тавилга, аж ахуйн эд хогшил, 13,476,410,063 төгрөгийн авто зам, Зам, гүүрийн байгууламж болон Бусад үндсэн хөрөнгийг шинээр орлого авсан байна.

**Өм. Ханбогд. Засаг даргын тамгын газар (+57,635.5 сая)**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн бүтээн байгуулалт хөрөнгийн нэмэгдэл Зам, зогсоол, барилга байгууламж, Мөн аймгаас хийгдсэн дэмчогийн зам Онцгойн 66 ангийн барилга бусад хөрөнгө оруулалтаар бий болсон үндсэн хөрөнгийн нэмэгдсэн дүн.

**Өм. Ханхонгор. Засаг даргын тамгын газар (+18,799.7 сая)**

2025 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХСан, Говийн оюу хөгжилийг дэмжих сан болон бусад эх үүсвэрээр бий болсон 20,104,332.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгасан ба үүний дотор Даланзадгад Ханхонгор сумын чиглэлийн 12.5 км зам ашиглалтанд орж 18,019,517,158 төгрөгөөр замын байгууламжийг бүртгэсэн болно.

**Өм. Цогтцэций. Засаг даргын тамгын газар (+18,930.4 сая)**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 26-н төсөл арга хэмжээг үндсэн хөрөнгийн бүртгэлд шинээр бүртгэсэн.

**Тэгш дүүрэн тохижилт (+6,438.9 сая)**

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах барилга, байгууламж, офиссын барилга болон Хог тээвэрлэх машин, техник хэрэгслээр хангах, тавилга хэрэгслээр хангах ажлуудыг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн.

**Хөгжил хөрөнгө оруулалтын газар (+11,159.6 сая)**

Улаанбаатар хот дахь оюутны хотхны барилга байгууламж, тавилга аж ахуйн эд хогшил, тоног төхөөрөмж шинээр нэмэгдсэн.

**Дөрвөлж (+13,684.3 сая)**

Дамжууланзээлээр баригдсан барилга байгууламжийг хөрөнгөд бүртгэх холбогдох байгууллагын шийдвэрийн дагуу ашиглагч байгууллагад хөрөнгөд бүртгэсэн.

**Тө. Батсүмбэр. Засаг даргын тамгын газар (+8,340.3 сая)**

Цогт-Өндөр, Үдлэг 2 багт бага сургуулийн Сөгнөгөрийн услалтын системийг шинээр бүртгэн авсан.

**Тө. Сэргэлэн. Засаг даргын тамгын газар (+10,227.4 сая)**

Халаалтын Уурын зуух шинээр 4.3 тэрбум, сумын төвийн автозамыг шинээр 5.1 тэрбум төгрөгөөр бүртгэж орлого авсан.

**Улаангом тохижилт үйлчилгээ улсын төсөвт үйлдвэрийн газар (+21,036.5 сая)**

Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь 19,1 тэрбум төгрөгийн зам гүүрийн байгууламжийн үндсэн хөрөнгийг баланс хооронд шилжүүлэн авсан ба аймаг, сумын ХО-аар хийгдсэн 2.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусшасан.

**Хо. Мөст. Засаг даргын тамгын газар (+9,675.7 сая)**

Мөст сумын Засаг даргын тамгын газар 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан замын барилга байгууламжийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр орлого авсан учир үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

**Хэнтий-Ус (+49,817.5 сая)**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй ирсэн Бэрх станцын 15.0 тэрбум болон 1.2-р багийн шугам сүлжээний 29.4 тэрбумыг тайлант онд бүртгэж авсан. Мөн тухайн онд биет бус хөрөнгөд бүртгэсэн байсан үндсэн хөрөнгийг дансыг засаж биет хөрөнгө дансанд бүртгэсэн.

### **Зорчигч тээвэр 3 (+8,682.6 сая)**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 48,045,745.53 мянган төгрөг болж өмнөх оноос 9,462,122.29 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Нийслэлийн засаг даргын 2025 оны А/800 дугаар захирамж, “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГазрын даргын А/47 тоот тушаалаар автобус паркийн угаалгын цех, кузов засварын барилга, байгууламж 3,154,329.14 мянган төгрөг, Нийслэлийн засаг даргын 2025 оны А/1308 дугаар захирамж, “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГазрын даргын А/76 тоот тушаалаар Шатахуун түгээх станцын барилга 184,000 мянган төгрөгөөр, Нийслэлийн Засаг даргын А/1428 дугаар захирамж, Даргын А/66 дугаар тушаалаар 3 дугаар гараашийн барилга 7,978,139.2 мянган төгрөгийг данс бүртгэлд тусган орлогод авсан орлогод авсан, Нийслэлийн Өмчийн харилцааны газрыг албан бичгээр Ай Ст Ти групп ХК-аас хүлээн авсан хөрөнгийг Даргын А/85 тоот тушаалаар орлогод авсан. Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГазрын даргын тушаалаар нийт Машин тоног төхөөрөмж 223,907.89 мянган төгрөг, Компьютер дагалдах хэрэгсэл 164,978.00 мянган төгрөг, Тээврийн хэрэгсэл 134,200.00 мянган төгрөг, тавилга эд хогшил 54,055.00 мянган төгрөг, 10,670.00 мянган төгрөгөөр бусад хөрөнгийг данс бүртгэлд бүртгэсэн.

### **Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ (+9,725.7 сая)**

Нийт 11,086,222,834 төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж 764,042,588.17 төгрөгөөр хөрөнгө хасагдаж, 1,846,286,026.28 төгрөгөөр элэгдэл тооцсон болно.

### **Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ (+21,931.8 сая)**

2025.10.22-ны НЗД-н А/1484 Захирамж. НЗДТГ-н Багаж тоног төхөөрөмжийн зардлаас 31.000.000, 2025.10.13-нд Суурин компьютер 10ш нийт 49.077.000, НАОБТГ-ын даргын 2024.12.10-ны 01/958 Угаарын хий мэдрэгчийн төхөөрөмжийн төлбөр 157.000ш 150.000 төгрөгөөр нийт 23.550.000.001 болсоныг бүртгэсэн болно.

### **Уб. Бз. Засаг даргын тамгын газар (+16,661.8 сая)**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 207,004,549.0 мянган төгрөг болж 16,039,208.0 мянган төгрөгөөр өссөн нь НӨХГ-ын 1/1640 дугаар албан бичгээр 1,966,800.0 мянган төгрөгийн 16 дугаар хорооны ӨЭМТ-ын барилга, гадна тохижилт, явган зам, НӨХГ-ын 1/1702 дугаар албан бичгээр 42,220.8 мянган төгрөгийн Налайх дүүргийн цагдаагийн постын газар, барилга, Нийслэлийн Засаг даргын 03/6183 дугаар захирамжаар 114,474.0 мянган төгрөгийн өртөг бүхий автобусны хяналтын камер, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 34,653,489.7 мянган төгрөгийн авто зам, гэрэлтүүлэг, тохижилтын ажлууд, 298,750.0 мянган төгрөгийн барилга, 271,522.4 мянган төгрөгийн компьютер, принтер, 500,750.0 мянган төгрөгийн цагаан давааны хог дээр баригдсан цаас боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 184,315.7 мянган төгрөг тавилга, тоног төхөөрөмж зэрэг нийт 38,032,322.5 мянган төгрөгийн орлого бүртгэсэн.

### **Уб. Замын хөдөлгөөний удирдлагын төв (+12,697.8 сая)**

1.Нийслэлийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн МН/002 дугаартай "Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлагын төвд байрлах нэгдсэн дата төвд шаардлагатай сервер, тоног төхөөрөмж, программ хангамж нийлүүлэх" гэрээг байгуулж тус ажлын хүрээнд 8,188,041.8 мянган төгрөгийн үнэ бүхий өртөгтэй хөрөнгийг хүлээн авсан. 2.Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн МН/004 дугаартай захирамжийн хүрээнд "Нэгдсэн хяналт, удирдлагын төвийн серверийн өрөөнд шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах" гэрээг байгуулж нийт 2,170,198.4 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг хүлээн авсан. 3.Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн МН/005 дугаартай захирамжийн хүрээнд "Нэгдсэн хяналт, удирдлагын төвийн серверийн өрөөнд шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах" гэрээг байгуулж нийт 1,825,670.0 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг хүлээн авсан.

### **Уб. Соёлын төв өргөө (+14,093.0 сая)**

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 14,969,064.2 мянган төгрөг болж, 14,258,762.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд өөрийн хөрөнгөөр 94,637.55 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, мөн Нийслэлийн Засаг

даргын 2025 оны А/796 дугаар захирамж, НӨХГ-ын 1/953, 1/1932 дугаар шийдвэр, НСТӨ ОНӨААТҮГ-ын захирлын А/37 дугаар тушаалын дагуу нийт 17,881,112.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр (үүнээс 3,236,406.8 мянган төгрөгийн элэгдэлтэй) хүлээн авсан, түүнчлэн НӨХГ-ын даргын А/25 дугаар тушаалаар 480,137.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 443,114.3 мянган төгрөгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

#### **Уб. Сх. Засаг даргын тамгын газар (+6,908.0 сая)**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 31,503,275.4 мянган төгрөг болж 6,902,006.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 1,092,891.1 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 7,069,990.3 мянган төгрөг, шилжүүлэн авсан 24,900.0 мянган төгрөг, нийт 8,187,781.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, 24,900.0 мянган төгрөгийн хөрөнгийг дотооддоо шилжүүлж, тайлант онд 1,260,875.3 мянган төгрөгийн элэгдэл тооцсоноос шалтгаалжээ.

#### **Улаанбаатар смарт карт ХХК (+14,414.9 сая)**

2025 оны биет үндсэн хөрөнгийн хөдөлгөөн: тоног төхөөрөмж 907,154,568.16 төгрөг, тээврийн хэрэгсэл 113,800,000 төгрөг, тавилга эд хогшил 41,779,615 төгрөг, компьютер бусд хэрэгсэл 67,508,200 төгрөг, нийт 1,130,242,383.16 төгрөгийн хөрөнгө худалдан авч 25,301,933.38 төгрөгийн тоног төхөөрөмж, 783,233 төгрөгийн компьютер нийт 26,085,166.38 төгрөгийн хөрөнгө актласан. Энэ онд 2,147,633,326.21 төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл үүссэн. 2025 оны 12 сарын 31 өдрийн 1/2444 тоот Өмчийн харилцааны газраас ирсэн хөрөнгө бүртгэх тухай албан бичигт заасан 12,866,492,694 төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалтаас 11,703,792,694 төгрөгийн хөрөнгийг тоног төхөөрөмж нэмж бүртгэсэнтэй холбоотой өөрчлөлт

#### **Улаанбаатар хотын хөгжлийн корпораци (+267,428.6 сая)**

Улаанбаатар Энержи ХХК-ийн Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 274,632,300.8 мянган төгрөг болж нэмэгдсэн нь тайлант онд "Багануур Батерей хуримтлуурын станцын 220/\*110/35 кВ-ын дэд станцын 110кВ-ын хуваарилах байгууламжийн өргөтгөл, 110/35 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35 кВ-ын дэд станц, 50 МВт-ын хүчин чадалтай 200 МВт.цагийн багтаамж бүхий эрчим хүчний хуримтлуурын станцын барилга, байгууламж, тоног төхөөрөмж нийт 286,141,012.0 төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого болгосон, 160,109.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, тайлант онд 11,668.8 мянган төгрөгийн элэгдэл тооцон бүртгэсэн нь голчлон нөлөөлсөн байна.

#### **Ус сувгийн удирдах газар (+16,173.2 сая)**

Биет хөрөнгө оны эхэнд 274,515,867.7 мянган төгрөг байсан бол оны эцэст 290,689,113.7 мянган төгрөг болж 16,173,246.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь өөрийн хөрөнгө оруулалтаар 7,119,013.6 мянган төгрөг, их засвараар 1,997,952.0 мянган төгрөг, бараа материалаас 39,748.2 мянган төгрөг, шугам доторлогоо хийгдсэн 2,388,041.7 мянган төгрөг, улс нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 29,296,607.1 мянган төгрөг, хандив тусламжаар 190,000.0 мянган төгрөг нийт 41,031,362.5 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж, НӨХГ-ын даргын А/75, А/107, А/248 дугаар тушаалаар 3,283,121.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасаж, 263,000.0 мянган төгрөгийн 3 тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэн нийт 3,546,121.8 мянган төгрөгөөр биет хөрөнгө буурсан байна. Мөн УБЗААлбатай хотын аж ахуйн ажил, үйлчилгээнд нэн шаардлагатай тусгай зориулалтын машин механизмыг төлбөртэй ашиглуулах гэрээг байгуулан 2,014,000.0 мянган төгрөгийн 8 тээврийн хэрэгслийг бусад эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэсэн.

#### **Ор. Баян-Өндөр. Хот тохижуулах газар (+83,415.2 сая)**

Өмнөх онд аймгийн шууд дээр нэгтгэгддэг байсан учраас Эхний үлдэгдэл нь аймгийн шууд дээр байгаа.

#### **Эрдэнэт-Ус (+22,757.1 сая)**

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ИШСүлжээ, дэд бүтцүүдийн хөрөнгийг орон нутгаас шилжүүлсэн тул хөрөнгө өссөн.

## **БУУРСАН БАЙГУУЛЛАГУУД (93)**

### **Шивээ овоо (-4,410.8 сая)**

Биет хөрөнгийн данс нь 71,088.6 сая төгрөгт хүрч 4,410.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардал 14,056.6 сая төгрөгөөр тооцсонтой холбоотой.

### **Эрдэнэс алт ресурс (-14,017.9 сая)**

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 4.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 19.3 тэрбум төгрөгийн элэгдэл байгуулсан, 396.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассан.

### **Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар (-1,154.7 сая)**

Засгийн газрын 2025 оын 90 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2024 оны 21 дүгээр хуралдааны тэмдэглэлээр 1.1 тэрбум төгрөгийн ДБУЭГ-т бүртгэлтэй барилгыг ГХЯ-ны балансаас балансад шилжүүлснээр гарсан өөрчлөлт байна.

### **Дипломат төлөөлөгчийн газар (-4,466.7 сая)**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 769, 307 тоот тогтоолуудаар 13 ДТГ-ын 15 автомашин, 1 чиргүүл, 1 мопед нийт 2,805.7 сая төгрөгийн автомашин тээврийн хэрэгслийг, 768, 306 тоот тогтоолоор 34 ДТГ-ын 2,398.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлийг акталж дансаас хассан байна.

### **УГЕГ - Өмнөговь Шивээ хүрэн гаалийн хороо (-1,251.7 сая)**

Тайлант хугацааны элэгдэлийн дүнгээр нийт хөрөнгийн дүн буурсан үзүүлэлттэй байна.

### **УГЕГ - Үйлчилгээний алба (-3,171.9 сая)**

Тайлант хугацааны элэгдэлийн дүнгээр нийт хөрөнгийн дүн буурсан үзүүлэлттэй байна.

### **ҮТЕГ - Өмнөговь аймгийн татварын хэлтэс (-1,109.4 сая)**

2024 оны жилийн эцсийн аудитын дүгнэлтээр Үндсэн хөрөнгөд 1,097,190.5 мянган төгрөгийн өртөгтэй орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдсан барилга давхар бүртгэлтэй байна гэж өгсөн зөвлөмжийн дагуу ТӨБЗГ-ын 2025 оны А-1/2287 тоот албан бичгийн дагуу орон нутгийн өмчид шилжүүлсэн.

### **Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл /Хятад/ (-108,144.6 сая)**

БНХАУ -ын дамжуулан зээлийн эх үүсвэрээр хэрэгжижи дууссан төслийн хөрөнгө болох 35 МВт-ын турбин генераторын барилга угсралтын ажил, тоног төхөөрөмжийг ТӨБЗГ-ын тогтоол гарч "эрдэнэтийн дулааний цахилгаан станц" ТӨХК нь хөрөнгөд бүртгэн авч төслийн эргэлтийн хөрөнгөөс хассан.

### **Цэргийн төв эмнэлэг (-4,288.0 сая)**

2025 оны жилийн эхний хуримлагдсан элэгдлийн үлдэгдэл 31,554,980,416.98 төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд 4,710,943,569.26 төгрөгийн элэгдлийн зардал нэмэгдэж жилийн эцэст 36,265,923,986.24 төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэлтэй болсон бөгөөд зөрүү нь хөрөнгийн анхны өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хассан үлдэгдэл байна. Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/496 дугаар тушаалаар Зэвсэгт хүчний 189 дүгээр ангиас 7 нэр төрлийн 22,907.5 мянган төгрөгийн компьютерийг үнэ төлбөргүй хүлээн авсан. Мөн сайдын 2025 оны А/500 дугаар тушаалаар эмнэлгийн төв корпус, гал тогооны барилгад 323,018.4 мянган төгрөгөөр нэмж капиталжуулалт хийгдсэн. Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/501 дүгээр тушаалаар 27 нэр төрлийн 283,154.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг эргэлтийн хөрөнгөнөөс шилжүүлэн бүртгэсэн. Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/187 дугаар тушаалаар 14 нэр төрлийн 187,119.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй 187,119.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй тоног төхөөрөмжийг данс бүртгэлээс хасч акталсан.

### **Амгалан амаржих газар (3) (-1,463.0 сая)**

800.0 сая хөрөнгө акталсан, 540.0 сая төгрөгийн дуусаагүй барилга хасч бүртгэсэн, машин тоног төхөөрөмжийн тайлант хугацааны элэгдлийн зардал 1.3 тэрбум төгрөг болсон.

### **Ар. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-2,083.0 сая)**

Машин тоног төхөөрөмжийн балансын дүн 10 тэрбум төгрөг, тайлант хугацааны элэгдлийн зардал 2.3 тэрбум төгрөг болсон.

**Бө. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-1,607.7 сая)**

Элэгдэлийн зардал өссөн. Аймгийн ИТХ-ийн 2025 оны 09-р сарын 11 өдрийн 91-р тогтоолоор үндсэн хөрөнгө акталсан. Мөн ИТХ-ийн 2025 оны 09-р сарын 11-ний өдрийн 68-р тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн.

**Дд. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-1,509.3 сая)**

Дд. Аймгийн нэгдсэн эмнэлэг Элэгдлийн зардал өссөнтэй холбоотой буурсан.

**Дд. Баянтүмэн. Хүн эмнэлэг (-1,409.2 сая)**

Дд. Баянтүмэн. Хүн эмнэлэг Эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг давхардуулан бүртгэсэн. Өмнө авсан дүнгээ залруулга хийж шинэ дүнгээр нь данхин бүртгэж авсан.

**Өм. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-4,874.1 сая)**

1 тэрбум төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй бүртгэсэн, тайлант хугацааны элэгдлийн зардал 4.4 тэрбум төгрөг, 1.7 тэрбум төгрөгийн өмнө оны элэгдлийг аудитын явцад нөхөн байгуулсан байна.

**Сү. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-1,299.5 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**Сэ. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-2,528.9 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**Тө. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-1,398.9 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**УБ. Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв (-2,555.0 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**УБ. Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг (-1,365.8 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**УБ. Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв (-1,115.1 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**Халдварт өвчин судлалын үндэсний төв (-3,972.9 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**Хо. Аймгийн нэгдсэн эмнэлэг (-2,306.0 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэний төв - 2 (-5,022.9 сая)**

Машин тоног төхөөрөмжид эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгддэг ба тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр гардаг.

**Замын үүд чөлөөт бүс (-2,518.5 сая)**

Биет бус хөрөнгөд бүртгэлтэй зураг төсөвт хуримтлагдсан элэгдэл тооцож, өртөг бууруулсныг аудитаар илрүүлж залруулга хийгдсэн

#### **ОБЕГ - Агаараас эрэн хайх, аврах 111-р анги (-4,327.0 сая)**

Тайлант онд 795,799,615.42 төгрөгийн үндсэн хөрөнгийг шинээр хөрөнгөд бүртгэж, 283,307,897.58 төгрөгийг балансаас балансад шилжүүлсэн. Тайлант хугацааны нийт хөрөнгийн элэгдлийн дүн 4,839,491,043.70 төгрөг.

#### **ОБЕГ - Ар талын 115-р анги (-3,312.4 сая)**

Онцгой байдлын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар хүлээн авсан Төв орон нутгийн онцгой байдлын байгууллагуудад хувиараар олгох тоног төхөөрөмж багаж хэрэгслийн нөөцөөр нэмэгдсэн. Тайлант оны хөрөнгийн элэгдлийн дүнгээр буурсан.

#### **Төрийн үнэт цаас хэвлэл (-2,155.8 сая)**

Тухайн жилд хөрөнгө оруулалт буюу худалдан авалт хийгдээгүй бөгөөд санхүүгийн болон татварын жилээр үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн элэгдэл, хорогдлоор буурсан.

#### **Улаанбаатар. Улсын бүртгэлийн ерөнхий газар (-2,736.5 сая)**

Засгийн газрын 2025 оны 196 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн улсын бүртгэлийн газрын чиг үүргийг УБЕГ-т шилжүүлсэнтэй холбоотой үүссэн бууралт.

#### **Улаанбаатар. ШШҮТ - Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын харъяа Шүүхийн шинжилгээний алба (-7,827.6 сая)**

ЗДТГ болон ГХУСАЗСЗ-д албаны үйл ажиллагааг сайжруулах хүрээнд цахилгаан дугуй ашиглах боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мөн лабораторын техник хэрэгслээр хангах хүсэлт гаргасны дагуу нийт 66.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шийдвэрлүүлж, бэлтгэсэн. ТӨБЗГ-ын 2025.02.13-ны өдрийн “Хөрөнгө шилжүүлэх тухай” А-1/309 дүгээр албан бичиг - 1 нэрийн, нийт 4.6 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2025.12.23-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” А-1/2579 дүгээр албан бичиг - 3 нэрийн, нийт 20.2 сая төгрөг, ШШЕГ-ын даргын 2025.12.19-ний өдрийн “Хөрөнгө, бараа материал шилжүүлэх тухай” А/178 дугаар тушаал - 6 нэрийн, нийт 11.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэж авсан. Мөн тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр 17.9 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийг 10.5 сая төгрөгийн үнэ шинэчлэн тогтоосон. ТӨБЗГ-ын 2025.12.23-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” А-1/2579 дүгээр албан бичгийн дагуу 4 нэрийн нийт 191.1 сая төгрөгийн анхны өртөгтэй 59.4 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий авто-тээврийн хэрэгслийг ШШЕГ болон Говьсэмбэр баймгийн ШШХ-т балансаас балансад шилжүүлсэн. НШШГ-ын даргын 2024.12.04-ны өдрийн Б/14 дүгээр тушаалаар “Үнэлгээний хороо” байгуулагдсаны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан 135.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг худалдан авсан. Тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол шийдвэрийн дагуу байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 36 нэрийн 229.2 төгрөгийн хөрөнгийг акталж устгасан.

#### **Улсын бүртгэлийн ерөнхий газар (-5,968.8 сая)**

ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэх тогтоох тухай” 318 дугаар тогтоолоор 235,202.5 мянган төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож бүртгэсэн; ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай” 333 дугаар тогтоолоор 524.015.9 мянган төгрөгийн хөрөнгийг Гадаад харилцааны яам, Гадаадын иргэн харьяатын газарт болон харьяа нэгжүүдэд шилжүүлэн өгсөн; ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 338 дугаар тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 838,906.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэх тогтоох, балансаас балансад шилжүүлэх тухай” 363 дугаар тогтоолоор 286,817.9 мянган төгрөгийн хөрөнгийг Гадаад харилцааны яам, Дотоод хэргийн их сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт шилжүүлэн өгсөн байна. ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгө бүртгэх тухай” 418 дугаар тогтоолоор 211,350.0 мянган төгрөгийн хөрөнгийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шилжүүлэн авсан байна. ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэх тогтоох тухай” 816 дугаар тогтоолоор 1,662,528.9 мянган төгрөгийн төгрөгийн хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоож дансанд бүртгэсэн байна.

### **ЦЕГ - Захиргааны удирдлагын газар (-3,100.7 сая)**

Цагдаагийн байгууллагын бүтэцээр Гэмт хэрэг, зөрчил шалгах алба, Урьдчилан сэргийлэх албыг тусад салгаж төсөв захирагч болгосноор дээрх 2 албанд ашиглагдаж байсан үндсэн хөрөнгийг дагуулж шилжүүлэн өгсөн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу балансаас балансад шилжүүлсэн.

### **ЦЕГ - Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба (-1,333.5 сая)**

2025 онд байгуулсан элэгдлээр хөрөнгийн дүн буурсан

### **Хөтөлийн цемент шохоо (-5,933.0 сая)**

Шүүхийн шийдвэрээр 377,000.0 мянган төгрөгийн орон сууцыг барилга,байгууламжийн дансанд, 359,954.3 мянган төгрөгийн барилгын засварын ажлыг капиталжуулж, өөрийн хөрөнгөөр 6,415,572.7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж тайлант онд 12,875,984.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь биет хөрөнгө буурах шалтгаан болсон.

### **Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургууль (-10,695.1 сая)**

ТӨБЗГ-ын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А1/861 тоот тогтоолоор хөрөнгө акталж машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг данснаас хассан, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 236 тоот тогтоолоор үндсэн хөрөнгө акталж данснаас хассан, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 236 тоот тогтоолоор Орхон аймаг дахь Политехникийн коллеж-д 1 машин балансаас балансад шилжүүлсэн, 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 231 тоот тогтоолоор 3 машиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрлийн дагуу худалдан данснаас хасалт хийгдсэн байна. /тогтоолуудын мөнгөн дүн байна уу/

### **МБСБ - Дархан-Уул аймаг дахь Политехник коллеж (-1,245.0 сая)**

ТӨБЗГ-ын 2025 оны 11 сарын 28-ны өдрийн 623 тоот тогтоолоор хөрөнгө акталж данснаас хасалт хийгдэж, тайлант онд элэгдэлийн зардлаар буурсан байна. /тогтоолоор хэдэн төгрөгийн хөрөнгө акталсан бэ/

### **Монгол Улсын Боловсролын Их Сургууль (-1,620.0 сая)**

Ректорын тушаалын дагуу нийт 2,2 тэр бум төгрөгийн хөрөнгийг худалдан авсан. Тайлант онд барилга байгууламж дансанд 358.2 сая төгрөгийн капиталжуулалт, Дуусаагүй барилга байгууламж 106,6 сая төгрөг, Тээврийн хэрэгсэл дансанд 74.5 сая төгрөг, Машин тоног төхөөрөмжийн дансанд 1,1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт, Номын фондод 74.5 сая төгрөг, Тавилга, эд хогшлын дансанд 403.0 сая төгрөгийн тавилга эд хогшлын худалдан авалтыг тус тус бүртгэсэн. Үнэ төлбөргүй авсан 208.8 сая төгрөгийн хөрөнгө нь боловсролын ерөнхий газраас 46,7 сая төгрөгийн компьютер, ширээ сандал, хамтын ажиллагааны хүрээнд Өвөр монголын их сургуулиас 820.0 мянган төгрөгийн ном сурах бичиг, Боловсролын яамнаас 6.5 сая төгрөгийн зөөврийн компьютер, Азийн хөгжлийн банкнаас 12.5 сая төгрөгийн ширээ сандал, зөөврийн компьютер, Эрасмус төслөөс 129,1 сая төгрөгийн компьютер, МУБИС-ийн төв номын сангаас 2.2 сая төгрөгийн номыг Баян-Өлгийн багшийн сургуульд хандивласан, Ангилал хооронд 4.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг шилжүүлж данс бүртгэлд тус тус бүртгэж авсан. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 7 дугаар сарын 4 өдрийн 343 дугаар тогтоолоор Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрлийн дагуу барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, номын фонд, программ хангамжийн хөрөнгийг тус тус данс бүртгэлээс хассан.

### **Өмнөговь. Боловсролын газар (-1,588.5 сая)**

Өмнөговь аймгийн Даланзадгад суманд шинээр 6-р сургууль ашиглалтанд орсноор орон нутгаас олгосон үндсэн хөрөнгийг 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд орлого авсан ба аймгийн ИТХ-ын 2025оны 04 сарын 11-ний өдрийн 5/22 тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн хөрөнгөөр буурсан байна.

### **Сү. Баруун-Урт. Нэгдсэн дотуур байр (-1,989.8 сая)**

Сүхбаатар аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 1 дүгээр сарын 23-ны 03 дугаар тогтоолоор татан буугдаж Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн харьяанд шилжснээр балансаас балансад үндсэн хөрөнгийг шилжүүлсэн.

### **Тө. Зуунмод. Сургууль /1-р Хүмүүн, цогцолбор/ (-4,014.9 сая)**

Төв Зуунмод Хүмүүн цогцолбор сургуулийг Төв аймгийн Засаг даргын А/601 тоот захирамжаар татан буугдаж 1,2 дугаар сургууль болгон бүтэц зохион байгуулалтыг өөрчилсөн байна. Төв аймгийн засаг даргын захирамжаар батлагдсан ажлыг хэсэг Хүмүүн цогцолбор сургуулийн үндсэн хөрөнгө, биет хөрөнгийг тоолон тулган баталгаажуулж аймаг, сумын ИТХ-аар батлуулсан байна.

#### **Уб. Бх. Сургууль /Хангай, цогцолбор/ (-2,197.0 сая)**

Сургуулийн бүтэц өөрчлөгдөж 91, 94-р сургууль болж хуваагдсан. 94-р сургуульруу хөрөнгө шилжүүлсэн.

#### **Зам, тээврийн хөрөнгө оруулалт, их засвар (-373,841.7 сая)**

ТӨБЗГ-ын 2025 оны 796 дугаар тогтоолоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 4 нэрийн Дуусаагүй үйлдвэлэл данснаас Зам, гүүрийн байгууламж дансанд капиталжуулан бүртгэсэн.

#### **Иргэний нисэхийн ерөнхий газар (-239,226.9 сая)**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 04 дүгээр тогтоолоор Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрыг хэрэгжүүлэгч агентлаг гэж, Монгол улсын засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай 193 дүгээр тогтоолоор Агаарын навигаци, нисэх буудал, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ болон аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг хариуцан хэрэгжүүлэх "Иргэний нисэхийн үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг тус тус заасан. 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн дээрх газрууд Сангийн яамны Э-Баланс, finform дээр санхүүгийн тайланг тус тусдаа оруулсан. Өмнөх онд санхүүгийн нэгтгэсэн дүнгээр бэлтгэн боловсруулж оруулдаг байсан. 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс тус тусдаа оруулж байгаа тул өмнөх оноос буурсан.

#### **МИАТ (-10,828.8 сая)**

Үндсэн хөрөнгийг элэгдлийн графикайн дагуу элэгдлийн зардалд суулгаж байна.

#### **Өв.Хх. АЗЗА (-1,505.4 сая)**

20 АЗЗА ТӨХК-иудыг нэгтгэсэнтэй холбоотойгоор бүх үндсэн хөрөнгийг АЗЗА нэгтгэл ТӨХК-д шилжүүлсэн. Үүнтэй холбоотойгоор нэгдсэн нэг тайлан гаргаж салбаруудын хаалтын тайлан гаргасанаар хөрөнгүүд тэг үлдэгдэлтэй болж буурсан байна.

#### **Хөдөө аж ахуйн корпораци (-1,036.5 сая)**

Тайлант хугацааны элэгдлийн зардалаар буурсан байна.

#### **Дарханы дулааны цахилгаан станц (-4,138.0 сая)**

Барилга байгууламж 614 сая төгрөгийн капиталжуулалт хийгдэж 5185.9 сая төгрөгийн элэгдэл байгуулагдсан зөрүү 4574.9 сая төгрөг элэгдлээр хасагдсан. Машин тоног төхөөрөмж худалдаж авсан 803.4 сая төг, капиталжуулалт хийгдсэн 5710.6 сая төгрөг, улсын төсөв 442 сая төгрөг ба нийт элэгдэл 8430.7 сая төгрөг аклагдсан хөрөнгө 466.9 сая зөрүүгээр 1469.6 сая төгрөгийн хөрөнгө буурсан. компьютер, мэдээлэл боловсруулах худалдаж авсан 128.8 сая төгрөг, капиталжуулалт 52 сая төгрөг, акталсан хөрөнгө 25.1 сая төгрөг элэгдэл 459.4 сая төгрөг зөрүүгээр нь 278.5 сая төгрөгөөр хөрөнгө буурсан. Тээврийн хэрэгсэл худалдаж авсан 61.8 сая төг, акталсан нь 14.9 сая төгрөг, элэгдэл нь 212.8 сая төгрөг зөрүүгээр 151.0 сая төгрөгөөр хөрөнгө буурсан. Тавилга эд хогшил 82 сая хөрөнгө худалдаж авсан. ТЗБАХ-ний 2 ажил он дамжиж үргэлжилж байгаа тул дуусаагүй их засвар өссөн.

#### **Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц (-31,964.3 сая)**

Биет бус хөрөнгө 766.3 сая төгрөгөөр, хорогдол 341.9 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн.

#### **Дулааны хоёрдугаар цахилгаан станц (-1,312.3 сая)**

Тайлант онд 1,210.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсан. Мөн ТӨБЗГ-ын 2025 оны 398 дугаар тогтоолоор 101.8 сая төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан.

#### **Хөвсгөл дулааны станц (-1,056.1 сая)**

684.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 38.2 сая төгрөгийн хөрөнгө акталж, элэгдлийн зардал 1702.5 сая төгрөгөөр нэмэгдсэний зөрүүгээр үндсэн хөрөнгө 1056.1 сая төгрөгөөр буурсан байна.

#### **Дархан-Уул. Аймаг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар (-1,229.1 сая)**

Тус газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан Зулзагын гол зуслангийн барилга, байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга, аж ахуйн эд хогшлийг балансаас балансанд шилжүүлсэн.

#### **Мэдээлэл, холбооны сүлжээ ХХК (-6,345.7 сая)**

Хөрөнгө актлах, хуримтлагдсан элэгдэл, хорогдуулалтын дүнгээс шалтгаалж 6,345.73 сая төгрөгөөр буурсан.

#### **Радио телевизийн үндэсний сүлжээ ТӨҮГ (-1,426.9 сая)**

Цахим хөгжил, иноваци, харилцаа холбооны яамны хөрөнгө оруулалтаар 40.98 сая төгрөгийн хөрөнгө, өөрийн хөрөнгөөр 93.31 сая төгрөгийн үндсэн хөрөнгө орлогод авч, ТӨБЗГ-ын 2025 оны 12 сарын 26 өдрийн 898 дугаар тогтоолоор 141 999 723 төгрөгийн хөрөнгө актлагдаж мөн 1,588.54 сая төгрөгийн элэгдлийн зардлаар хөрөнгийн дүнд өөрчлөлт орсон,

#### **Ар. Хот тохижилт үйлчилгээний газар (-14,401.7 сая)**

2024 онд төсвийн байгууллага байсан ба 2025 онд ОНӨААТҮГ болон өөрчлөгдснөөр буурсан байна.

#### **Булганмээж (-1,220.1 сая)**

Булган мээж ОНӨХХК-ний 2025 онд үндсэн хөрөнгөнд тооцсон 1,750,914,743.99 төгрөгийн элэгдлийн зардал нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурахад нөлөөлсөн байна. Булган мээж ОНӨХХК 2025 онд нийт 531,632,619.03 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

#### **До. Сайншанд. Засаг даргын тамгын газар (-5,189.3 сая)**

Сайншанд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 сарын 24-ний өдрийн 04/02 дугаар тогтоол, 2025 оны 08 сарын 06-ны өдрийн 07/02 дугаар тогтоол 4 байгууллагад балансаас балансд хөрөнгө шилжүүлсэн.

#### **До. Сайншанд. Захирагчийн ажлын алба (-8,511.8 сая)**

Сайншанд хотын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02/06 дугаар тогтоолоор Сайншанд тохижилт үйлчилгээний газар болон Захирагчийн ажлын алба гэж бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэн. Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 04/02 дугаар тогтоолоор Сайншанд тохижилт үйлчилгээний газрын 8.5 тэрбум төгрөгийг хөрөнгийг балансаас балансд шилжүүлсэн.

#### **Өв. Хархорин. Засаг даргын тамгын газар (-1,253.8 сая)**

Биет хөрөнгийн эцсийн үлдэгдэл 16,921,887,316.44 төгрөг бөгөөд үүнд барилга байгууламж, орон сууц данс 90.73%, Авто тээврийн хэрэгсэл 1.97%, Машин тоног төхөөрөмж 2.63%, Тавилга эд хогшил 0.36%, Зам гүүрний байгууламж 0.026%, Бусад үндсэн хөрөнгө 4.24% эзэлж байна. Биет хөрөнгийн бууралтад элэгдлийн дүн нөлөөлсөн байна.

#### **Өм. Баяндалай. Засаг даргын тамгын газар (-2,853.6 сая)**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл болон эцсийн үлдэгдлийн зөрүү болох 2,853,279,056.02 төгрөг нь үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардал болон хуримтлагдсан элэгдлийн залруулга байна.

#### **Өм. Орон нутгийн өмчийн газар (-1,873.0 сая)**

Аймгийн ИТХ-ын тогтоолоор ашиглагч байгууллага руу шилжүүлсэн.

#### **Өм. Төрийн үйлчилгээний алба (-1,169.6 сая)**

Татан буугдсан.

#### **Таван толгой (-2,779.4 сая)**

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаар буурсан болно.

### **Цэмцгэр Өмнөговь ОНӨААТҮГ (-1,805.8 сая)**

Татан буугдсан.

### **Сэ. Ерөө. Засаг даргын тамгын газар (-1,131.8 сая)**

2024 онд дуусаагүй барилгаар бүртгэсэн байсан 6 хөрөнгийн үлдэгдэл санхүүжилтийг 2025 онд олгож дуусган, холбогдох байгууллагуудад нь шилжүүлэн өгсөн нь хөрөнгийн бууралтанд нөлөөлсөн.

### **Сэ. Орхонтуул. Засаг даргын тамгын газар (-6,201.9 сая)**

Үндсэн хөрөнгийн дуусаагүй барилга байгууламж дээр бүртгэлтэй байсан баригдаж буй гүүрийг 2025 оны аудитын тайлангийн шалгалтаар залруулж, бараа материалын бусад хангамжийн материалын дансанд шилжүүлэн бүртгэсэн.

### **Тохилгог Хараа ААТҮГ (-1,932.3 сая)**

2025 онд аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Хово машин 277.0 сая төгрөг, сумын хөрөнгө оруулалтаар хийгдсэн шахдаг ногоон машин 110.0 сая төгрөг, хог шатаадаг зуух 55.9 сая төгрөгөөр тус тус орлогод авч, зам гүүрийн байгууламжуудын элэгдлийн зардал өндөр тооцогдсоноос хуримтлагдсан элэгдэл 1,490.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хөрөнгийн бууралтад нөлөөлсөн.

### **Ув. Улаангом. Засаг даргын тамгын газар (-9,346.1 сая)**

Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь 19,1 тэрбум төгрөгийн зам гүүрийн байгууламжийн үндсэн хөрөнгийг УГТҮОНТҮГазарт, 61,0 сая төгрөгийн бусад хөрөнгийг /ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн ажил / цэцэрлэгүүдэд баланс хооронд шилжүүлсэн. Мөн хуучирсан зам гүүр, ногоон байгууламж, ашиглалтын хугацаа дууссан машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл тавилга эд хогшил зэрэг нийт 3,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан болно.

### **Шим-Ус (-1,753.5 сая)**

Алтай Зэрэг Мянгад сумдад шугам сүлжээ, ус татуургын хөрөнгийг аймгийн ИТХ-ын шийдвэрээр балансаас балансад шилжүүлсэн.

### **Хө. Хот тохижилт, үйлчилгээний газар (-3,215.7 сая)**

Хот тохижилт үйлчилгээний төв ХХК татан буугдаж Биет хөрөнгийг Аймгийн ИТХ-ын шийдвэрээр балансаас балансад сумын ЗДТГ-т шилжүүлсэн.

### **Хөдөөгийн шийдэл (-2,456.5 сая)**

2022 оны ОНӨГ-ын даргын тушаалаар Худалдан борлуулах зориулалттай хөрөнгийг Үндсэн хөрөнө дээрээ бүртгэсэн учир аудитын явцад залруулга хийн бараа материалын дансанд бүртгэсэн.

### **Шинэ мөрөн худалдааны төв (-5,192.1 сая)**

Барилга байгууламж шатаж улсын комиссын дүгнэлт гарч акталсан.

### **Хэ. Биндэр. Засаг даргын тамгын газар (-3,082.5 сая)**

2025 онд Их хуралдайн гадна тохижилт, шугам сүлжээ, зоорийн ажил, газрын хамт Чингис хаан музей руу СЯам шилжүүлсэн /2,966,012,556 төг/

### **Дархан орон нутгийн зам тээвэр (-5,352.9 сая)**

Аймгийн хэмжээний замын байгууламж автозам бүртгэлтэй байгаагаас ҮХ -ийн элэгдлийн зардлын дүнгээр хөрөнгө буурсан.

### **Дархан хотын тохижилт үйлчилгээний газар (-1,350.8 сая)**

Нийтийн эзэмшлийн зам байгууламжийн хөрөнгө ҮХ -ийн элэгдлийн зардлын дүнгээр хөрөнгө буурсан.

### **Дархан-Ус суваг (-4,319.2 сая)**

Мон төслийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалт нэмэгдсэнээс ҮХ -ийн элэгдлийн зардал өссөнөөм нийт хөрөнгө буурсан.

#### **Геодези, усны барилга байгууламжийн газар (-3,706.0 сая)**

803,508,833.63 -Үндсэн хөрөнгө шинээр худалдаж авсан. 3,537,496,198.38-Үнэ төлбөргүй шилжүүлж авсан. 62,519,746.34 -акталсан 7,984,523,560.19 -элэгдэлийн зардал

#### **Зорчигч тээвэр 1 (-1,679.8 сая)**

НӨХГ-ын 1/178 дугаар тогтоолын дагуу дахин үнэлж буурсан.

#### **Зорчигч тээвэр 4 (-3,300.0 сая)**

2025 онд Нийслэлийн засаг даргын тамгын газар луу шилжүүлсэн 10 ширхэг Ютонг маркийн автобусны үнэ 2,759,832,000 төгрөгөөр буурсантай холбоотой.

#### **Зорчигч тээвэр 5 (-3,028.6 сая)**

НЗДаргын захирамж, өөрийн хөрөнгөөр бий болсон нийт хөрөнгийн орлого 12,066.9 сая төгрөг, хасагдсан буюу шилжүүлсэн, акталсан, үнэ шинэчлэн тогтоосон 7,842.2 сая төгрөг зардал, элэгдлийн зардал 7,253.3 тус тус байна.

#### **Нийслэлийн төр захиргааны авто бааз (-2,760.0 сая)**

2025 онд нийт 722.1 сая төгрөгийн хөрөнгийг балансад бүртгэсэн, 8.15 сая төгрөгийн анхны үнэтэй 775.8 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг дансаас хасах, балансаас балансад шилжүүлэх хөдөлгөөн хийгдсэн. Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хөрөнгийн өсөлт гарсан.

#### **Уб. Бн. Засаг даргын тамгын газар (-1,233.5 сая)**

Тайлант хугацааны элэгдлээр ҮХ буурсан.

#### **Уб. Монгол наадам төслийн нэгж (-1,561.3 сая)**

Хөрөнгө буурсан нь элэгдэл тооцогдсоноос шалтгаалсан. Мөн НӨХГ-ын даргын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/706 тоот тушаалаар 198,007,247.81 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хууль журманд гийцүүлэн данс бүртгэлээс хассан.

#### **Уб. Мэдээлэл технологийн газар (-3,321.4 сая)**

Үндсэн хөрөнгийн бууралт нь Мэдээлэл технологийн газар (МТГ) татан буугдсантай холбоотойгоор хөрөнгийг НЗДТГ, ЗХУТ-т шилжүүлэн бүртгэснээс хасалт хийсэн. НӨХГ-ын шийдвэрээр ашиглалтын шаардлага хангахгүй үлдэх өртөгөө бүрэн нөхсөн хөрөнгүүдийг акталсан.

#### **Уб. Нийслэлийн Захирагчийн ажлын алба (-12,896.2 сая)**

2025 онд нийт 12,608,652.00 мянган төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгсэл дансанд бүртгэлтэй автомашины бүртгэлийг бусад эргэлтийн хөрөнгө дансанд шилжүүлж бүртгэсэн.

#### **Уб. Өмчийн харилцааны газар (-8,913.9 сая)**

НЗД-ын 2025 оны А/1849 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших Буянт-Ухаа 1 хорооллын 1,304,435.2 мянган төгрөгийн 23 орон сууцны төлбөрийг бүрэн төлж барагдуулсан иргэдэд шилжүүлэн өгсөн, НИТХ-ын 25/35 дугаар тогтоол, НЗД-ын 2025 оны А/483 дугаар захирамжаар Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших Сувилал сургалт эрдэм шинжилгээ, судалгааны төвийн 40,860.3 мянган төгрөгийн барилга акталсан, НИТХ-ын 2025 оны 25/27 дугаар тогтоол, НЗД-ын 2025 оны А/796 дугаар захирамжаар Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороонд байрлах Нийслэлийн соёлын төв өргөө Г корпусын 9,548,536.4 мянган төгрөгийн барилгыг Нийслэлийн соёлын төв өргөө ОНӨААТҮГ-т балансаас баланст шилжүүлсэн, НИТХ-ын 24/20 дугаар тогтоол, НЗД-ын 2025 оны А/87 дугаар захирамжаар Багахангай дүүргийн дүгээр хороонд байрлах 623,432.7 мянган төгрөгийн нийтийн орон сууцыг Нийслэлийн орон сууцны корпораци ХК-ийн баланст шилжүүлсэн, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2025 оны 07 дугаар тогтоолоор Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороонд байрлах 665,754.0 мянган төгрөгийн Нарны титэм Ж блок барилгыг нээлттэй дуудлага худалдаагаар борлуулсан, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2025 оны 03, 06 дугаар тогтоолоор БГД-ийн 14 дүгээр хороонд байрлах шуудангийн 24 дүгээр салбар байсан 124,296.1 мянган төгрөгийн барилгыг нээлттэй дуудлага худалдаагаар борлуулсантай тус тус холбоотой байна.

**Уб. Хот тохижилт, үйлчилгээний газар (-4,424.7 сая)**

Нийслэлийн ӨХГ-2025-12-30 №А/904 тоот тушаалаар 90,999,000.00 төгрөгийн үндсэн хөрөнгө дансаас хассан, Мөн өдрийн А/902 тоот тушаалаар 1,233,3337,350.42 төгрөгийн үндсэн хөрөнгө дансаас хассан, НИТХ-ын 2025оны 25/160 дугаар тогтоолоор 2,975,664,875.4 төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн, Нийслэлийн засаг даргын 2025/05/15-ны өдрийн А/684 тоот захирамжаар 2,018,939,559.56 төгрөгийн 15 тээврийн хэрэгсэл данснаас хассан.

**Уб. Ху. Засаг даргын тамгын газар (-1,178.9 сая)**

Биет хөрөнгө өөрчлөлт нь дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 12,763,091.3 мянган төгрөг, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 4,304,075.3 мянга нийт үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 17,067,166.68 мянган төгрөг, 2,5,6,21 хороод, 19 хорооны өрхийн эмнэлгийн байр, дүүргийн иргэдэд үйлчлэх төв байрны 9 давхарт шаардлагатай засварыг хийж, нийт 218,492.78 мянган төгрөгийн сайжруулалт, тайлант хугацаанд худалдан авсан 454,931.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус данс бүртгэлдээ тусгасан.

**Уб. Чи. Засаг даргын тамгын газар (-1,848.9 сая)**

Нийслэлийн өмчийн харилцааны газрын 816-р тогтоолоор акталсан барилга, машин тоног төхөөрөмж, зам гүүр гэсэн үндсэн хөрөнгөөр буурсан байна.

**Ор. Нийтлэг үйлчилгээний алба (-1,908.5 сая)**

Залуучуудын ордны барилга бүртгэлтэй байсаныг 2025 онд Орон нутгийн өмчийн газарт аймгийн Засаг даргын захирамжаар шилжүүлсэн.

**Ор. Орон нутгийн өмчийн алба (-28,429.5 сая)**

Дуусаагүй барилгаас Хөрөнгө оруулалтаар хийгдээд дууссан ажлуудын хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлсэн.

**Ор. Хот тохижуулах газар (-65,172.3 сая)**

Аймгийн шууд дээр нэгтгэгдэж байгаад Баян-Өндөр сумын төв. Захирагчийн тайланд шилжүүлсэн.

**Ор. Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар (-1,838.2 сая)**

Аймгийн шууд дээр нэгтгэгдэж байгаад Баян-Өндөр сумын төв. Захирагчийн тайланд шилжүүлсэн.

## Тодруулга №13 Биет бус хөрөнгө Биет бус хөрөнгийг цэвэр дүнгээр нь харуулбал:

/мянган төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Төсөвт байгууллага	Төсөл/Сан	Төрийн сан	ТӨҮГ болон ОНӨҮГ	Устгал	Нэгтгэсэн нийт дүн
1		Эхний үлдэгдлийн дүн	2,596,967,975.5	8,912,949.4	0.0	16,994,275,130.5	0.0	19,600,156,055.5
2		Эцсийн үлдэгдлийн дүн : Үүнээс	4,278,431,655.3	13,476,004.6	0.0	16,894,534,627	0	21,186,442,287
3	39301	1.2.2.03.01 Програм хангамж	308,013,028.2	16,703,503.6	0.0	165,075,617.7	0.0	489,792,149.5
4	39302	1.2.2.03.02 Хуримтлагдсан элэгдэл	-190,678,177.6	-7,934,071	0.0	-99,224,332.8	0.0	-297,836,581.5
5	39303	1.2.2.03.03 Бусад биет бус хөрөнгө	4,216,643,284.2	5,479,944.4	0.0	17,124,881,623.4	0	21,347,004,851.9
6	39304	1.2.2.03.04 Хуримтлагдсан элэгдэл	-55,546,479.4	-773,372.2	0.0	-296,198,281.2	0	-352,518,132.9

Тэмдэглэл.(Биет бус хөрөнгөтэй холбоотой тайлбар тэмдэглэлийг хийнэ.)

**.2.2.03 Биет бус хөрөнгө****ӨССӨН БАЙГУУЛЛАГУУД (11)****Зэвсэгт хүчний жанжин штаб (+1,917,424.2 сая)**

Холбогдох шийдвэрийг үндэслэн газрыг үнэлэн санхүүгийн тайланд бүртгэлд тусгасан.

**АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТЫН НЭГТГЭЛ (+6,352.0 сая)**

20 АЗЗА-ТӨХК-ийг 2025.04.11-ний өдөрөөр тасалбар болгон татварын ерөнхий газараас хасалтын картаар татан буулгаж тайлан балансыг албан ёсоор нэгтгэсэн. Биет бус хөрөнгийн өсөлт огцом өссөн байгаа нь 20 ТӨХК-тай баланс нэгдээгүй байсны эхний үлдэгдэл бөгөөд 20 сарбарын авлага нийлсэнээр өндөр өсөлттэй харагдаж байна.

**Иргэний нисэхийн үндэсний төв (+449,155.2 сая)**

ТӨБЗГ-ын 438 дугаар тогтоолоор газар эзэмших эрх хүлээн авсантай холбоотой өссөн.

**Монголын төмөр зам (+13,355.3 сая)**

ТӨБЗГ-н А-1/1764 тоот албан бичгийн хүрээнд 13. тэрбум төгрөгний 8ш цахилгаан эрчим хүч дамжуулах шугамын газар орлогод авснаар биет бус хөрөнгийн дүн нэмэгдсэн.

### **Дулааны гуравдугаар цахилгаан станц (+30,853.5 сая)**

Нийслэлийн засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 15-ний өдрийн А/45 тоот захирамжийн дагуу 1269 м.кв-аар газрын хэмжээг нэмэгдүүлсэн. ТӨБЗГ-ын 2025 оны 03 дугаар сарын 26-ний өдрийн А1/628 тоот албан бичгийн дагуу газар эзэмших эрхийн үнэлгээг шинэчлэх тогтоох ажлыг Мастер үнэлгээ ХХК-аар гүйцэтгүүлсэн. 1780913410 дугаар бүхий 424,337 м.кв газрыг “биет бус хөрөнгө газар эзэмших эрх” дансанд бүртгэж, газрын үнэлгээ 30,501,646.4 мян төгрөгөөр нэмэгдсэн.

### **Хөвсгөл дулааны станц (+8,091.1 сая)**

Биет бус хөрөнгө 8094.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 3.6 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж, хорогдол 0.2 сая төгрөгөөр нэмэгдсэний зөрүүгээр биет бус хөрөнгө 8091.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **Тө. Баян. Засаг даргын тамгын газар (+8,377.8 сая)**

шинээр 8 газар орлого авсан.

### **Тө. Зуунмод. Засаг даргын тамгын газар (+9,196.7 сая)**

Зуунмод сумын нийтийн эзэмшлийн 38 газрыг дахин үнэлээд 9.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн орлогдож авсан.

### **Уб. На. Засаг даргын тамгын газар (+78,497.5 сая)**

Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар нь 2025 онд 4,439,721 мкв 37 төрлийн газар эзэмших эрхийг бүртгэлд авч 102,705,619.4 мянган төгрөгөөр газар эзэмших эрх тайлант онд нэмэгдсэн. Дүүргийн Засаг даргын захирамжаар 2,932,392 мкв талбайтай Цэнгэлдэх хүрээлэн, наадмын талбайн зориулалт бүхий газрыг Засаг даргын Тамгын газарт 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэнийг бүртгэлд тусгасан. Тайлант онд 3 төрлийн зориулалт бүхий 24,207,937.5 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг шилжүүлж 78,497,681.10 мянган төгрөгөөр өссөн.

### **Ор. Баян-Өндөр. Засаг даргын тамгын газар (+11,857.0 сая)**

Шинэ байгуулагдсан багуудын эдэлбэр газрын эзэмших эрх 11.8 тэрбум төгрөгийг биет бус хөрөнгийг Аймгийн Засаг даргын захирамжаар шинээр бүртгэж авсан.

### **Ор. Баян-Өндөр. Хот тохижуулах газар (+15,862.1 сая)**

Өмнөх онд аймгийн шууд дээр нэгтгэгддэг байсан учраас Эхний үлдэгдэл нь аймгийн шууд дээр байгаа.

### **БУУРСАН БАЙГУУЛЛАГУУД (16)**

#### **Тагнуулын Ерөнхий газар (-3,626.1 сая)**

1,3 тэрбум төгрөгийн программ хангамж акталсан болон хуримтлагдсан элэгдлээр буурсан.

#### **Эрдэнэс таван толгой (-45,545.7 сая)**

Биет бус хөрөнгийн хорогдуулгатай холбоотойгоор биет бус хөрөнгийн дүн буурсан.

#### **Эрдэнэт үйлдвэр (-2,309.9 сая)**

Биет бус хөрөнгө нь тайлант хугацаанд байгуулсан хорогдлын хэмжээгээр буурсан байна.

### **Эрүүл мэндийн яам (-1,282.8 сая)**

Дата төвд байршдаг эрүүл мэндийн системийн программ хангамж бөгөөд 692.0 сая төгрөг тайлант хугацааны элдэгдлийн хасагдуулга, 590.0 сая төгрөг өмнө оны хасагдуулга тооцон бүртгэсэн.

### **Төрийн үнэт цаас хэвлэл (-1,910.5 сая)**

Тухайн жилд хөрөнгө оруулалт буюу худалдан авалт хийгдээгүй бөгөөд санхүүгийн болон татварын жилээр үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн элэгдэл, хорогдлоор буурсан.

### **Улсын бүртгэлийн ерөнхий газар (-2,384.0 сая)**

2025 оны 05 сарын 22-ны 260 дугаар тогтоол, 864 дүгээр тогтоол, 338 дугаар тогтоолуудын дагуу 2,384,001.3 мянган төгрөгийн програм хангамжийг акталж, данснаас хассан байна.

### **Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль (-1,711.2 сая)**

ТӨБЗГ-ын 2024 оны 07-р сарын сарын 19-ний өдрийн “Шинжлэх ухаан технологийн их сургуулийн газар болон үл хөдлөх хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн шалгалт тайлан”-гийн 7 дахь хэсгийн “Цаашид авах арга хэмжээний талаар”-ийн 15-т “Сургуулийн үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа газрын нэгж талбарын талбайн хэмжээний зөрүүг арилгаж, санхүүгийн тайланд тусгах” гэсний дагуу Атен үнэлгээ ХХК-иар 12 нэрийн газрын эзэмших эрхийн үнэлгээг дахин хийлгэсэн. ТӨБЗГ-ын 2025 оны 10-р сарын 24-ний өдрийн А1/2039 албан бичгийн дагуу 3 нэрийн газар эзэмших эрхийн үнэлгээг 533,999,160.00 төгрөгөөр нэмэгдүүлэн, 9 нэрийн газар эзэмших эрхийн үнэлгээг 1,290,405,710.00 төгрөгөөр бууруулж санхүүгийн тайланд тусгасан. Биет бус хөрөнгийн тайлант оны элэгдэл 1,230,791,166.13 төгрөгөөр буурсан байна.

### **Иргэний нисэхийн ерөнхий газар (-448,188.6 сая)**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 04 дүгээр тогтоолоор Зам,тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрыг хэрэгжүүлэгч агентлаг гэж, Монгол улсын засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай 193 дүгээр тогтоолоор Агаарын навигаци, нисэх буудал, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ болон аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг хариуцан хэрэгжүүлэх "Иргэний нисэхийн үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг тус тус заасан.2025 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн дээрх газрууд Сангийн яамны Э-Баланс, finform дээр санхүүгийн тайланг тус тусдаа оруулсан. Өмнөх онд санхүүгийн нэгтгэсэн дүнгээр бэлтгэн боловсруулж оруулдаг байсан.2025 оны 01 дүгээр сарын 01-нээс тус тусдаа оруулж байгаа тул өмнөх оноос буурсан.

### **МИАТ (-563,078.1 сая)**

Компани 2024 онд биет бус хөрөнгө дээр агаарын хөлгийн түрээсийн хөрөнгө ашиглах эрх дансныг нэмж бүртгэсэн бол 2025 онд залруулж биет бус хөрөнгийг дангаар нь бүртгэн залруулсан.

### **Алтай-Улиастайн эрчим хүчний систем (-1,428.7 сая)**

ТӨБЗГ-н 2025 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн 604 дугаар тогтоолоор 1,428.6 сая төгрөгийн үнэлгээтэй газрыг ЦДҮС ТӨХК-д шилжүүлсэн

### **Дулааны хоёрдугаар цахилгаан станц (-6,664.1 сая)**

ТӨБЗГ-ын 2025 оны 03 сарын 13-ны 122 дугаар тогтоолоор 6,658.5 сая төгрөгийн газрын эрх Нийслэлд шилжүүлсэн. ТӨБЗГ-ын 2025 оны 398 тогтоолоор 5.6 сая төгрөгийн биет бус хөрөнгө акталж данснаас хассан.

#### **Эгийн голын усан цахилгаан станц (-16,480.2 сая)**

Бусад биет бус хөрөнгө дансанд 2013-2024 онуудад хийгдсэн 16.4 тэрбум төгрөгийн 48 нэр төрлийн зардлуудыг хуримтлуулан бүртгэсэн байна. Аудитын хүрээнд судалгааны ажлуудаас түүвэрлэн биет бус хөрөнгийн шалгуур хангаж буй эсэхийг нягтлахад авто зам, гүүрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, ЦДАШ, дэд станцын нарийвчилсан зураг төсөл боловсруулах, Түүх соёлын дурсгалт зүйл /археологи/-ийн урьдчилсан хайгуул судалгааны зардал гэх мэт зардлууд нь НББОУС 38 "Биет бус хөрөнгө"-ийн шалгуур хангахгүй, цаашид хөрөнгийн өртөгт орох зардлуудыг бүртгэсэн байна. Аудитын дүгнэлтээр биет бус хөрөнгөөр бүртгэсэн бүртгэлийг бусад эргэлтийн бус хөрөнгөнд дансанд бүртгэж буурсан.

#### **Үндэсний дата төв /ЦХИХХС/ (-2,092.4 сая)**

ТӨБЗГ-ын 2025 оны 897 тоот тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 122 нэр төрлийн 3313 ширхэг лиценз, биет бус хөрөнгийг акталж, данснаас хассан.

#### **Таван толгой (-6,594.3 сая)**

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаар буурсан болно.

#### **Цант Орхон (-3,760.7 сая)**

2018 онд газрын суурь үнийн нэгж үнэлгээг андууран хэт өндөр үнэлсэн байсныг мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгүүлж, залруулга хийн 3,760.6 сая төгрөгөөр бууруулан үнэлж хөрөнгөнд бүртгэсэн нь хөрөнгийн бууралтанд нөлөөлсөн.

#### **Хэнтий-Ус (-5,235.7 сая)**

Тухайн тайлант онд биет бус хөрөнгөд бүртгэсэн байсан үндсэн хөрөнгийг дансыг засаж биет хөрөнгө дансанд бүртгэсэн.

## Тодруулга №14 Бусад хөрөнгө

/мянган төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Төсөвт байгууллага	Төсөл/Сан	Төрийн сан	ТӨҮГ болон ОНӨҮГ	Устгал	Нэгтгэсэн нийт дүн
1		Эхний үлдэгдлийн дүн	4,235,513.6	22,442,890.7	0.0	6,530,025,907.9	1,300,238,079.4	5,256,466,232.7
2		Эцсийн үлдэгдлийн дүн : Үүнээс	17,469,584.6	22,664,114.8	0.0	4,007,725,547.8	0	4,047,859,247.3
3	39401	1.2.2.04.01 Биологийн хөрөнгө /ТӨҮГ/	15,056,586.3	0.0	0.0	2,535,798.6	0.0	17,592,384.9
4	39402	1.2.2.04.02 Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/	0	0.0	0.0	185,547,468.4	0.0	185,547,468.4
5	39403	1.2.2.04.03 Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/	1,903,296.9	0.0	0.0	150,057,191.9	0.0	151,960,488.8
6	39404	1.2.2.04.04 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ТӨҮГ/	0	5,247,769.9	0.0	169,253,457.6	0.0	174,501,227.5
7	39405	1.2.2.04.05 Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + бусад	509,701.4	17,416,344.9	0.0	3,500,331,631.3	0	3,518,257,677.6

Тэмдэглэл.(Бусад хөрөнгийн талаар тайлбар тэмдэглэлийг хийнэ.)

## Тодруулга №15а Богино хугацаат өр төлбөр Санхүүгийн байдлын тайланд тусгасан өглөгийн үлдэгдэл нь дараах зүйлсээс бүрдэнэ:

/мянган төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Төсөвт байгууллага	Төсөл/Сан	Төрийн сан	ТӨҮГ болон ОНӨҮГ	Устгал	Нэгтгэсэн нийт дүн
1		Эхний үлдэгдлийн дүн	3,714,453,415.2	1,373,497,248	5,958,650,109.4	15,020,257,427.4	12,749,222,078.8	13,317,636,121.3
2		Эцсийн үлдэгдлийн дүн : Үүнээс	4,967,953,604.7	1,273,511,262.1	6,837,018,747.6	13,143,441,255.5	11,807,408,406.5	14,414,516,463.4
3	41100	2.1.1.01 Богино хугацаат үнэт цаас	0	0.0	138,956,769.9	0.0	0.0	138,956,769.9
4	41110	2.1.1.01.01 Төгрөг	0	0.0	138,956,769.9	0.0	0.0	138,956,769.9
5	41200	2.1.1.02 Богино хугацаат зээлийн өглөг	506,123.8	0	5,250,967,352.5	3,520,980,814.2	5,561,415,480.5	3,211,038,810
6	41210	2.1.1.02.01 Төгрөг	506,123.8	0.0	5,250,967,352.5	3,168,593,456.9	5,547,926,640.4	2,872,140,292.8
7	41211	2.1.1.02.01.01 Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	0	0.0	5,250,967,352.5	672,192,136.3	5,292,645,515.3	630,513,973.6
8	41212	2.1.1.02.01.02 Хувь хүмүүст олгосон зээл	305,238.9	0.0	0.0	1,520,136,018.6	0	1,520,441,257.4
9	41214	2.1.1.02.01.04 Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	0	0.0	0.0	274,937,676.3	117,507,143	157,430,533.3
10	41216	2.1.1.02.01.06 Арилжааны банк	0	0.0	0.0	311,419,296.4	137,773,982.1	173,645,314.3
11	41217	2.1.1.02.01.07 Санхүүгийн бусад байгууллага	200,885	0.0	0.0	389,908,329.2	0.0	390,109,214.2
12	41220	2.1.1.02.02 Гадаад валют	0	0	0	352,387,357.3	13,488,840.1	338,898,517.2
13	41224	2.1.1.02.02.04 Төслийн зээл	0	0	0.0	24,605,241.6	13,488,840.1	11,116,401.5
14	41225	2.1.1.02.02.05 Бусад гадаад эх үүсвэрээс	0	0.0	0	327,782,115.7	0.0	327,782,115.7
15	41300	2.1.1.03 Өглөг	4,831,397,156.6	1,113,454,493.8	1,414,171,371.9	6,375,495,334.1	6,193,867,777.2	7,540,650,579.2
16	41310	2.1.1.03.01 Ажилчидтай холбогдсон өглөг	78,275,756	145,314	0	99,738,454.2	5,600,533.7	172,558,990.4
17	41320	2.1.1.03.02 Бараа үйлчилгээний зардлын өглөг	119,813,485.9	971,407.1	2,471	397,390,000.8	1,747,018.6	516,430,346.2
18	41330	2.1.1.03.03 Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	678,415.7	198,781,337.3	30,286,431.3	0	175,880,053.6	53,866,130.7
19	41340	2.1.1.03.04 Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	149,726,088.9	8,999,943.4	0	1,010,731.4	112,439,884.4	47,296,879.3
20	41350	2.1.1.03.05 Зээлийн хүүгийн өглөг	51,141,677.4	54,609.9	350,305,064.8	280,514,640.8	7,597,093.5	674,418,899.3
21	41360	2.1.1.03.06 Бусад өглөг	4,431,761,732.8	904,501,882.1	1,033,577,404.7	5,596,841,507.1	5,890,603,193.4	6,076,079,333.2

22	41361	2.1.1.03.06.01 Байгууллагад төлөх өглөг	3,700,935,670.4	130,073,394.5	1,033,577,276.8	2,428,244,266.7	4,009,046,072.7	3,283,784,535.7
23	41362	2.1.1.03.06.02 Хувь хүмүүст төлөх өглөг	727,789,193.4	65,796,937.6	128	8,557,207	685,783,702.5	116,359,763.5
24	41363	2.1.1.03.06.03 Татварын өглөг /ТӨҮГ/	400,203.7	249,034.3	0.0	707,906,588.7	210,544.9	708,345,281.9
25	41364	2.1.1.03.06.04 НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	140,844.5	35,204.2	0.0	26,623,887.1	261,536.8	26,538,399
26	41365	2.1.1.03.06.05 Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/	0	0.0	0.0	42,488,274.7	0.0	42,488,274.7
27	41366	2.1.1.03.06.06 Дансны өглөг /ТӨҮГ/	2,495,820.8	708,347,311.4	0	2,331,636,725	1,195,301,336.6	1,847,178,520.6
28	41400	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	136,050,324.2	160,056,768.3	32,923,253.4	3,246,965,107.1	52,125,148.8	3,523,870,304.2
29	41410	2.1.1.04.01 Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	29,739,154.4	70,201,212.2	0.0	58,539,893.3	28,964,924.2	129,515,335.8
30	41420	2.1.1.04.02 Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	12,842,670.2	0.0	0.0	66,140,835.9	775,181.9	78,208,324.2
31	41430	2.1.1.04.03 Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	63,367,148.2	40,344,075.7	0.0	1,069,375.9	0.0	104,780,599.8
32	41440	2.1.1.04.04 Бусад урьдчилж орсон орлого	30,101,351.3	49,511,480.5	32,923,253.4	3,077,193,254.1	22,385,042.7	3,167,344,296.6
33	41450	2.1.1.04.05 Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар	0	0.0	0.0	44,021,747.8	0.0	44,021,747.8

## Тодруулга №156 Богино хугацаатай өр төлбөрийг байгууллагаар нь харуулбал:

/мянган төгрөгөөр/

№	Байгууллага /Шатлал 2, ТЕЗ, Шатлал 1/-ын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Архангай	680,671.3	2,139,899.1
2	Баян-Өлгий	6,728,573.5	10,401,864.5
3	Баянхонгор	10,159,312.5	8,103,796.4
4	Булган	8,865,111.9	10,751,504.1
5	Говь-Алтай	6,057,070.6	7,659,010.2
6	Дорноговь	29,065,699.3	66,480,435
7	Дорнод	5,195,446.9	10,295,060.6
8	Дундговь	3,846,812.3	6,314,185.8
9	Завхан	777,314.4	2,237,736.3
10	Өвөрхангай	3,796,517.2	5,055,425.1
11	Өмнөговь	322,502,310.2	380,613,646.6
12	Сүхбаатар	23,646,967.5	37,925,580.2
13	Сэлэнгэ	24,843,634.6	25,975,188.9
14	Төв	4,172,138.7	11,117,992.5
15	Увс	7,133,629.2	8,777,120.9
16	Ховд	16,788,467.7	13,522,359.5
17	Хөвсгөл	29,676,044.6	39,164,055.8
18	Хэнтий	29,716,592.1	71,218,885.1
19	Дархан-Уул	21,990,088.1	14,734,463.9
20	Улаанбаатар	290,405,496.2	322,070,165.4
21	Орхон	14,568,690.1	35,935,247.1
22	Говь сүмбэр	5,201,662	3,275,580.1
23	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	793.1	10,601.3
24	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	992,623.6	633,778.5
25	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	24,341,359.3	24,929,484.6
26	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	5,316,425,885.8	4,969,535,691.2
27	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	3,148,680.6	1,815,782.6
28	САНГИЙН САЙД	4,158,875,682.7	4,456,208,338.3
29	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	33,648,198	46,708,294.7
30	ТӨВ ТӨРИЙН САН	428,631,450.9	575,408,683.8
31	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	259,700,463.6	229,695,667.4
32	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	0.0	59.5
33	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	2,410,151.9	4,229,323
34	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	3,949,317.4	3,027,735.7
35	ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	54,759	6,072.3

36	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	2,343,688.2	3,119,230.9
37	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	1,973.7	24,384.2
38	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	455,693.5	324,058.9
39	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	19,325	228,093.1
40	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	67,727,954.4	7,304,674.8
41	СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	0.0	147,892
42	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	30,002.3	283,627.8
43	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	21,149,098.9	22,724,822.6
44	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	57,602,640.3	81,796,798
45	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	248,287,812.3	274,784,041.3
46	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	235,504,385.5	226,617,881.3
47	БОЛОВСРОЛЫН САЙД	161,189,618.5	122,502,961.4
48	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	486,081,175.7	918,216,339.9
49	АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД	40,598,518.5	39,544,297.7
50	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	131,742,291.4	261,604,115.6
51	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	306,679,060.6	563,247,164.4
52	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	18,914,846.7	21,554,723.5
53	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	4,500,646.4	10,524,211.5
54	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД, ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	168,791,383.9	222,547,022.2
55	ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	35,726,582.7	33,439,554.7
56	ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА	10,650	163,597.1
57	МОНГОЛ УЛСЫН САЙД, 20 МИНУТЫН ХОТ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	50,000,000	0.0
58	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	672	24,273.7
59	Эрүүл мэндийн даатгалын сан	85,119,984.8	50,176,818.4
60	Үндэсний баялгийн сан	0.0	342,566.2

Тэмдэглэл. (Богино хугацаат өр төлбөрийн талаар тайлбар, тэмдэглэл хийнэ.)

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 61,094.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 3,370.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт өр төлбөрийн 36,124.4 тэрбум төгрөг буюу 59.1 хувь нь төрийн сангийн, 23,162.2 тэрбум төгрөг буюу 37.9 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн, 1,368.8 тэрбум төгрөг буюу 2.3 хувь нь төсөвт байгууллагын, 438.7 тэрбум төгрөг буюу 0.7 хувь нь төсөл, сангийн санхүүжилтийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

Засгийн газар өрийн удирдлагын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлжээ. Тухайлбал,

- Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “Эс энд Пи” агентлагаас “В+ эерэг” байсныг “ВВ-, тогтвортой” түвшинд, Мүүдиз агентлагаас В2 тогтвортой түвшинд байсныг “В1, тогтвортой” түвшинд, “Фитч” агентлагаас “В+, тогтвортой” түвшинд хэвээр хадгалсан байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зээлийн эрсдэлийн ангиллыг шинэчлэн тогтоох уулзалтаар Монгол Улсын зээлийн эрсдэлийн үнэлгээг нэг шат ахиулжээ.

- Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн зорилтын 41-т заасны дагуу 2025 онд 148.7 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хоёр долоо хоног тутам Монголын хөрөнгийн бирж ХК-аар дамжуулан арилжаалсан.
- Тайлант онд “Сенчири-4” 6.625 хувийн хүүтэй 500 сая ам.долларын бондыг 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр олон улсын зах зээлд арилжаалж “Номад” бондоос 391.7 сая ам.доллар буюу 1,356.6 тэрбум төгрөг, “Сенчири-2” бондоос 108.3 сая ам.доллар буюу 374.9 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний үнэт цаасыг дахин санхүүжүүлсэн байна.

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2024 онд 33,399.9 тэрбум төгрөг болж, ДНБ-ий 41.8 хувьтай, 2025 онд 35,407.6 тэрбум төгрөг болж, ДНБ-ий 39.4 хувьтай тэнцэж байна.

Засгийн газрын өрийн үлдэгдэлд гадаад өр 33,868.6 тэрбум төгрөг буюу 95.7 хувийг, дотоод өр 1,373.3 тэрбум төгрөг буюу 3.9 хувийг, Засгийн газрын өрийн баталгаа 165.7 тэрбум төгрөг буюу 0.4 хувийг тус тус эзэлж байна.

## 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

### ӨССӨН БАЙГУУЛЛАГУУД (41)

#### Багануур (+83,276.2 сая)

Нийт өр төлбөрийн 89 хувийг БХӨТ эзэлж байгаа ба оны эхнээс 83,276.2 сая төгрөгөөр өссөн. Тайлант онд Татварын өр төлбөр 59,580.6 сая төгрөгөөр буурсан хэдий ч Богино хугацаат зээл 124,417.8 сая төгрөгөөр, зээлийн хүүгийн өглөг 8,585.1 сая төгрөгөөр, бэлтгэн нийлүүлэгч байгууллагад өгөх дансны өглөг 8,188.9 сая төгрөгөөр, урьдчилж орсон орлого 1,513.3 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой.

#### Дарханы төмөрлөгийн үйлдвэр (+30,844.5 сая)

Доор тайлбарласны дагуу Урьдчилж орсон орлого 168.7 тэрбум төгрөгөөр өсч, Өглөг 135.9 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн.

#### Монголрос цветмет (+44,013.3 сая)

Уул уурхайн бүтээгдэхүүнээ биржээр борлуулах хуулийн дагуу борлуулалт хийсэн даруйд төлбөрийг урьдчилан авч ачилтыг хийснээр борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрдөг учир энэ данс нэмэгдсэн болно.

#### Таван толгой төмөр зам (+58,105.7 сая)

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 21 дүгээр тогтоолын 2 дах заалт, Зам тээврийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 01/1646 дугаартай албан бичгээр Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр замын барилга угсралтын ажлын эхлэлтийн санхүүжилтэд дэмжлэг үзүүлхээр "Монголын төмөр зам" ТӨХК-тай 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн СГ-2025/01 тоот гэрээ, 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн СГ/2025/02 тоот гэрээний дагуу санхүүжилт олгох болсноос шалтгаал арилжааны банкуудад байршуулсан хугацаат хадгаламжуудыг барьцаалж зээл авсан шалтгаалж өглөг өссөн.

#### Шивээ овоо (+100,499.5 сая)

Богино хугацаат өр төлбөрийн данс нь 195,609.3 сая төгрөгт хүрч 79,689.5 сая төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд МУЗГ-ын 2025 оны 157 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Эрдэнэс Монгол ХХК-аас авсан 100.507.1 сая төгрөгийн зээл голлон нөлөөлсөн бөгөөд үүнээс гадна нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн өглөг 1,369.5 сая төгрөгөөр, урьдчилж орсон орлогын дүн 2,211.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн. Тайлант онд бэлтгэн нийлүүлэгч байгууллагад өгөх өглөг 8,989.5 сая төгрөгөөр, татварын өрийн үлдэгдэл 15,708.7 сая төгрөгөөр буурсан зэргээс мөн шалтгаалсан байна.

#### Эрдэнэс Монгол (+108,887.3 сая)

Эрдэнэс Тавантолгой ХК-аас ҮБС-д 2025 онд төвлөрүүлэх ёстой байсан ногдол ашгаас 96.5 тэрбум төгрөгийг 2026 он гарч төвлөрүүлсэн ба уг төлбөрийг 2025/12/31-ээрх СТ-д өр төлбөрөөр бүртгэсэн болно. Мөн компанийн

---

<sup>1</sup> Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна

санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгээр НӨАТ, ААНОАТ-ийн өглөг өмнөх оны мөн үеэс 13.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

### **Монголын хөрөнгийн бирж (+425,601.3 сая)**

Богино хугацаат өрт төлбөр ба 2.1.1.3 Өглөг - Монгол улсын "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай" хууль, Санхүүгийн зохицуулах хорооны "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа, төлбөр тооцоо хийх ерөнхий журам", Монголын хөрөнгийн бирж ХК-ийн "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам"-ын дагуу биржийн арилжаанд оролцогч нь арилжааны дэнчинг биржийн тусгай дансанд байршуулдаг. Арилжааны дэнчин нь биржийн дансанд гадаад валютаар байршдаг. Арилжааны дэнчинд байршиж буй 1,192,815,215,717.84 төгрөгийг Санхүү байдлын тайлангийн богино хугацаат өрт төлбөрийн хэсэгт УУБ-ны арилжааны дэнчинд байршиж буй мөнгө гэж тайлагнадаг ба тусгай дансны үлдэгдлийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд бүртгэдэг.

### **УБ хотын төлбөрийн чадварт нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл /3694/ (+13,405.3 сая)**

Богино хугацаат өрт төлбөрийн үлдэгдэл 13,405,270,225.46 төгрөгөөр өссөн нь: ■ Зөвлөх үйлчилгээний төлөгдөөгүй өрт төлбөр 2,022,762,211.54 төгрөг; ■ Барилга угсралт, гадна тохижилт, гадна инженерийн шугам сүлжээ, цахилгаан хангамжийн ажлын гэрээний дагуу ажлын гүйцэтгэлийн дүнгээс тооцож суутгасан чанарын баталгаа болон төлөгдөөгүй өрт төлбөрийн үлдэгдэл 10,558,512,984.52 төгрөг; ■ Барилга байгууламжийн ажлын захиалагчийн техникийн хяналтын үйлчилгээний төлөгдөөгүй өрт төлбөрийн үлдэгдэл 1,058,011,117.95 төгрөг; ■ Газар чөлөөлөлт ба нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговрын төлөгдөөгүй өрт төлбөрийн үлдэгдэл 3,687,428,413.9 төгрөг; ■ Нийлүүлсэн бараа, ажил үйлчилгээний төлөгдөөгүй өрт төлбөр 8,800,340.54 төгрөг; ■ Ажилчдын цалин хөлсний төлөгдөөгүй өрт 5,341,561.86 төгрөг; ■ 2025 оны 4 дүгээр улирлын хувь хүний орлогын албан татварын төлөгдөөгүй өрт 17,455,190.62 төгрөг; ■ 2025 оны 11 ба 12 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийн төлөгдөөгүй өрт 32,296,877.71 төгрөг; ■ Хувь хүмүүст өгөх төлөгдөөгүй өрт 15,776.92 төгрөг тус тус бүртгэгдсэнтэй холбоотой. Үүнээс: (1) 2025 онд төсөл хэрэгжүүлэх нэгжээс баталгаажиж Нийслэлийн засаг даргын Тамгын газар болон Сангийн яаманд хүргүүлсэн ч төсвийн хуваарилалт болон төлбөр баталгаажуулах үйл ажиллагаатай холбоотойгоор тайлант онд төлөгдөөгүй барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн төлбөр 4,758,089,237.03 төгрөг, барилга байгууламжийн ажлын захиалагчийн техникийн хяналтын төлбөр 961,828,289.01 төгрөг, газар чөлөөлөлт болон нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговрын 3,352,207,649 төгрөг зэрэг нь 2026 онд төлөгдөж эхэлсэн. (2) Барилга угсралт, гадна тохижилт, гадна инженерийн шугам сүлжээ, цахилгаан хангамжийн ажлын гэрээний дагуу ажлын гүйцэтгэлийн дүнгээс тооцож суутгасан чанарын баталгааны 5 хувь болох 4,134,289,409.15 төгрөг нь гэрээнд заагдсан хугацаа дууссаны дараа гүйцэтгэгчид төлөгдөнө. (3) Эко хорооллын ТЭЗҮ, хөгжил болон бодлогын шинэчлэлийн дэмжлэг, ажлын зургийн зөвлөх үйлчилгээний 2025 оны 3 дугаар улирлын төлбөр болох 173,406.59 ам.долларыг нэхэмжлэлийн дагуу гүйцэтгэгчид төлөхөөр санхүүжилтийн хүсэлтийг шууд төлбөрөөр Азийн хөгжлийн банк (АХБ)-нд хүргүүлсэн боловч АХБ-ны Уур амьсгалын Ногоон сангаас татан авсан эх үүсвэр дууссан тул санхүүжилт хүссэн төлбөрөөс 67,044.36 ам.долларыг шилжүүлж, 106,362.23 ам.долларын үлдэгдэлийг 2026 онд шилжүүлэхээр болсон. Мөн зөвлөх компанийн зүгээс 2025 оны 4 дүгээр улирлын төлбөрт 309,992.92 ам.долларыг нэхэмжилсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэх нэгжээс баталгаажсан боловч, дараагийн үе шатны төлбөр баталгаажуулах үйл ажиллагаатай холбоотойгоор тайлант онд төлөгдөөгүй бөгөөд тус төлбөрыг 2026 онд шилжүүлэхээр болсон. (4) 2025 оны 4 дүгээр улирлын хувь хүний орлогын албан татварын төлөгдөөгүй өрт 17,455,190.62 төгрөг болон 2025 оны 11 ба 12 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийн төлөгдөөгүй өрт 32,296,877.71 төгрөгийг тус тус 2026 онд төлсөн.

### **УБ хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл /МССан/ (+9,238.9 сая)**

2025/12/31-ний байдлаар хүлээн авсан ба төлөгдөөгүй нэхэмжлэхийн дүн.

### **Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл-ЕХОБ /FI-83097/ (+16,869.9 сая)**

Өр төлбөр дансны үлдэгдэл 55,643,168.7 мянган төгрөг болж, 16,869,891.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн төслийн үр дүнд бий болж байгаа дэд бүтэц, барилга байгууламж болон нийлүүлж байгаа бараа ажил үйлчилгээний гэрээний дүнгээс тооцсон баталгаа болон ажлын гүйцэтгэлийн төлөөгүй өглөгүүд голлон нөлөөлсөн.

#### **Үнэт цаасны хадгаламжийн төв (+27,526.2 сая)**

"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2024 оны 2,3-р ээлжийн ногдол ашгийн тараагдаагүй үлдэгдлээр харилцагчидад өгөх өглөг өссөн.

#### **Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл (+8,085.0 сая)**

УТХО-ын санхүүжилтээр шинээр БХЯ, ЗХЖШ-ын захиалгаар хэрэгжүүлж байгаа Ми-171Е нисдэг 1002 дугаартай тэрэгний их засвар, нисгэгчгүй нисэх төхөөрөмж, сумыг бэлтгэж, 2025 онд БХЯ, ЗХЖШ-т хүлээлгэн өгөөгүйгээс төслүүдийн урьдчилж орсон орлогын үлдэгдэл урьд оноос өссөн үзүүлэлттэй байна.

#### **Зэвсэгт хүчний жанжин штаб (+6,521.7 сая)**

Зэвсэгт хүчний 55 анги, 22 салбарын цалин татвар, нийгмийн даатгалын өглөг 7.1 тэрбум төгрөг, томилолын зардал 720.0 мянган төгрөг, 9 аанэгж байгууллагад хог хаягдлын 5.3 сая, 15 аанэгжид шуудан холбооны 210.3 саятөгрөг, 3 аанэгжид штм-ын 97.4 сая төгрөг, 1 аанэгжид 4.9 сая төгрөгийн хөдөлмөр хамгааллын хувцасны, 2аанэгжид хоол хүнсний 18.0 сая төгрөгийн, төмөр замын төсөлтэй холбоотой 961.8 сая, ЗХ-ний 5 анги нэгтэлтэй холбоотой газрын төлбөр 2 хувь хүнтэй холбоотой түрээсийн 57.8 сая төгрөгийн өглөгтэй.

#### **Улсын хоёрдугаар төв эмнэлэг (+8,029.4 сая)**

ЭМД-аас авах авлагатай хэдий ч байгууллага, хувь хүнд өгөх өглөгийг барагдуулах боломжгүй байгаа. Эмнэлгийн тусгай үйлчилгээний санхүүжилт 2025 онд орж ирээгүйгээс эмнэлгийн үйл ажиллагаа хүндрэлтэй байна.

#### **Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (+7,951.7 сая)**

ЭМД-аас авах авлагатай, бараа материалын өртэй байгаа. Санхүүжилт хүрэлцэхгүй байгаа.

#### **Хил хамгаалах ерөнхий газар (+12,488.8 сая)**

УТХО, НҮБ, Хөгжлийн хөтөч, Бүс нутгийн хөгжил төсөл, дуусаагүй үйлдвэрлэлээс шилжүүлэн авсан барилга 21,661.8 сая төгрөг, УТХО, санхүүгийн түрээсээр авсан нисдэг тэрэг, автомашин 51,592.2 сая төгрөг, ТӨБЗГ-ын н/07 тогтоолоор үнэ, хугацаа шинэчлэн тогтоосон бүртгэсэн.

#### **ШШГЕГ. Шийдвэр гүйцэтгэх газар/төлбөр/ (+1,252,286.9 сая)**

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн хүрээнд төлбөр авагч төлбөр төлөгчийн хоорондын тооцооноос үүссэн, өссөн.

#### **ЕБС-н гүйцэтгэл, үр дүнгээр олгох санхүүжилт (+6,007.7 сая)**

2025 оны 12 дугаар сард төрийн бус өмчийн 145 сургуульд олгосон санхүүжилтийн гүйлгээ буцсанаар тооцоо үүссэн.

#### **АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТЫН НЭГТГЭЛ (+25,659.8 сая)**

20 АЗЗА-ТӨХК-ийг 2025.04.11-ний өдөрөөр тасалбар болгон татварын ерөнхий газараас хасалтын картаар татан буулгаж тайлан балансыг албан ёсоор нэгтгэсэн. Богино хугацаат өр төлбөрийн өсөлт огцом өссөн байгаа нь 20 ТӨХК-тай баланс нэгдээгүй байсны эхний үлдэгдэл бөгөөд 20 сарбарын авлага нийлсэнээр өндөр өсөлттэй харагдаж байна.

#### **Монголын төмөр зам (+362,115.8 сая)**

1. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 21,86 дугаар тогтоолын дагуу БХХХ чиглэлийн салбар төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд ТТЗ ХХК-с 77.3 тэрбум төгрөгийн зээл, 2025 оны 132 дугаар тогтоолын дагуу төслийн санхүүжилтийн тодорхой хэсгийг бонд гаргаж шийдвэрлэх асуудлын хүрээнд дотоодын зах зээлээс 120.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосонтой холбоотойгоор байгууллагын 2025 оны өр, хүүгийн үзүүлэлт

өссөн. 2. БХХХ-ийн төслийн гүйцэтгэлийн өглөг 197.9 тэрбум төгрөгөөр өссөн. 3. Сангийн яамны зээлийн хүүгийн өглөг 19.2 тэрбум төгрөг, Бондын хүүгийн өглөг 1.3 тэрбум төгрөг, ТТТЗ ХХК-ийн зээлийн хүүгийн өглөг 4.7 тэрбум төгрөгөөр өссөн. 4. Чайна энержи нүүрс тээврийн 12-р сарын гүйцэтгэлийн өглөг, болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн өглөг 24.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

#### **Геологийн судалгаа-шинжилгээний төв ААТҮГ (+12,248.1 сая)**

Нийт 20,472.1 сая төгрөгийн өглөгөөс Улсын төсвийн санхүүжилтээр хийгдэж буй Агаарын геофизик-2024, 5 улсын төслийн санхүүжилттэй холобоотой өр, төлбөр-14,631.2 сая төгрөг буюу 71.9 хувь, мөн төслийн НӨАТ, ААНОАТ-ын суутгантай холбоотой өр нь 3,358.9 сая төгрөг буюу 17% -ийг эзэлж байна. Мөн 2026 онд хийгдэх ажилтай холбоотой өглөг 1,104,1 сая төгрөг болно. Үлдсэн 1,377.6 сая төгрөг буюу 7.2% нь үйл ажиллагаатай холбоотой ердийн өглөг юм. 2025 онд 110 аж ахуйн нэгжийн 981,2 сая төгрөг, 29 иргэний 3,8 сая төгрөг нийт 139 харилцагчийн 985,1 сая төгрөгийн шинжилгээний ажлын захиалга тавигдаж урьдчилж орсон орлогод бүртгэгдэж он дамжин хийгдэж байна. Үүнээс Оюу толгой ХХК нь нийт УОО-ын 30% буюу 291.0 сая төгрөг байна.

#### **ХХААХҮСайдын шууд (+142,491.0 сая)**

Сайдын хөтөлбөр арга хэмжээний санхүүжилт Урамшуулал /9,10,11 сар/- 25,100.3 сая төгрөг, Хөнгөлттэй зээлийн хүүгийн хөнгөлөлт /7,8,9,10,11 сар/ - 104,083.0 сая төгрөг, Сайдын хөтөлбөр арга хэмжээний бусад- 13,247.29 сая төгрөг /Үүнд: МАА-г хөгжүүлэх- 69.7 сая төг, ГТ-г хөгжүүлэх - 11,820.29, Хүнсний үйлдвэрлэл- 60.5 сая төгрөг, Хөнгөн үйлдвэрийн салбар- 93.4 сая төгрөг, Салбар дундын арга хэмжээ- 77.0 сая төгрөг, ХАА-н бодлого-337.1 сая төгрөг, ЖДҮ-ийг хөгжүүлэх хөтөлбөр- 789.4 сая төгрөг зэрэг арга хэмжээг 2025 оны эцсээр Ерөнхий сайдын 05 дугаар албан даалгаварын 1.4.5 дах заалын дагуу дараа онд санхүүжүүлэхээр тусгагдсаны дагуу үүссэн өр төлбөр.

#### **Амгалан дулааны станц (+10,974.1 сая)**

2025.12.31-ний өдрийн байдлаар төлөвлөгөөнд тусгагдаагүй 8,127.3 сая төгрөгийн борлуулалтын авлагатай, 31-ний өдрийн орой банк хаах үед харилцах дансанд төвлөрсөн 4,550.0 сая төгрөгийг өр төлбөрт шилжүүлэх боломжгүй байснаас өглөг өссөн.

#### **Дарханы дулааны цахилгаан станц (+10,201.0 сая)**

Еврогийн зээлийн бодит бус гарз, тарифын дутагдал, орлого төвлөрүүлэлт 5.6% тасарсантай холбоотой байна.

#### **Дорнод бүсийн эрчим хүчний систем (+7,802.7 сая)**

Дансны өглөг оны эхний үлдэгдлээс 6,180.1 сая төгрөгөөр өсч 27,230.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч байна. Дээрх өглөгийн 88.2 хувь буюу 24,006.4 сая төгрөг нь Төвийн эрчим хүчний системээс худалдан авсан цахилгаан эрчим хүчний өглөг эзэлж байна. /2025 онд Төвийн эрчим хүчний системээс 48.2 сая кВт/цаг цахилгаан эрчим хүч худалдан авсан/. Мөн 10.9 хувь буюу 2,955.9 сая төгрөг нь 12-р сард гэрээт бэлтгэн нийлүүлэгч компаниудаас худалдан авсан нүүрсний болон тээврийн хөлсний үнийн өглөг. /Гэрээний дагуу дараа сарын 15-ны дотор төлбөр хийгддэг Татварын өглөгийн үлдэгдэл оны эхний үлдэгдлээс 2,586.3 сая төгрөгөөр буурч 1,780.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч байна. Дээрх татварын өрийн 99.7 хувь буюу 1,776.0 сая төгрөг нь нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг, 0.3 хувь буюу 4.9 сая төгрөг нь суутган тооцсон татварын өглөг байна. - Нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татвараар өр төлбөргүй гарч байна. - Хүүний өглөг 4,939.3 сая төгрөг Хөгжлийн банкны зээлийн өглөг. - Урьдчилж орсон орлогын 2,016.6 сая төгрөг нь аж ахуйн нэгж байгууллагуудын цахилгаан эрчим хүчний урьдчилж төлсөн орлого байна.

#### **Дулааны гуравдугаар цахилгаан станц (+7,397.6 сая)**

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд бэлтгэн нийлүүлэгч байгууллагад өгөх 11,768,086.5 мянган төгрөгийн, татварын өглөг 1,503,880.5 мянган төгрөгийн, НББОУС-ын дагуу 2026 онд төлөх зээлийн үндсэн төлбөр болон хойшлогдсон хүүгийн төлбөрт төлөх 2,339,225.9 мянган төгрөгийг богино хугацаат өглөгт шилжүүлэн бүртгэсэн, урьдчилж орсон орлогын 3,703,510.6 мянган төгрөгийн, ажиллагсдын хоолны картын 125,138.8 мянган төгрөгийн, тэтгэвэрт гарсан болон бусад ажилтнуудад өгөх өр төлбөр 144,990.2 мянган төгрөг бүртгэлтэй байна. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагад өгөх өр төлбөр өмнөх оноос өссөн нь нүүрсний үнэ өссөнтэй холбоотой

Багануур ХК-д 2,704,534.7 мянган төгрөгийн өглөгтэй гарсантай. Урьдчилж орсон орлогын 98.5 хувь нь буюу 3,651,054.6 мянган төгрөг нь УБДС ТӨХК-д өгөх дулааны эрчим хүчний үнэ юм.

#### **Улаанбаатар дулааны сүлжээ (+9,893.0 сая)**

Богино хугацаат өр төлбөрийн 57 хувь буюу 8,126.9 сая төгрөгийг Амгалан ДС-аас ХАДЭХ-ний өр төлбөр, 28 хувийг УОО, 10.0 хувийг татварын өр, 5.0 хувийг бусад өр төлбөр эзэлж байна.

#### **Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ (+74,644.7 сая)**

Компанийн богино хугацаат өглөг 128,482.8 сая төгрөг байгаа бөгөөд үүний 69 хувийг /88,140.6 сая төгрөг/ ДҮТ ТӨХК-д төлөх ХАЦЭХ-ний өглөг эзлэж байна. ХАЦЭХ-ний үнэ нь оны эхнээс 79 хувийн өсөлттэй бөгөөд зөвхөн 11 дүгээр сарын нөлөөллийг авч үзвэл нэгж үнэ 43,81 төгрөгөөр нэмэгдсэнээр дансны өглөг 24,454.7 сая төгрөгөөр өссөн байна.

#### **Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ (+7,770.9 сая)**

Дээр дурдсан худалдан авагчийн авлагын нөлөөгөөр бэлтгэн нийлүүлэгчдийн төлөвлөгөөт ажлуудтай холбоотой өглөгийн хэмжээ өссөн.

#### **Эрдэнэтийн ДЦС (+51,014.2 сая)**

ДҮТ ХХК иас авлага өссөнтэй холбоотой мөн өргөтгөл орлогод авч бүртгэлд тусгасан боловч тарифт суугаагүй.

#### **Улаанбаатар. НДСан - УБ-Баянзүрх (+9,965.3 сая)**

Ажилгүйдлын даатгалын сангийн санхүүжилт хийгдээгүйгээс 2025 оны 10 сараас хойш олгох ажилгүйдлийн тэтгэмжийг олгоогүй учир хувь хүмүүст олгох өглөг нэмэгдсэн. Малчны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдээ асарч буй ээжийн сайн дурын даатгалын хамрагдалт бага байсан нь нөлөөлсөн байна.

#### **Дорноговь орон сууц ОНӨҮГ (+21,923.9 сая)**

Замын-үүд суманд Түрээслээд өмчлүүлэх орон сууц ашиглалтанд орсонтой холбоотой санхүүгийн түрээсийн өглөг, УОО нэмэгдсэн.

#### **Таван толгой (+56,522.6 сая)**

2025 оны тээвэр болон хөрс хуулалт, нүүрс ачиж буулгах зардлуудыг тайлант онд зардлаар тооцож өглөг үүсгэж бичилт хийгдсэн.

#### **Дөрвөлж (+6,356.0 сая)**

Дамжууланзээлээр баригдсан барилга байгууламжийг хөрөнгөд бүртгэх холбогдох байгууллагын шийдвэрийн дагуу ашиглагч байгууллагад зээлээр бүртгэсэн.

#### **Хэнтий-Ус (+45,035.4 сая)**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй ирсэн Бэрх станцын 15.0 тэрбум болон 1.2-р багийн шугам сүлжээний 29.4 тэрбумыг тайлант онд бүртгэж авсан

#### **Дархан-Уул барьцаа (+8,866.8 сая)**

УТЭШХО -ын гүйцэтгэлийн чанарын баталгааны дансны үлдэгдэл

#### **Нийслэлийн орон сууцны корпораци (+6,884.6 сая)**

Дансны өглөг дансны үлдэгдэл 833,190.2 мянган төгрөг болж 192,817.8 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны үлдэгдлээс “НОСК 2 ТЗК” ХХК-ийн дансны өглөг 630,411.5 мянган төгрөг, “НОСК 4 ТЗК” ХХК-ийн дансны өглөг 202,778.6 мянган төгрөгөөр өссөн, НОСК ХК-ийн дансны өглөг 8,712.0 мянган төгрөгөөр хасагдсанаас шалтгаалсан байна. Хүүгийн өглөг 711,090.4 мянган төгрөг Монгол банкны зээлийн хүүгийн өглөг байна. 2025 онд урьдчилж орсон орлого 2,848,692.3 мянган төгрөг болж өссөн нь НӨХГ-аас ирсэн өрхийн орон сууц газраар байраа сольсон 22 орон сууц борлуулсанаас үүссэн 2,844,692.3 мянган төгрөг нөлөөлж байна. Мөн хэрэгжээгүй НӨАТ өглөг 4,278,946.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн энэ нь түрээслээд өмчлөх хэлбэрийн 15 жилийн хугацаатай орон сууцны борлуулалттай холбоотой байна.

#### **Уб. Засаг дарга Ерөнхий данс (+34,818.8 сая)**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 17 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 201, 264, 265 дугаар тогтоолын дагуу гадаадын зах зээлд 500.0 сая ам доллар, дотоодын зах зээлд 1.0 их наяд төгрөгийн үнэт цаас гаргах зөвшөөрлийг авч дотоодын зах зээлээс 798.3 тэрбум, гадаадын зах зээлээс 1,712.5 тэрбум төгрөгийн бондын эх үүсвэрийг 2024 онд бүрдүүлсэн бөгөөд 2025 оны төсвийн жилд 115.5 тэрбум төгрөгийн бондыг эргэн төлж үлдэгдэл 2.461.7 тэрбум төгрөгийн бондын үлдэгдлээс тооцсон хуримтлагдсан хүүгийн үлдэгдэл 51.1 тэрбум төгрөг болж өмнөх оноос 34.8 тэрбум төгрөгөөр өссөн болно.

#### **Уб. Нийслэлийн Захирагчийн ажлын алба (+16,454.7 сая)**

2025 оны эхэнд барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэл 5,769,558.79 мянган төгрөг байсан ба Махны зээлийн хүүгийн өр болох 9,822.34 мянган төгрөгийг Сангийн Яаманд, Эс-Жи-Групп ХХК-д Сангийн яамны хоорондын тооцооноос үлдсэн 2,487.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2012 онд бэлтгэсэн нөөцийн махны Өвөрхангай аймгийн ЗДТГазар 11,239.2 төгрөг, Булган аймгийн ЗДТГ 104,000 мянган төгрөг нийт 115,239.2 төгрөгийг Нийслэлийн төрийн сангаас төлбөрийг төлсөн тул өглөгөөр бүртгэсэн байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар нэмэлт орлого болох зам талбайн сэтэлгээний ажлын орлого, авто замын хайс, хашлага болон ногоон байгууламж эвдэж сүйтгэсний хохирлын орлогод аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс барьцааны дансаар орсон орлогоор хийгдэх ажлын өр төлбөр үүссэн. Нийт барьцааны дансны үлдэгдэл 7,506,307.84 мянган төгрөг байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 14,717,928.64 мянган төгрөгийг байгууллагад төлөх өглөгөөр бүртгэсэн. Нийт 22,351,785.56 мянган төгрөгийн өглөгтэй байна.

#### **Уб. Орлого (+14,103.6 сая)**

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс "Улаанбаатар хотын орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл", Агаарын бохирдлыг бууруулах, цэвэр эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор гэр хорооллын дахин төлөвлөлтөд орох боломжгүй Баянзүрх дүүргийн 180 өрхийг шингэрүүлсэн хийн түлшний хэрэглээнд нэвтрүүлэх ажлын үлдэгдэл 15.2 тэрбум төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг 2025 оны төсвийн жилд татан төвлөрүүлснийг 2026 оны төсвийн жилд зарцуулахаар тооцоо үүсгэсэнтэй холбоотойгоор татаас санхүүжилтийн өглөгийн дүн нэмэгдсэн.

#### **Улаанбаатар смарт карт ХХК (+29,755.6 сая)**

2025 онд нийт 227,658,473,69 төгрөгийн өр төлбөр төлөгдөж, 630,666,783.68 төгрөгийн өглөг үүсэж, 278,503,425.80 төгрөгийн цэнэглэлтийн мөнгө урьдчилж орж ирсэн ба 2025 оны 12 сарын 31 өдрийн 1/2444 тоот Өмчийн харилцааны газраас ирсэн хөрөнгө бүртгэх тухай албан бичигт заасан 12,866,492,694 төгрөгийг урьдчилж орсон орлого дансанд бүртгэсэнтэй холбоотой өөрчлөлт байна.

#### **БУУРСАН БАЙГУУЛЛАГУУД (66)**

##### **Тагнуулын Ерөнхий газар (-2,611.8 сая)**

ЗГ-ын байгууллагуудын нэгдсэн цогцолбор барих цогц төслийн зөвлөх үйлчилгээний урьдчилгаа төлөгдөж, өглөг буурсан.

##### **Монголын газрын тос боловсруулах үйлдвэр (-99,674.3 сая)**

Барилгын ажлын гүйцэтгэлийн дүн нийт 175,6 тэрбум төгрөг төлсөнтэй холбоотойгоор өглөгийн дүн буурсан.

##### **Эрдэнэс алт ресурс (-47,880.9 сая)**

Татварын өр, урьдчилж орсон орлого буурсантай холбоотой богино хугацаат өглөг буурсан.

##### **Эрдэнэт үйлдвэр (-285,280.0 сая)**

Татварын өр, богино хугацаат зээлийн бууралтаас хамаарсан.

##### **Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл -2 /3679/-ТХН (-2,690.9 сая)**

Өглөгтэй гарын төлбөрийг тайлант онд төлсөн

##### **Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ, бэлэн байдлыг хангах төсөл-ТХН (-1,440.9 сая)**

Бараа үйлчилгээний гэрээний үлдэгдэ отөлбөр шилжүүлсэн.

### **Монголын үнэт цаасны клирингийн төв (-2,799.8 сая)**

МУ-ын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.2, 62.1.15 дахь заалт, "Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулах, шинэчлэх талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2025 оны 61 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Сангийн сайдын №228-р тушаалын дагуу "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК руу нэгтгэгдэх шийдвэр гарсан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 26-нд бүх харилцагч компаниуд руу барьцаа хөрөнгийг шилжүүлэн үлдсэн мөнгөн хөрөнгийг балансаас баланс руу шилжүүлсэн.

### **Сангийн яам (-4,816.9 сая)**

22 байгууллагын баталгаат чанарын 5 хувийн барьцаа чөлөөлсөн

### **Төрийн банк (-171,246.4 сая)**

Богино хугацаат үнэт цаас - 10.04 тэрбум, Богино хугацаат хадгаламж, харилцах - 144.96 тэрбум, бусдад өгөх өглөг - 16.25 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

### **УГЕГ - Гаалийн ерөнхий газар (-10,501.9 сая)**

Өр төлбөрийн буурсан шалтгаан нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын дагуу "Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэхээр гэрээ нь хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, санхүүжилт бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдэлийг захиалагчийн барьцаа дансанд байршуулах" гэж заасны дагуу 10,734.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2024 оны жилийн эцэст өглөг үүсгэн барьцаа дансанд байршуулан он дамжуулан 2025 онд гүйцэтгэлээр санхүүжүүлэн ажилласан.

### **Хилийн боомтын дэд бүтэц төсөл ( БНХАУ-ын тусламжын төсөл) (-11,723.7 сая)**

Байгууллагад төлөх өглөг дансны эхний үлдэгдэл 11,723,726,543.95 төгрөг нь 2025 онд БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын ажлын барьцаа хөрөнгийн дүн болох 4,591,172,614.93 төгрөгөөр нэмэгдэж, чанарын баталгааны хугацаа дуусаж барьцаа чөлөөлөгдсөнөөр 16,314,899,158.88 төгрөгийн дүнгээр хасагдаж тэг үлдэгдэлтэй болсон.

### **Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл /3895/-ТХН (-1,295.7 сая)**

Гүйцэтгэгчээс суутгасан барьцааг өглөгөөр бүртгэж 2025 онд гүйцэтгэгчид төгрөг төлсөн.

### **Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл-ТХН (-1,267.3 сая)**

Гүйцэтгэлийн тооцоог өглөгийн дансаар дамжуулж бүртгэж байсан байна. Үлдэгдэл 85 005 826.88 төгрөг нь Менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээтэй оршин суух бус гадаад байгууллагын олгох ёстой тооцооноос суутгаж авч НӨАТ-д шилжүүлэх тооцоо юм.

### **Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл-ТХН (-3,696.4 сая)**

Ашиглалтанд орсон сургуулийн барилгын гэрээнд заасан чанарын баталгаа чөлөөлсөн.

### **Цэргийн төв эмнэлэг (-1,595.9 сая)**

2024 оны жилийн эцэст байгууллагад төлөх өглөг 724,850.00 төгрөг, мэс заслын өндөр өртөгт мэс заслын хэрэгсэлд 754,731,558.00 төгрөг, эм,бэлдмэл эмнэлгийн хэрэгсэлд 1,639,059,637.70 төгрөгийн өглөгтэй гарсан бөгөөд 2025 онд оны эхний өглөгүүд бүрэн барагдаж дууссан. 2025 оны жилийн эцсийн өглөгийн үлдэгдэл нь эм, бэлдмэл эмнэлгийн хэрэгслийн тайлант оны өглөгийн үлдэгдэл бөгөөд ЭМДС-н санхүүжилттэй холбоотойгоор үүссэн өглөг болно.

### **УБ. Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг (-1,921.3 сая)**

ЭМД-аас авах авлагатай, бараа материалын өртэй байгаа

### **Улсын гуравдугаар төв эмнэлэг (-12,972.7 сая)**

Өглөгийг хэсэгчилэн шилжүүлснээр өглөг буурсан.

### **Улсын нэгдүгээр төв эмнэлэг (-12,640.5 сая)**

ЭМД-аас авах авлагатай, бараа материалын өртэй байгаа

#### **Хавдар судлалын үндэсний төв (-7,784.3 сая)**

ЭМД-аас авах авлагатай, бараа материалын өртэй байгаа. Төсвийн хэмнэлтийг үр ашигтай зохион байгуулснаар өглөг өмнө оноос буурсан.

#### **Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, их засвар (-37,471.3 сая)**

Барьцаа данснаас 13.9 тэрбум төгрөгийн гараагүй гүйцэтгэлийг Сангийн яаманд буцаан төвлөрүүлж, 2024 онд барьцаанд авсан 20.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг шилжүүлж, чанарын баталгааны хугацаа дууссан 4.4 тэрбум төгрөгийг гүйцэтгэгчид олгосон.

#### **Эрүүл мэндийн яам (-3,189.8 сая)**

Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтээр бэлтгэсэн түргэн тусламжийн автомашины мөнгийг төлж өглөг буурсан.

#### **Улаанбаатар. МУПЕГазар - Улаанбаатар, Нийслэлийн Прокурорын газар (-1,255.6 сая)**

Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 2025/ЦХШЗ/1269 дугаартай шүүгчийн захирамжаар 3.0 тэрбум төгрөг, 6 дугаар сарын 19-ны өдрийн 2025/ШЗ/1833 дугаартай шүүгчийн захирамжаар 100.0 сая төгрөг, 5 дугаар сарын 28ны өдрийн 1575 дугаар гүйцэтгэх хуудсаар 70.0 сая төгрөг нийт 3,170.0 сая төгрөгийн барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний мөнгийг буцаан шилжүүлсэн. Мөн шүүгчийн захирамж болон прокурорын тогтоолоор 1.9 сая төгрөгийн барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээний мөнгийг нэмж байршуулах шийдвэр гарснаар зэргээс үүдэн тус дансны үлдэгдэл буурсан байна.

#### **Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн - УТҮГ (-59,606.0 сая)**

2024.12.31-нд ЗГ-н тогтоолоор 60 тэрбум төгрөгийн төсөл хөтөлбөрийн санхүүжилт тус байгууллагын Барьцаа хөрөнгийн дансанд орж ирсэн. 2025 онд энэ санхүүжилтээс 20 төсөл арга хэмжээний санхүүжилт болох 6,883,787,200 төгрөгийн санхүүжилтийг олгож, гэрээ байгуулаагүй болон хугацаандаа санхүүжилт олгогдох боломжгүй 12 төсөл арга хэмжээний санхүүжилт 51,451,830,109.41 төгрөгийг улсын төсвийн орлогын дансанд буцаан төвлөрүүлж, чанарын баталгаа, Захиалагчийн хяналтын зардал болон Гүйцэтгэгчид өгөх санхүүжилт болох 1,664,382,690.69 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

#### **ОБЕГ-Улсын нөөцийн бараа бүрдүүлэлт сэлгэлт шинэчлэлт (-2,508.4 сая)**

Авлага МУ-ын ЗГ-ын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 22 дугаар хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу газрын тосны бүтээгдэхүүн импортлогч 5 аж ахуйн нэгж байгууллагад 3,400 тн 13,1 тэрбум төгрөгийн газрын тосны бүтээгдэхүүнийг улсын нөөцөд эргэн төлөгдөх, сэлгэн хадгалах богино хугацааны гэрээний үндсэн дээр олгож, авлагаар бүртгэсэн. Эргэн төлөгдөх гэрээний хэрэгжилт 80 гаруй хувийн гүйцэтгэлтэй байна. Өглөг МУ-ын ЗГ-ын 2025 оны 138 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд улсын нөөцөд нөхөн бүрдүүлсэн гэр, өвс тэжээлийн төлбөрийн үлдэгдэл бөгөөд өр төлбөрийг 2026 онд бүрэн барагдуулсан.

#### **Хилийн цэргийн 0119 дүгээр анги (-26,154.9 сая)**

Дансны өглөг 234,627.9 мянга, Богино хугацаат зээл 1,424,840.0 мянга, урьдчилж орсон орлого 26,802,572.7 мянган төгрөгөөр буурч, татварын өглөг 2,307,141.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бонгино хугацаат өр төлбөр 26,154,899.5 мянган төгрөгөөр буурсан.

#### **Хууль зүйн үндэсний хүрээлэн (-3,045.1 сая)**

ХЗҮХ-ийн өргөтгөлийн барилгын 2025 оны санхүүжилтийн өглөг 3,4 тэрбумийг олгож Хүрээлэнгийн барилгыг ашигланд тул өглөг буурсан.

#### **Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын хөрөнгө оруулалт, их засвар (-25,202.4 сая)**

2025 онд чанарын баталгааны хугацаа дууссан 87 компаний чанарын баталгаа болон хөрөнгө оруулалтын барьцааг чөлөөлсөн.

#### **БЕГ-Хөрөнгө оруулалт барьцаа (-41,059.4 сая)**

Тайлант онд 8,108,599,000 төгрөгийн барьцаа төвлөрч, 61 төсөл арга хэмжээний 9,898,156,100 төгрөгийн барьцаа хөрөнгийг чөлөөлөн, аудитын актын дагуу 3,209,275,6 төгрөгийг шилжүүлсэн, Засгийн газрын тогтоолын дагуу гүйцэтгэлээр 23,372,540,400 төгрөгийн ажил гүйлгээг хийсэн, 13,240,272,300 төгрөгийг Сангийн яамны улсын төсвийн дансанд төвлөрүүлж үлдэгдэл буурсан байна.

#### **Боловсролын салбарын хөрөнгө оруулалт, их засвар (-6,423.4 сая)**

Тайлант онд 250,014,306,900 төгрөгөөр өр төлбөр нэмэгдэж, 256,437,688,100 төгрөгөөр буурсан байна.

#### **БСШУСЯ. Барьцаа (-3,285.2 сая)**

Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын чанарын баталгааны төлбөрийг журмын дагуу тоног төхөөрөмж нийлүүлсэн байгууллагад шилжүүлснээр богино хугацаат өр төлбөр буурсан байна.

#### **Монгол Улсын Боловсролын Их Сургууль (-2,130.7 сая)**

Байгууллагад төлөх өглөг 92.1 сая төгрөг нь тендерийн гэрээний чанарын баталгааны 5 хувийн буцаалт, гаднын төсөл хөтөлбөрийн 733.9 сая төгрөг болон ректорын 2025 оны 12 сарын 26-ны өдрийн А/427 тоот тушаалаар урьдчилж орсон орлогыг орлогод хүлээн зөвшөөрснөөр буурсан байна. /тодорхой болгох/

#### **Хөдөө Аж Ахуйн Их Сургууль (-4,788.6 сая)**

Сургуулийн санхүүгийн хүндрэлээс үүссэн өр төлбөрийг барагдуулахад анхааран ажиллаж, хуримтлагдсан өр болох тэтгэвэртээ гарсан ажилдчын тэтгэмж, бусад урсгал өр төлбөрийг тайлант онд барагдуулан ажилласан байна.

#### **Зам, тээврийн хөрөнгө оруулалт, их засвар (-81,374.1 сая)**

Тус яамны Барьцаа баталгаа дансны үлдэгдлээр өглөг үүсч байгаа. Энэ нь оны эхэнд 147 байснаа оны эцэст 65 сая болж буурсан.

#### **Эрчис ойл (-14,660.6 сая)**

Эрчис ойл ХХК нь 14,639,066.3 мянган төгрөг байгаа нь аж ахуй нэгж байгууллагуудтай дизель түлш авч дансны өглөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

#### **Зээлийн батлан даалтын сан (-5,425.7 сая)**

СТОУС 9 дагуу бүртгэлд тусгасан.

#### **Хүнс хөдөө аж, ахуй, хөнгөн үйлдвэрийн ХО-ИЗ (-6,835.2 сая)**

